Улсын бүртгэлийн дугаар… Нууцын зэрэглэл **Б**

Аравтын бүрэн ангиллын код Төсөл хэрэгжүүлэх гэрээний дугаар

.........................

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

# АХМАД НАСТНЫ СОЦИАЛЬ АСУУДАЛ: ҮР ДАГАВАР, ТӨЛӨВ ХАНДЛАГА

СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2019-2022

**Төслийн удирдагч:** Б.Батхишиг, Бодлого судлал, улс төрийн эдийн засгийн ухааны салбарын эрхлэгч, академич, доктор (Sc.D)

**Санхүүжүүлэгч байгууллага:** Шинжлэх Ухаан Технологийн сан

**Захиалагч байгууллага:** Боловсрол, шинжлэх ухааны яам

**Тайлан өмчлөгч:** ШУА-ийн Философийн хүрээлэн

УЛААНБААТАР
2023 ОН

Улсын бүртгэлийн дугаар… Нууцын зэрэглэл **Б**

Аравтын бүрэн ангиллын код Төсөл хэрэгжүүлэх гэрээний дугаар

.........................

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

# АХМАД НАСТНЫ СОЦИАЛЬ АСУУДАЛ: ҮР ДАГАВАР, ТӨЛӨВ ХАНДЛАГА

СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2019-2022

**Төслийн удирдагч:** Б.Батхишиг, Бодлого судлал, элс төрийн эдийн засгийн ухааны салбарын эрхлэгч, академич, доктор (Sc.D)

**Санхүүжүүлэгч байгууллага:** Шинжлэх Ухаан Технологийн сан

**Захиалагч байгууллага:** Боловсрол, шинжлэх ухааны яам

**Тайлан өмчлөгч:** ШУА-ийн Философийн хүрээлэн

УЛААНБААТАР
2023 ОН

# РЕФЕРАТ

| | |
|---|---|
| **Тайлангийн нэр:** | Ахмад настны социаль асуудал: үр дагавар, төлөв хандлага |
| **Хуудас** | 159 |
| **Зурагт хуудасны тоо** | |
| **Тайлан бичсэн газар:** | Улаанбаатар хот, ШУА-ийн Философийн хүрээлэн |
| **Он** | 2023 |
| **Тайлан өмчлөгч:** | ШУА-ийн Философийн хүрээлэн |

## РЕФЕРАТ

Суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд ахмад настны социаль асуудлуудыг цогцоор нь судалж, ямар асуудлууд хамгийн ихээр доголдож байгаа, ямар асуудлуудыг нэн түрүүнд шийдвэрлэх шаардлагатайг тодруулж, тодорхой санал, зөвлөмж боловсруулах нь судалгааны ажлын гол зорилго байсан. Эл зорилгыг хэрэгжүүлэхээр дараах зорилтуудыг дэвшүүлж шийдвэрлэв. Үүнд:

1. Ахмад настны социаль асуудлыг насжилтын социологийн онол, арга зүйн үүднээс өөрийн орны онцлогт тохируулан судлах аргачлал, арга зүйг боловсруулж
2. Ахмад нас, ахмад настны талаарх ойлголт, бүлгийн дотоод мэдрэмж, уламжлал ба шинэчлэлийн ялгааг тодруулан
3. Ахмад настны социаль асуудлуудыг дээр тодорхойлсон асуудлын хүрээнд хувь хүн, бүлэг, нийгмийн түвшинд судлаж, тэтгэвэрт гарахаас өмнө ба дараах гарсан өөрчлөлтийг харьцуулан хоорондын уялдаа холбоо, харилцан хамаарлыг тогтоов.

Тоон судалгааны үндсэн мэдээллийг ажиглалт, анкет-сурвалжлагын аргаар, чанарын мэдээллийг экспертийн, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын аргаар цуглуулсан.

Анкет сурвалжлагын аргаар цуглуулсан мэдээллийг нийгмийн мэдээлэлд статистик боловсруулалт хийх орчин үеийн багц программ “SPSS-22”-ыг хэрэглэн боловсруулж, нэг болон олон хэмжээст тархалтаас гадна хүчин зүйлийн, хамаарах болон үл хамаарах хувьсагчдын шинжилгээ, хүчин зүйлсийн болон кластер шинжилгээ, индексийн арга, олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээ, график шинжилгээний аргыг ашиглаж судалгааны үр дүнг боловсруулсан.

Чанарын судалгааны мэдээллийг судалгааны зорилго, хэрэглэх аргачлалаас хамаарч контент анализ, уламжлалт шинжилгээний арга гэж хоёр ангилдаг. Уламжлалт шинжилгээний арга нь баримтын агуулга, утга санаан дахь уялдаа холбоо, зүй тогтлыг илрүүлэхэд илүүтэй анхаардаг. Анхдагч эх сурвалж буюу бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлага, экспертийн ярилцлагын мэдээллийг логик матрицын аргыг ашиглаж шинжилсэн. Чанарын мэдээлэл боловсруулах аргыг ашигласнаар нэгдүгээрт, текстийн утгыг тоон хэлбэрээр илэрхийлэх, хоёрдугаарт судалгаанд оролцогчдын илэрхийлж буй санаа,

тэдгээрийн хоорондох уялдаа холбоо, зүй тогтлыг илрүүлэх гэсэн давуу талыг олгодог.

Монголын ахмад настнуудын социаль асуудлыг цогцоор нь авч үзэж, өнөөгийн төлөв байдал, цаашдын чиг хандлагыг тодорхойлов.

Ахмад настны өмнө тулгамдаж буй социаль асуудлын учир шалтгаан, төлөв байдлын талаар судалгааны цогц өргөн мэдээлэл бүрдүүлж, ахмад настны амьдралын хэв маяг, амьжиргаа, хөдөлмөр эрхлэлтийн байдал, эрүүл мэнд, сэтгэл зүйн байдал, гэр бүл дэх үүрэг хариуцлага, харилцаа, нийгмийн оролцооны ерөнхий дүр зургийг тодорхойлж, нийгмийн асуудлын шалтгаан үр дагаврын харилцаа хамаарлыг шинжлэн судласан нь шинэлэг болсон.

Энэхүү суурь судалгаа нь ахмад настны социаль асуудлыг 1) амьжиргаа, 2) эрүүл мэнд, сэтгэл зүйн байдал, 3) ажил эрхлэлт, 4) нийгмийн амьдрал дахь оролцоо, нийгмийн капитал, 5) гэр бүл ба халамж, 6) тэтгэвэрт гарсны дараах дасан зохицолт, нийгмийн шилжилт, 7) нэр төр, аюулгүй байдал, 8) ахмадуудын талаарх төрийн бодлого гэсэн 8 чиглэлээр нарийвчлан судалж, судалгааны тайлан, санал зөвлөмжийг гаргасан бөгөөд судалгааны үр дүнд тулгуурлан ахмад настны социаль асуудлын төлөв байдал, үр дагавар, цаашдын хандлагыг шинжлэн тодорхойлсны дээр ахмадуудад тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг шийдвэрлэх гарц шийдлийн талаар санал зөвлөмж боловсруулав.

**Үндсэн ойлголт.** Ахмад настны амьдралын түвшин, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн капитал, харилцаа, нийгмийн оролцоо, сэтгэл зүй, эрүүл мэнд, эйджизм, нийгмийн шилжилт

## Гүйцэтгэгчдийн нэрийн жагсаалт

Баднаагийн Азбаяр, Философийн хүрээлэн, магистр. (III бүлэг 3.1, 3.2)

Батын Батхишиг, Философийн хүрээлэн, академич, доктор (Sc.D), профессор. (I бүлэг, XI бүлэг)

Оюуны Баасантогтох, Философийн хүрээлэн, доктор (Ph,D) (III бүлгийн 3.2, V бүлэг)

Жаргалсайханы Батжаргал, Философийн хүрээлэн, докторант (VI бүлэг, XI бүлэг)

Пандийн Бямбацэрэн, Монголын ахмадын холбоо, доктор (Ph.D), профессор. (II, XI бүлэг)

Т.Намжил, Монголын ахмадын холбоо, доктор (Sc.D), профессор. (VII бүлэг)

Даваадоржийн Номун-Эрдэнэ, Философийн хүрээлэн, докторант. (VIII бүлэг)

Цэвээний Цэцэнбилэг, Философийн хүрээлэн, доктор (Ph.D), дэд профессор. (IV бүлэг)

Ёндонгийн Ундрал, Философийн хүрээлэн, докторант. (IV бүлгийн 4.1, IX бүлэг)

П.Сүхбаатар, Монголын ахмадын холбоо, (X бүлэг)

Жаргалсайханы Пүрэвханд, Философийн хүрээлэн, магистр. (III бүлгийн 3.2-3.3, VII бүлэг)

## Гарчиг


Нэр томъёоны тайлбарлал ........ 8

Оршил........ 10

1.1. Суурь судалгааны үндэслэл........ 10
1.2. Судлагдсан байдал ........ 11
1.3. Судалгааны арга зүй, судлах асуудал........ 13
1.4. Судалгааны түүвэр, судалгааны зохион байгуулалт ........ 20

СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН АГУУЛГА........ 23

2.1 Ахмад настны талаарх бодлогын үр дүн, сорилт........ 23
2.2 Ахмад настны амьжиргааны асуудал ........ 24
2.3 Ахмад настны эрүүл мэнд, сэтгэл зүйн байдал........ 29
2.4 Ахмад настны хөдөлмөр эрхлэлт........ 31
2.5 Ахмад настны нийгмийн оролцоо........ 32
2.6 Ахмад настны гэр бүлийн анхаарал халамж........ 36
2.7 Ахмад настны нийгмийн шилжилт, дасан зохицол ........ 37
2.8 Ахмад настанд хандах хандлага ба ялгаварлан гадуурхалт ........ 40
2.9 Ахмад настны өнөөгийн байдал, нийгэмд эзлэх байр суурь, цаашдын хандлага........ 42
2.10 Судалгааны үр дүн ........ 47

Хавсралт 1........ 48

Хавсралт 2........ 51

## Нэр томъёоны тайлбарлал[1]

**Амьдралын чанар -** мах бодийн эрүүл мэнд, гэр бүл, боловсрол, ажил эрхлэлт, эд хөрөнгө, аюулгүй байдал, эрх чөлөөний баталгаа, шашны итгэл үнэмшил болон хүрээлэн буй орчин нь хувь хүний амьдралд эрсдэл учруулахгүй байх явдал юм

**Ангижрахын онол** – хөгшрөлтийн социологид хүмүүс хөгшрөхийн хэрээр залуустай улам хүнийсэж, хөгшчүүд гол төлөв хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбоо бүхий нийгмийн үүргээс сайн дураар ангижирч, амьдралаас хагацах гэсэн байдалтай болдог тухай төсөөлөл юм.

**Бүлэг –** Бие биетэйгээ тодорхой янзаар харилцан үйлчилдэг, бүлэгт хамаарагдаж байгаагаа мэдэрдэг, бусад нь тухайн бүлгийн гишүүн гэж хүлээн авдаг хэсэг хүмүүс.

**Геронтологи –** Нас хөгшрөлтийн тухай шинжлэх ухаан.

**Дахин нийгэмшилт** – Амьдралын шат бүхэндээ шинэ үүрэг, үнэт зүйл, мэдлэг олж авах үйл явц.

**Идэвхийн онол –** хүмүүс хөгшрөхдөө урьдын үүргээ гүйцэтгэж чадахгүй бол, алдсанаа мөн нийгэмд хэрэггүй болсноо мэдэрч, өөрийгөө хүндэтгэхгүй болдог тухай баримтлал. Энэ үзэл ёсоор настай хүмүүс хэдий чинээ идэвхтэй байвал тэдний сэтгэцийн байдал төдий чинээ сайн байна. (Н.Смелзер. Социологи. УБ., 2001. 608 дахь тал).

**Зохицох хандлага –** Насанд хүрэгсдийн амьдрал бол зохицвол зохих хэд хэдэн хямрал мөн гэж нийгэмшилтийг үзэх төсөөлөл.

**Наслалтын үүрэг** – наслалттай холбогдон хүлээгдэж буй бүхний цогц.

**Насны эрхт байдал** – Наслалтыг харгалзан бодгальд оноох нийгмийн байдал

**Нийгмийн сүлжээ -** тодорхой хувь хүмүүс болон хувь хүмүүсийн хоорондын нийгмийн харилцаа холбоо, нийгмийн холбоо хамаарлын цогц юм хэмээн тодорхойлжээ. ...Нийгмийн капиталын судалгаа нь нийгмийн сүлжээний онолтой шууд холбоотой. Энэ нь нийгмийн сүлжээ болж бүрэлдсэн цогц холбоо харилцааны функц хэмээн үздэг нийгмийн капиталын ойлголтоос үүсдэг юм. Сүлжээний онол нь нийгмийн капиталыг нийгмийн сүлжээнүүдийн үр нөлөө

[1] Н.Смелзер. Социологи. УБ., 2001. 608-621 дэх тал.

хэмээн үздэг бөгөөд нийгмийн капиталыг хуримтлуулах, нөхөн үйлдвэрлэх үйл явцыг судлахын тулд сүлжээний шинжилгээний зарчмуудыг нэвтрүүлдэг.

**Нийгмийн капитал -** нийгмийн бүтцийн шинж чанараас, тухайлбал, нийгмийн сүлжээний хаалттай/явцуу байдал/, нийгмийн харилцааны үргэлжлэх хугацаа, нийгмийн харилцааны олон талт байдлаас хамаардаг. Нийгмийн сүлжээний хаалттай явцуу байдал нь сүлжээний оролцогчид сүлжээний оролцогч биш бусад хүмүүстэй харилцахдаа харьцангуй бие даасан байдал (алслагдмал байдал)-тай байгаагаар нь илэрдэг. ...Нийгмийн сүлжээ харьцангуй тогтвортой буюу удаан хугацаанд хуримтлагддаг, харин сүлжээний оролцогчдын хоорондын харилцааны үргэлжлэх байдал нь нэг нийгмийн сүлжээнд хамаарах хувь хүмүүсийн харилцан итгэлийн өндөр түвшинг тодорхойлох хүчин зүйл юм. ...Нэг талаас, нийгмийн капитал бол нийгмийн сүлжээнүүдийн мөн чанар бөгөөд нөгөө талаас, нийгмийн холбоо харилцаа нь сүлжээний оролцогчдод нөөц ба бусад ашиг тусыг бий болгох боломжийг олгоход л илэрдэг.[2]

**Шилжих хөдөлгөөн -** хүн амын хэсэг нэг нийгмээс нөгөөд, нэг нийгмийн дотор, эсвэл хувь хүн бүлгийн статус өөрчлөгдөх үйл явц.

**Хамтын шилжих хөдөлгөөн -** нийгмийн үечлэлийн тогтолцоон дахь нийгмийн бүлгийн байдал өөрчлөгдөх хөдөлгөөн.

**Хөндлөн шилжих хөдөлгөөн -** нийгмийн эрхт байдлыг дээшлэх буюу доошлоход хүргэлгүй бодгалийн байдал өөрчлөгдөх.

**Тэгш бус байдал -** хүмүүс нийгмийн баялгаас жигд биш хүртэх байдал.

**Эгц шилжих хөдөлгөөн -** бодгаль хүний байдал түүний нийгмийн эрхт байдлыг дээшлүүлж эсвэл доошлуулж өөрчлөгдөх нь.

**Эйджизм** – Насны нэг буюу хэд хэдэн бүлгээс бусдын хувьд явуулж байгаа гадуурхал. Насны бусад бүлэгтэй харьцуулахад нам эрхэт байдалтай настангуудад хэрэглэхэд нэн тохиромжтой.

**Ялгаварлан гадуурхах -** цөөнхийн бүлгийн гишүүдийг муу гэгдэх шинжээр нь ялгаварлан шударга бусаар хандах явдал.

**Ялгарал -** хүний амьдрал ажиллагааг аар саар ажил, хязгаарлагдмал орон зай болгож хэсэглэхийг тэмдэглэхэд хэрэглэдэг.

---

[2] Попов Денис Дмитриевич. Социальный капитал в сетевых экономических структурах. https://cyberleninka.ru/article/n/sotsialnyy-kapital-v-setevyh-ekonomicheskih-strukturah

# I

## Оршил

### *1.1. Суурь судалгааны үндэслэл*

Дэлхийн хүн амд ахмад настны эзлэх хувь өсөх хандлагатай байгаа бөгөөд энэ нь эдийн засаг, нийгэм, хүн ам зүй, сэтгэл зүйн зэрэг олон асуудлыг дагуулах болжээ. Ийм ч учир 1991 онд НҮБ-аас Ахмад настны талаарх зарчим, 2002 онд Мадрид хотноо “Насжилтын талаарх олон улсын үйл ажиллагааны төлөвлөгөө” зэрэг баримт бичгийг батлан гаргасан. Үүнтэй холбогдуулан НҮБ-аас ахмад настны аж байдал, эрүүл мэнд чадамж, орчин нөхцөл гэсэн 4 бүлэг үзүүлэлтээр насжилтын индексийг жил бүр тооцож гаргах болжээ. 2015 онд уг индексийг тооцсон 96 орноос манай улс 37.4 гэсэн үзүүлэлтээр 72-т оржээ.

Сүүлийн жилүүдэд манай улсын хүн амын дотор ахмад настны эзлэх хувь өсөх хандлагатай байна.

Хүснэгт 1. Нийт хүн амд ахмад настны эзлэх хувь[3]

| *Ахмад настны тоо* | *1990 он* | *2000 он* | *2018 он* |
|---|---|---|---|
| 60-аас дээш настай хүн | 123 100 | 130 900 | 217 700 |
| 55-59 насны эмэгтэй хүн | 26 800 | 29 100 | 74 000 |
| Нийт ахмад настан | 149 900 | 160 000 | 291 700 |
| Нийт хүн амд ахмад настны эзлэх хувь | 7.3 % | 6.6 % | 9.15 % |

Судлаачдын үзэж байгаагаар нийт хүн амд ахмад настны эзлэх хувь 2030 онд 12.0%, 2050 онд 21.1% болох төлөвтэй байна.

Нийт ахмадуудын 16.7 хувь буюу 28.2 мянган ахмад настан амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхөд амьдарч, 3963 ахмад настан ганц бие, харж хандах ах дүүгүй, 7815 ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй хэвтэрт, 8.4 мянган ахмад настан бусдын байнгын асрамжинд байна.

Өндөр насны тэтгэвэр авагчдын 3.1 хувийг 500.0 мянган төгрөгөөс дээш тэтгэвэртэй хүмүүс эзэлж байгаагаас үзэхэд ихэнх ахмад настан буюу 97 хувь нь бага тэтгэвэртэй амьдарч, амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байна.

---

[3] Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2017, 36 дахь тал; Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2018, 36, 37 дахь тал,

Ахмад настны нийгмийн асуудлыг судалж ирсэн ч гэсэн түүнийг насжилтын социологийн онол, арга зүйн үүднээс иж бүрэн судлах, хоорондын хамаарал, шалтгаан үр дагаврын холбоог цогцоор нь авч үзэх, ахмадуудад тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замын талаар санал зөвлөмж боловсруулах, тодорхойлох нь нэн ач холбогдолтой юм.

### *1.2. Судлагдсан байдал*

Ахмад настанд холбогдох асуудлаар статистик болон социологийн судалгааны хэд хэдэн ажлууд хийгджээ. Үүнд:

Судлаач *Т.Баярцэцэг, Г.Намуунцэцэг нарын хийсэн "Ахмад настныг нийгмийн энтерпрайс үйл ажиллагаагаар идэвхжүүлэх боломжууд" сэдэвт судалгааны* ажил нь түүврийн хэмжээ харьцангуй бага, Улаанбаатар хотод хийснээрээ хүрээ нь хумигдмал байна. Насны ангиллын хувьд, ахмадууд гэдэгт 55-аас дээш насныхнаар төлөөлүүлсэн нь судалгааны ажлын хүрээнд харьцангуй хязгаарлагдмал байдлаар авч үзсэн бөгөөд Монголчуудын онцлог, олон улсын жишиг хандлагыг нарийвчлан судлаагүй. Өгүүлэлд, "Нийгмийн энтерпрайс" гэдэг нь нийгмийг хөгжүүлэх хүсэл зориг, ашгийн төлөөх бизнесийн үйл ажиллагаа хоёрыг сайтар уялдуулсан, инновацид тулгуурласан, нийгмийн чиг баримжаа бүхий бизнесийн үйл ажиллагаа юм хэмээн тодорхойлж нийгэмд тулгараад буй асуудлуудыг шийдвэрлэхэд зөвхөн засгийн газрын гарыг хараад суух бус харин тухайн орон нутгийн нөөц бололцоог олж илрүүлэн ашиглах орон нутгийн иргэдийг өөрсдийг нь үйл ажиллагаанд өргөнөөр татан оролцуулах чухал юм гэж тайлагнасан байдаг. Өөрөөр хэлбэл, судалгааны арга зүйн хувьд ахмадуудыг нийгмийн нөөц гэж үзэж байгаагаараа онцлог юм.  Өгүүллийн хувьд судалгааны ажлын зорилго, гаргаж тавьж буй асуудал нь шинэлэг бөгөөд судалгааны үр дүнд гарсан зарим үр дүнг харьцуулан судлах боломжтой юм.

*М.Ундармаа, М.Сугармаа нарын хийсэн "Ахмад настны асран хамгаалагчийн стресс"* сэдэвт судалгааны ажилд асран хамгаалагчдад тулгамдаж буй асуудал, стресс, түүний хэлбэр, гүнзгийрэлт, шалтгаан, шийдвэрлэх аргыг тодруулсан байна.

*Ахмад настны нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа” стастистик судалгаа 2018 онд хийгджээ. Уг судалгааны үр дүн нь ахмад настныг судлахад гол суурь судалгаа болж байгаагаараа ач холбогдолтой юм.* Монгол улсын нийт хүн ам 2017 онд 3.2 сая хүн болж, 2000-2017 онд 25.3 хувиар,

жилд дунджаар 5.6 хувиар нэмэгдсэн бол ахмад настан 331.3 мянган хүн болж 45.6 хувиар, жилд дунджаар 4.4 хувиар нэмэгдсэн бөгөөд нийт хүн амын 10.4 хувийг эзэлж байна. Нийт ахмад настны 2017 онд 140.6 мянга буюу 42.4 хувь нь эрэгтэйчүүд, 190.7 мянга буюу 57.6 хувь нь эмэгтэйчүүд байна[4]. Орчин үеийн нийгэмд ахмад настны нийгмийн байдал эртний уламжлалт соёлуудтай харьцуулахад тааруу байдаг. Уламжлалт нийгэмд өндөр нас нь нэр хүнд, эрх мэдэл, эд баялагт тооцогдож, ахмадууд нь нийтээрээ хүндэтгэл хүлээж, гэр бүлийн дотор тэргүүлэх байр суурь эзэлдэг бол орчин үеийн нийгэмд үүнтэй адилтгах зүйл үлдсэнгүй[5]. Ахмад настны асуудлуудыг социаль харилцааны талаас нь авч үзвэл ахимаг нас нь голдуу гарз хохирлын хугацаа байдаг. Ахимаг насны эрэгтэйчүүд, тэр дундаа хот суурин газар амьдрагсдын хувьд тэдний үйл ажиллагааг маш их хязгаарлана гэсэн айдас давамгайлдаг бол эмэгтэйчүүдийнх илүү төвөгтэй[6] Өндөр настны гэр бүлийн гишүүдэд эхнэр нөхөр хоёроос гадна үр хүүхэд, ач зээ, гуч, дөч, жич, тач багтана. Энэхүү гэр бүлд хамгийн хүндэтгэлтэйд эхнэр нөхөр буюу өвөө эмээ, элэнц хуланц тооцогдох бөгөөд 55-аас дээш насныхан байна. Өндөр настны гэр бүлийн хосууд тэтгэвэрт гарсан байдаг болоод нийгмийн идэвхтэй үйл ажиллагаанаас харьцангуй холддог. Ахмад настнууд хуримтлуулсан баялаг туршлага, арвин мэдлэг ухаанаараа үр хүүхэд, ач зээдээ дамжуулж байдаг. Өндөр настны гэр бүлд, залуу гэр бүлд тохиолддог бэрхшээлүүд тэр бүр байдаггүй боловч бэлэвсрэх магадлал өндөрсдөг[7] байна.

Манай судлаачдын хувьд ОХУ-ын ШУА-ийн Социологийн хүрээлэнгийн судлаачидтай хамтран 2014-2016 онд хэрэгжүүлсэн төслийн хүрээнд “Тэтгэврийн насныхан” судалгааг хийж, ахмадуудын амьжиргаа, эдийн засгийн болон бусад чадамж, нийгмийн үйлчилгээнд хамрагдах байдал, нийгмийн харилцаан дахь оролцоо, сэтгэл зүйн төлөв, нийгмийн капитал, нийгмийн сүлжээний асуудлыг шинжилсэн нь зохих ач холбогдолтой болсон. Мөн 2018-2019 онд НЗДТГ, Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын төрийн үйлчилгээний ардчилсан эгэх хариуцлагын үнэлгээ” төслийг хэрэгжүүлж, Нийслэлийн нийгмийн халамжийн газрын ажил үйлчилгээг үнэлэх хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн

[4] Ахмад настны нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа. ҮСХ. УБ., 2018. 4 дэх тал
[5] А.Гидденс. Социологи. УБ., 2006. 503 дахь тал.
[6] Мөн тэнд.
[7] Т.Бүрэнжаргал. Гэр бүлийн социологи. УБ., 2005. 118 дахь тал.

нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих цахим картын үйлчилгээ (2018), Ахмадын зориулалттай амралт сувиллын хөнгөлөлттэй үйлчилгээ (2018), Ахмад настны сэргээн засах үйлчилгээ (2018) гэсэн гурван судалгаа хийсэн.[8] Эдгээр судалгааны хүрээнд ахмад настнууд тухайн нийгмийн үйлчилгээнд хамрагдах явцад тулгарч буй асуудал бэрхшээлийг судалж, цаашид авах арга хэмжээг тодорхойлсны дээр нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдалтын талаар өргөн мэдээлэл цуглуулснаараа ач холбогдолтой болсон билээ.

Бид энэ удаад ахмад настны талаар үргэлжлүүлэн судлах, тэгэхдээ ахмад настны социаль асуудлууд гэдгийг тодотгож иж бүрэн авч шинжлэх, тэдгээрийн хоорондын хамаарал, шалтгаан үр дагаврын холбоог социологийн онол, арга зүйн үүднээс цогцод нь судлах, энэ үндсэн дээр ахмадуудад тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замын талаар санал зөвлөмж боловсруулах зорилго тавьж, энэхүү суурь судалгааны ажлыг Монголын ахмадын хороотой хамтран 2019 оны II хагаст эхлүүлсэн юм. Ахмад настны талаар урьд өмнө янз бүрийн байгууллага, судлаачид судалсаар ирсэн боловч социаль асуудлуудыг иж бүрэн авч үзэж, тэдгээрийн хоорондын хамаарал, харилцан нөлөөллийг тодорхойлсон ажил хангалтгүй байна. Иймд социологийн шинжлэх ухааны орчин үеийн онол, арга зүйг ашиглан ахмад настны социаль асуудлыг цогцод нь авч үзсэнээрээ онцлог болно.

### *1.3. Судалгааны арга зүй, судлах асуудал*

*Насжилтын талаарх ойлголт:* Насжилт нь олон хэмжээст үйл явц бөгөөд хүний амьдралын бараг бүх талуудад нөлөөлдөг. Jean Bourgeois Pichat (1979) ageing at base, ageing at apex гэсэн хоёр хэмжүүрийг гаргаж тавьсан. Суурьт насжих гэдэгт нийт хүн амын харьцаанд хүүхдийн тоо буурах үзэгдлийг хэлдэг бол оройд насжих гэдэг ойлголтод нийт хүн амын харьцаанд өндөр настнуудын тоо өсөхийг хэлнэ.

Hooyman, Kiyak (1994) хөгшрөлтийн он цагийн, биологийн, сэтгэл зүйн, нийгмийн гэсэн ерөнхий 4 хэмжүүрийг тодорхойлсон.

*Он цагийн насжилт:* Энэ нь хүний төрсөн цагаас эхлэх бөгөөд насны өөр өөр үечлэлд ялгаатай үүрэг, харилцаа холбоо, зан төлөв үүсдэг байна. Гэвч энэ

[8] Улаанбаатар хотын төрийн үйлчилгээний ардчилсан эгэх хариуцлагын үнэлгээ (Нийслэлийн нийгмийн халамжийн 3 үйлчилгээний ардчилсан эгэх хариуцлагын үнэлгээ). Судалгааны тайлан. НЗДТГ, ФСЭХ, АСДҮОУХ. УБ., 2018-2019.

нь тийм ч хангалттай хэмжигдэхүүн биш юм. Учир нь хувь хүн бүр өөр хоорондоо харилцан адилгүй үйл явцыг туулдаг.

*Биологийн насжилт:* (ихэвчлэн хөгшрөлтийн улмаас эс, организмын доройтлыг ойлгодог). Энэ нь цаг хугацааны явцад тохиолддог биологийн үйл явц нь физиологийн тогтолцоог тасралтгүй сааруулдаг. Ингэснээр организм өвчнийг тэсвэрлэх чадваргүй болж эцэст нь үхэлд хүргэх магдлалтай. Ихэвчлэн бие мах бодийн амин чухал эрхтний зохицуулалт, үйл ажиллагаа буурдагтай холбоотой. Гэхдээ хүн бүрийн физиологи, эрхтэн систем адилхан өөрчлөгддөггүй. Зарим 80 настай хүмүүс 60 настай хүнээс ч залуухан байдаг.

*Сэтгэлзүйн насжилт:* Энэ нь хувь хүний зан чанар, оюун санааны үйл ажиллагаа (Жнь: ой ухаан, суралцах, оюун ухаан) болон мэдрэхүйн ба ойлгох процессууд дээр гарч буй өөрчлөлтүүд дээр төвлөрдөг. Jegede (2003) сэтгэл зүйн насжилтын индекс мэдрэмж, сэдэл, санах ой, сэтгэл хөдлөл, туршлага, өөрийгөө танин мэдэхээс хамаардаг.

*Нийгмийн насжилт:* Хувь хүмүүс амьдралын өөр өөр үе шатуудаар дамжин өнгөрөхөд тэдний үүрэг, нийгмийн бусад гишүүд, бүлэгтэй харилцах харилцаа холбоо өөрчлөгдөж байдаг. Насжилтын социологид хувь хүмүүсийг нийгмийн харилцан холбоо, байр суурьтай холбон авч үздэг. Хүн настай болох нь хэрэглэж буй үг хэллэг, найз нөхдийн харилцаа холбоо, хувцаслалтын загвар, чөлөөт цагаа өнгөрүүлэх хэв маяг гэх мэтээр нэлээд өөрчлөгддөг. Өндөр настай хүн ямар байдаг талаар тогтсон хэм хэмжээ удирдаж байдаг. Хувь хүний туршлагаас харахад нийгмийн насжилт нь бидний хэн бэ гэдэг ойлголтод нөлөөлдөг. Ингэхдээ ахмад настнуудын үүрэг, байр суурь, зан үйлийн талаарх норматив хүлээлтээр нийгэм-соёлын орчин нөхцөлд дасан зохицох болдог.

*Ахмад настны нийгмийн ангийн асуудал:* Хөгшрөлт нь өөрөө тэдний амьдралын чанарыг өөрчилдөг гэсэн утгаараа нийгмийн ангид нөлөөлдөг чухал хүчин зүйл юм. Нийгмийн анги нь аль ч нийгэмд нийгмийн давхраажилтын систем дэх хувь хүмүүсийн эзлэж буй байр суурийг илэрхийлдэг чухал үзүүлэлт юм.

*Нийгмийн насжилтын шинж чанар:* Хувь хүмүүсийн гэр бүл, хамт олон, нийгэмд гүйцэтгэж буй үүргийн өөрчлөлтөд анхаардаг.

Strehler (1962) нь хөгшрөлтийн 4 шалгуурыг санал болгожээ. Тэдгээр нь:

1. Насжилт нь нийтлэг бөгөөд нийгмийн бүх гишүүдэд тохиолддог
2. Насжилт нь өсөн нэмэгддэг, тасралтгүй үйл явц юм
3. Насжилт нь организмд нөлөөлдөг

4. Насжилт нь доройтол юм

Насжилтын улмаас эрүүл мэндийн үйлчилгээний хомсдол, хүм амын өсөлт буурах, ядуурал-амьжиргааны түвшин буурах, нийгмийн халамжийн тогтолцооны хүртээмж, зардлыг нэмэгдүүлэх гэх мэт шаардлагыг бий болгодог.

Cavanaught (1993) in Osunde and Obiunu (2005) нар насжилтыг 3 түвшинд хуваасан байна. Үүнд:

1. Насжилтын өмнөх үе: Энэ нь өвчлөлтэй холбоогүй энгийн үйл явц гэж үздэг. Энэ нь биологи, нийгэм, сэтгэл зүйн хүрээнд энгийн өөрчлөлтөд оруулдаг.

2. Хоёрдогч насжилт: Энэ үйл явц нь хувь хүний энгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг өвчлөлийн олон төрөлтэй холбоотой.

3. Гуравдагч насжилт: Хувь хүний хэвийн үйл ажиллагааг аажмаар бууруулж болзошгүй гэр бүл, ойрын найз нөхдөд тохиолдсон үхэл, гамшиг, дайнтай холбоотой.

*Насжилтын олон төрөлт байдал:* Насжилт нэгдмэл бүлэг биш юм. Насжилт нь хэд хэдэн үеэс бүрдэх бөгөөд тэдгээр нь тус бүр өөрсдийн түүхтэй, амьдралын өөр өөр стандарттай, өөр өөр зан төлөвт хүргэх олон янзын үнэт зүйлтэй байдаг. Хөгжингүй орнуудад ахмад настнууд нь 3 буюу түүнээс олон ангилалд хуваагддаг.

1. Ахимаг: Энэ ангилалд 60-69 насны хөдөлмөрийн чадвараа хадгалж үлдсэн хүмүүсээс бүрдэнэ. 1990 онд Энэтхэгт 38-39 сая хүн энэ ангилалд багтаж байв.

2. Ахмад настан: 70-75 насны хүмүүс багтана.

3. Өндөр настан: 75-аас дээш насны ахмадууд багтах бөгөөд өндөр наслалттай холбоотойгоор бие махбодийн хувьд бүрэн чадвартай биш зарим талаар хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй байж болзошгүй.

4. Өтөл ахмад настан: 80-аас дээш насныхан энэ ангилалд хамаарна.

Үүнээс гадна ахмадуудыг 55-65 насных, 66-75 насных, 75 ба түүнээс дээш гэж 3 насны бүлэгт хуваасан судалгаа бий. Харин ДЭМБ-ын ангиллаар 60-74 насны ахмадуудыг ахимаг настнууд, 75-89 насны ахмадуудыг өндөр настнууд, 90-ээс дээш настнуудыг өтөл настнууд гэж үздэг байна.

Насжилтын үе шатаас хамаараад ахмадуудын хөдөлмөр эрхлэх боломж, амьдралын хэв маяг, эрүүл мэндийн байдал ялгардаг учраас судалгаанд насны ангилал чухал юм. Гэхдээ тэдгээр ангиллыг өөрийн орны хууль, хүн амын дундаж наслалт, ахмад настны онцлог, хүн амын бүтэц зэрэгтэй уялдуулан

өөрчлөхгүйгээр шууд авч хэрэглэх нь зохимжгүй юм. Тиймээс бид судалгаандаа *55-59 насны хүмүүсийг “ахимаг”, 60-64 насны хүмүүсийг “ахмад настан”, 65-69 насны ахмадуудыг “өндөр настан”, 70-аас дээш насны ахмадуудыг “өтөл ахмад настан”* хэмээн ангилан үзэж судална.

*Ахмад настны социаль асуудлууд гэж юу вэ?*

Юуны өмнө ахмад настны социаль асуудлууд гэж юу вэ, тэдгээрт ямар асуудлыг хамруулах вэ гэдгийг тодорхойлох нь судалгааны цаашдын явц, үр дүнд нэн чухал ач холбогдолтой юм. Яагаад энд заавал “социаль” гэсэн гадаад үг хэрэглэж байна, энэ нь ямар утгатай вэ гэдэгт ч бас хариу өгөх хэрэгтэй. Аливаа хүн нийгэмд амьдарч, нийгмийн харилцаанд оролцож, ингэснээрээ амьдралаа тэтгэж, өөрийгөө хөгжүүлж, улмаар үр хүүхэд, залуу хойч үеэ хүмүүжүүлж, нийгмийн нэр хүндтэй гишүүн болоход нь тусалж байдаг. Энэ үүднээс авч үзвэл социаль асуудлууд гэдэг нь хүмүүст нийгэмд, амьдрах, нийгмийн харилцаанд оролцоход учирч буй гол асуудлууд юм.

“Социологийн шинжлэх ухаан нь нийгмийн социаль харилцааг судалдаг бөгөөд ингэхдээ тухайн харилцааг төдийгүй, түүний субъектив илэрхийлэл, тусгал болох бие хүний нийгмийн учир холбогдол бүхий социаль хэрэгцээ, сонирхол, үнэт зүйлс, санал бодол, төсөөлөл, үзэл баримтлал, энэ социаль харилцаа явагдах нийгмийн орчин энэ харилцааны албан ёсны хийгээд бодит илрэл болох давхаргын чанартай элементүүдийг (гэр бүл, үйлдвэрлэлийн хамт олон, социаль бусад институтууд г.м) харилцан шүтэлцээнд нь судалдаг. Нийгмийн социаль харилцаа, түүний дээр дурьдсан объектив, субъектив илрэл нь хамтдаа нийгмийн социаль хүрээг бүрэлдүүлнэ”[9] гэж үздэг. Энэхүү судалгааны хүрээнд ахмад настныг бид нийгмийн нэг бүрэлдэхүүн хэсэг, үндсэн бүлэг болохынх нь хувьд нийгмийн бусад бүлгүүдтэй хэрхэн харилцаж, холбогдож байгаа, тухайн социаль харилцааны явцад нийгмийн микро, мезо, макро түвшинд ямар асуудал бэрхшээл тулгарч буйг авч үзэж байгаа учраас үүнийг тодотгож социаль асуудал хэмээн нэрлэж байгаа болно. Мөн социологийн шинжлэх ухаанд социальный (нийгмийн) гэдэг ойлголтыг общественный (нийгмийн) “нийгэм” гэсэн ерөнхий ойлголтоос ялгаж “цэвэр нийгмийн” гэж нэрлэж хэрэглэх нь ч бий. Социаль гэдэг ойлголтыг энэ ерөнхий нийгэм гэдэг ойлголтоос ялгаж ойлгож, авч

[9] Отгоннасан, В. (2016). Социологийн шинжлэх ухааны судлах зүйлийн асуудалд. МУИС. Эрдэм шинжилгээний бичиг. Социологи сэтгүүл. Улаанбаатар. 11-12 дахь талд. //https://catalog.num.edu.mn/journal/sots/sots2016-11/sots2016-11/assets/basic-html/page-12.html#

үзэхийн тулд нийгмийн асуудал хэмээн нэрлэхээс зайлсхийж социаль хэмээн нэрийдсэн болно.

Бидний судалгааны гол объект бол ахмад настнуудын социаль асуудлууд юм.

Хүн өсөлт, хөгжлийнхөө явцад нялх нярай, хүүхэд, өсвөр нас, насанд хүрсэн үе, ахмад нас гэсэн 5 үе шатыг дамждаг бөгөөд ахмад нас бол хүний хөгжлийн сүүлийн үе шат юм. Ийм ч учир ахмад настнууд хүн амын онцгой бүлэг бөгөөд тэдний аж амьдрал, ажил төрөл, эрүүл мэнд, сэтгэл санаа, нийгмийн идэвх оролцоо зэрэг олон хүрээнд үлэмж өөрчлөлт бий болдог. Тэд энэ үед олон төрлийн асуудалтай тулгардаг учир тэдгээрийг судалж, эргээр шийдвэрлэхэд туслах арга замыг хайх нь төрийн бодлогын салшгүй хэсэг байх ёстой.

Судлаач Jonhson ахмад настныг судалдаг эмпирик судалгаанд давамгайлдаг 5 үндсэн чиглэлийг гаргаж тавьсан. Үүнд:

1. *Өвчлөлийн судалгаа*. Эдгээр нь ихэвчлэн нийгэм, институтийн түвшинд өндөр настнуудын дунд тохиолддог нийгмийн, сэтгэцийн болон бие махбодийн хөгжлийн бэрхшээл, тархалтыг тодорхойлох зорилготой эпидемиологийн судалгаа юм. Ийм судалгааг үндэсний (Хант, 1978) болон орон нутгийн түвшинд (жишээ нь Бонд ба Карстэрс, 1982) явуулсан.

2. *Амьдралын чанар.* Эдгээр нь хөгшин хүмүүсийн хүрээлэн буй орчны янз бүрийн асуудал, тухайлбал барилга байгууламжийн хүртээмж, орон сууцны чанар, түүнтэй холбоотой талуудтай холбоотой байдаг. Эдгээр судалгааны дийлэнх хэсэг нь орон сууц, орон байр, орон сууцны байшинд төвлөрсөн байдаг (Willcocks, Peace and Kellaher, 1987).

3. *Хувийн харилцаа*. Энд гэр бүлийн харилцаа (Таунсенд, 1964), нөхөрлөлийн хэв маяг (Jerrome, 1990), нийгмээс тусгаарлагдах, ганцаардах, болон нийгмийн сүлжээнүүд (Венгер, 1983) хамаарах бөгөөд энэ талаарх эмпирик судалгаанууд хамгийн их анхаарал татдаг. Гэхдээ ахмад настнуудын гэр бүл, эсвэл хамт олонд оруулсан эерэг хувь нэмрийг бага анхаарч үздэг.

4. *Үйлчилгээг ашиглах.* Энэ чиглэл нь хөгшин хүмүүсийн хэрэглээ, хэрэгцээ, нийгмийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ, түүний зарим тодорхой үйлчилгээ, тухайлбал гэрээр хооллох, эсвэл хоол хүргэж өгөх зэргийг нарийвчлан тодорхойлсон байдаг.

5. *Тэтгэвэр ба хөдөлмөр эрхлэлт.* Энэ чиглэл нь тэтгэврийн хэмжээ, түүнийг өсгөх, тэтгэвэр тогтоох нас, эрт тэтгэвэрт гарах, хөдөлмөрийн зах зээл дээрх өндөр настай ажиллах хүчний хувь нэмэр зэргийг голчлон судалдаг.

Түүнчлэн социологит ахмад настнуудын талаар авч үзэхдээ ихэвчлэн хөгшрөлтийн танин мэдэхүйн үйл ажиллагаа, тэдний эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээл, санхүүгийн болон сэтгэл санааны байдал, ажиллах хүчний оролцоо, амьдрах орчин, нийгмийн харилцаа, шилжилт, хөгшрөлт ба хөгшин хүмүүсийн ойлголт, нийтийн нөөцийн хуваарилалт зэрэг сэдэвт анхаардаг байна.

Ахмадыг судалдаг ерөнхий 3 арга зүй байдаг. ***Нэгд,*** хөгшрөлтийг хувь хүний туршлага хэмээн үзэж нас ахих тутам хувь хүний үйл ажиллагаа, амьдралын чанар өөрчлөгддөг хэмээн үздэг. Эл үйл явц нь гэр бүлийн микро түвшнээс бүх л нийгмийн болон соёлын макро түвшний хүрээнд явагддаг байна. ***Хоёрт,*** хөгшрөлтийг тодорхойлдог нийгмийн нөхцөл байдлыг судалж, ахмад настны нийгэм дэх байр суурийг ойлгохыг эрмэлздэг. ***Гуравт,*** хэмжигдэхүүн нь хөгшрөлтийн нийгмийн үр дагаврыг шалгах явдал юм. Хүн амын насжилт, хүн ам зүйн бүтцийн өөрчлөлт нь бодлогын, ялангуяа эдийн засгийн талбарт нэлээд их асуудал үүсгэдэг. “Ахмадын настны социаль асуудал, төлөв, хандлага” судалгааны хүрээнд дээрх ерөнхий арга зүйг хослуулан хэрэглэнэ, мөн тоон болон чанарын судалгааны арга зүй, аргачлалыг хослуулна.

Бидний суурь судалгаа “Ахмад настны социаль асуудлууд, үр дагавар, төлөв хандлага” сэдэвтэй учир юуны өмнө ахмад настны социаль асуудлууд гэдэгт чухам ямар асуудлууд багтахыг онол, арга зүйн үүднээс тодорхойлох нь чухал. Үүнтэй холбогдсон баримт бичиг, судалгаа, шинжилгээний бүтээлүүдийг судалж үзэхэд олон янзын байр суурь харагдаж байна.

Тухайлбал, НҮБ-аас 1991 онд гаргасан “Ахмад настны талаарх зарчим”-д тэднийг ***Нэгд*,** Бие даан амьдрах нөхцөлөөр хангах /хүнс, орон сууц, хувцас, эмнэлгийн үйлчилгээ, орлого олох үйл ажиллагаа явуулах боломж, аюулгүй орчинд оршин суух, гэрийн нөхцөлд аль болох удаан амьдрах боломж, гэр бүл ба нийгмийн зүгээс харж хандах/, **Хоёрт,** Ахмадуудын нийгмийн амьдралд оролцох оролцоог сайжруулах, **Гуравт,** Ахмадуудыг харж хандах, хамгаалах, **Дөрөвт,** Ахмадууд өөрийн чадавхийг хөгжүүлэх, боловсрол, соёл, оюун санаа, амралт цэнгэлийн үйлчилгээ авах боломжийг өргөтгөх, **Тавд,** Ахмадуудын нэр төр, аюулгүй байдлыг хамгаалах, тэднийг аливаа ялгаварлан гадуурхах,

хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх явдлыг голлон анхаарч ажиллахыг гишүүн улсуудын Засгийн газруудад уриалжээ.[10]

АНУ-ын судлаач Карол Пардуе-Спеары тус улсын ахмадуудад тулгарч байгаа гол асуудалд 1. Биеийн болон сэтгэл санааны эрүүл мэнд; 2. Эрүүл мэндээ хамгаалах ба асран хамгаалуулах зардал; 3. Санхүүгийн аюулгүй байдал; 4. Үхэл хагацал тохиолдох; 5. Нийгмээс тусгаарлагдах; 6. Ганцаардал; 7. Хүчирхийлэлд өртөх зэрэг асуудлыг хамааруулж үзсэн байна.[11]

АНУ-д хийсэн өөр нэг судалгаанд ахмад настны социаль асуудлуудад 1. Гэр бүлийн асуудал; 2. Амьдралын нөхцөл /орон сууц/; 3. Мөнгө, санхүү; 4. Асрах, харах хүнтэй эсэх; 5. Өдөр тутмын үйл ажиллагаа; 6. Гэр бүлийн болон бусад хүчирхийлэлд өртдөг эсэх зэргийг оруулсан байна.[12]

ОХУ-ын судлаач О.В.Николаева 1. Эрүүл мэнд; 2. Материаллаг хангамж; 3. Хүмүүстэй харилцах асуудал; 4. Бусдаас хамааралгүй амьдрах; 5. Бусад хүмүүст хэрэгтэй, тустай байх; 6. Бусдын хүндэтгэл хүлээх; 7. Чөлөөт цагаа ашигтай, сонирхолтой өнгөрүүлэх боломж; 8. Тайван, амгалан байх; 9. Нийгэмд хүлээсэн үүргээ биелүүлсэн гэх мэдрэмж, бахархал зэргийг ахмадуудын гол социаль асуудлууд гэж үзжээ.[13]

Судлаач Т.Куприянова бичихдээ ахмадуудын социаль асуудлуудад 1. Материаллаг хангамж; 2. Орон сууцны нөхцөл; 3. Эрүүл мэндийн асуудал; 4. Эрүүл аж төрөх нөхцөл бололж, сурталчилгаа; 5. Сурсан мэдсэнээ нийгэмд зориулах нөхцөл, боломж /ажил эрхлэлт/; 6. Гэр бүлийн байдал, уур амьсгал; 7. Хүмүүстэй харилцах боломж; 8. Мэдээлэл авах боломж зэргийг хамааруулж үзжээ.[14]

Янз бүрийн санал, байр суурийг харьцуулан үзсэний үндсэн дээр бид ахмадын социаль асуудлуудыг дараах чиглэлээр судлалаа. Үүнд:

1. Амьжиргааны байдал-Гэр бүлийн нийт орлого, тэтгэврийн хэмжээ, орлогын бусад эх үүсвэр, орлогын хүрэлцээ, орон сууцны нөхцөл г.м.
2. Эрүүл мэндийн байдал-Эрүүл мэндийн асуудалтай эсэх, эмнэлгийн үйлчилгээ авах нөхцөл, боломж, эм, тариа авах зардал г.м.

---

[10] Principles for Older Persons, The General Assembly of the UN, 1991
[11] Carol Pardue-Spears, Common Problems Faced by the Elderly in the US, www.familymattershc.com
[12] Columbia University School of Social Work, Introduction to Social Issues Affecting Older People
[13] О.В.Николаева, Стиль жизни пенсионеров как социологичесзая проблема, Известия Саратовского университета, 2011, стр.11
[14] Т.Куприянова, Пожилой человек, его проблемы и их решение, www.fotoriter.ru

3. Ажил эрхлэлт -Ямар нэг ажил эрхэлдэг эсэх, ажил хийх хүсэлтэй эсэх, ажил олох боломжтой эсэх г.м.
4. Нийгмийн амьдрал дахь оролцоо- Нийгмийн амьдралд оролцох хүсэл сонирхол, нөхцөл, боломж, нам, улс төрийн шинжтэй байгууллагын үйл ажиллагаанд оролцдог эсэх, ямар нэг мэргэжил юмуу сонирхлын бүлэг, холбоо, клуб, хамт олны гишүүн эсэх, баг, хорооны хурал, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцдог эсэх, нийгмийн харилцааны байдал г.м.
5. Гэр бүл ба халамж, хамгаалал -Гэр бүлийн халамж, үр хүүхэд, ач, зээ нарын асуудал, нийгмийн зүгээс үзүүлэх анхаарал халамж
6. Тэтгэвэрт гарсны дараах дасан зохицолт, сэтгэл зүйн байдал-Тэтгэвэрт гарсны дараа санаа зовоож буй асуудал, ганцаардал, бусад хүмүүсийн харьцаа, хандлага өөрчлөгдсөн эсэх, өөртөө итгэх, өөртөө сэтгэл хангалуун байгаа эсэх
7. Нэр төр, аюулгүй байдал-Ахмад хүний хувьд ямар нэг хүчирхийлэл, гадуурхалт, доромжлолд өртөж байгаа эсэх
8. Тэтгэвэрт гарсны дараах амьдралын хэв маягийн өөрчлөлт-Амьдралын хэв маяг, түүнд гарсан өөрчлөлт, чөлөөт цагаараа гол төлөв хийдэг зүйл г.м.
9. Ахмадуудын талаарх төрийн бодлого - Ахмадын талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлогын үнэлгээ, төр засгаас ахмадуудын нийгмийн хамгааллын талаар авбал зохих арга хэмжээний талаарх санал

### 1.4. Судалгааны түүвэр, судалгааны зохион байгуулалт

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа олон шатат, санамсаргүй түүврийн аргыг хэрэглэсэн. Түүвэрлэлтийн *эхний шатанд* Монгол улсын газар нутгийн бүсчлэл, хүн амын харьцаанд үндэслэн баруун бүсээс Ховд аймгийг, хангайн бүсээс Хөвсгөл аймгийг, төвийн бүсээс Өмнөговь аймгийг, зүүн бүсээс Дорнод аймгийг, Улаанбаатар хотоос Багануур, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргээс мэдээлэл авч *хоёрдугаар шатанд* сонгогдсон аймгаас сумдын газар зүйн байршил буюу аймгийн төвөөс алслагдсан байдлыг харгалзан тус бүр хоёр сумыг сонгосон.

**Хүснэгт 1.1**. *Судалгаанд хамруулах аймаг, сум*

| № | *Аймаг* | *Сонгох сум-1* | *Сонгох сум-2* |
|---|---|---|---|
| 1 | Ховд | Дарви (2 тал = 414 км) | Мянгад (2 тал = 72 км) |
| 2 | Хөвсгөл | Чандмань-Өндөр (1 тал 178 км) | Тариалан (2 тал = 318 км) |
| 3 | Өмнөговь | Цогт-Овоо (2 тал = 240 км) | Ханбогд (2 тал = 522 км) |
| 4 | Дорнод | Халхгол (1 тал = 514 км) | Матад (1 тал = 547 км) |

*Гуравдугаар шатанд* Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 3.1-д “55 насанд хүрсэн эмэгтэй, 60 насанд хүрсэн эрэгтэйг ахмад настан”[15] гэж заасны дагуу тухайн аймаг суманд албан ёсны харъяалал бүхий ахмад настныг санамсаргүй аргаар сонгон судалгаанд хамруулсан. Мөн тэтгэвэрт хараахан гараагүй, удахгүй гарах нийт 70 респондентоос мэдээлэл авсан.

Судалгааны мэдээлэл цуглуулах 3 баг 2020, 2021 онд судалгааны удирдамжийн дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн, Тариалан, Чандмань-Өндөр сум, Ховд аймгийн Жаргалант, Мянгад, Дарви сум, Дорнод аймгийн Хэрлэн, Халхгол, Матад сум, Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Цогт-Овоо сум, Улаанбаатар хотын Хан-Уул, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх, Багануур дүүрэгт ажиллаж, нийт 836 хүнээс анкет-сурвалжлагын аргаар мэдээлэл авсан. Ганцаарчилсан ярилцлага-11, экспертийн ярилцлага-10, фокус бүлгийн ярилцлага-6, нэмэлт-2 ярилцлага, нийт 29 ярилцлага хийж, тэмдэглэл хөтлөв.

*Судалгаанд оролцогчдын нийгэм хүн ам зүйн дүр зураг*

Судалгаанд хамрагдсан ахмад настнуудын 26.7% нь дээд боловсролтой, 41.5% нь бүрэн болон тусгай дунд боловсролтой байв. Харин хотын ахмадуудын 32.7% нь, хөдөөгийн ахмадуудын 11.4% нь дээд боловсролтой байв. *(Хүснэгт 1.2).*

*Хүснэгт 1.2. Ахмад настны нийгэм хүн ам зүйн үзүүлэлт*

| | N(%) | Mean | SD | Хот(%) | Хөдөө(%) |
|---|---|---|---|---|---|
| **Нас** | **-** | **63,5** | **6,34** | **-** | **-** |
| ▪ 55-59 (ахимаг) | 35,6 | | | 34,9 | 37,6 |
| ▪ 60-64(ахмад) | 27,3 | | | 27,7 | 26,2 |
| ▪ 65-69 (өндөр) | 22,1 | | | 21,4 | 24,1 |
| ▪ 70-аас дээш (өтөл) | 15,0 | | | 16,0 | 12,2 |
| **Хүйс** | **-** | **1,58** | **0,49** | **-** | **-** |
| ▪ Эрэгтэй | 41,5 | | | 41,4 | 41,8 |
| ▪ Эмэгтэй | 58,5 | | | 58,6 | 58,2 |
| **Оршин суугаа газар** | - | **1,28** | **0,45** | - | - |
| ▪ Хот | 71,7 | | | | |
| ▪ Хөдөө | 28,3 | | | | |
| **Гэрлэлтийн байдал** | - | **2,06** | **1,42** | - | - |
| ▪ Гэрлэсэн | 63,5 | | | 61,9 | 67,5 |
| ▪ Гэрлээгүй | 1,1 | | | 0,7 | 2,1 |
| ▪ Салсан | 3,2 | | | 3,5 | 2,5 |

[15] Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль // www.legalinfo.mn //2019.10.01

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| ▪ Бэлбэсэн | 30,9 | | | 32,4 | 27,0 |
| ▪ Хамтран амьдрагчтай | 1,3 | | | 1,5 | 0,8 |
| **Боловсролын түвшин** | - | **4,28** | **1,34** | - | - |
| ▪ Боловсролгүй | 1,1 | | | 0,7 | 2,1 |
| ▪ Бага боловсролтой | 8,4 | | | 4,8 | 17,3 |
| ▪ Бүрэн бус дунд | 22,4 | | | 17,7 | 34,2 |
| ▪ Бүрэн дунд | 24,6 | | | 25,7 | 21,9 |
| ▪ Тусгай дунд | 16,9 | | | 18,4 | 13,1 |
| ▪ Дээд | 26,7 | | | 32,7 | 11,4 |
| **Тэтгэврийн хэмжээ** | - | **394315** | **189894** | - | - |
| ▪ 300000 төгрөгнөөс доош | 5,3 | | | 5,9 | 3,7 |
| ▪ 300001-350000 | 47,9 | | | 43,0 | 60,2 |
| ▪ 350001-400000 | 13,1 | | | 11,8 | 16,2 |
| ▪ 400001-500000 | 13,2 | | | 13,3 | 13,0 |
| ▪ 500001-600000 | 8,3 | | | 10,1 | 3,7 |
| ▪ 600001-700000 | 5,4 | | | 7,0 | 1,4 |
| ▪ 700000 төгрөгөөс дээш | 6,9 | | | 8,9 | 1,9 |
| **Эрүүл мэндийн байдлын үнэлгээ** | - | **2,26** | **0,9** | - | - |
| ▪ Сайн, ямар нэг асуудалгүй | 23,3 | | | 24,2 | 21,1 |
| ▪ Бага зэргийн зовиур байдаг | 34,9 | | | 35,1 | 34,6 |
| ▪ Үе үе өвддөг, эмчилгээ хийлгэдэг | 34,6 | | | 33,1 | 38,4 |
| ▪ Хүнд өвчтэй | 7,2 | | | 7,7 | 5,9 |

36.6% нь ажилчин, 45.9% нь малчин, 17.5% нь сэхээтэн гаралтай, 45.1% нь мэргэшсэн ба туслах ажилчин, техникийн ажилтан, 31.6% нь дээд боловсролтой мэргэжилтэн болон дунд түвшний удирдах ажил хийж байжээ. Малчин, саальчин байсан нь 1/10, хувиараа хөдөлмөр эрхлэгч, эсвэл гэр бүлийн бизнес хийж байгаад тэтгэвэрт гарсан хүмүүс 7 хувь, ажилгүй, хүүхэд хараад гэртээ байж байгаад тэтгэвэрт гарсан хүмүүс 6.4 хувийг эзэлж байна.

### *1.5 Суурь судалгааны ажлын даалгавар*

Суурь судалгааны сэдэвт ажлын  хүрээнд судалгааны үр дүнг гаргаж, судалгааны тайлан санал зөвлөмж боловсруулан, 16 эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлэн, ЭШ-ний хурал зохион байгуулж, 12 илтгэл хэлэлцүүлж, хамтын бүтээл бичиж хэвлүүлэх байв.

## II

## СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН АГУУЛГА

### *2.1 Ахмад настны талаарх бодлогын үр дүн, сорилт*

Монгол улс өөрийн орны онцлогт нийцүүлэн ахмад настны холбогдолтой асуудлыг зохицуулсан 10 гаруй хууль, тэдгээрийн дотор Ахмад настны тухай тусгайлсан хууль[16] батлан гаргаж мөрдүүлсэний дээр мөн 10 орчим Үндэсний стратеги, хөтөлбөрүүд зэрэг бодлогын баримт бичгүүдийг мөрдөн ажиллаж иржээ. Монголын төрөөс ахмад настнуудынхаа талаар авч хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны үнэлгээнээс харахад ололт амжилт, сорилт бэрхшээл аль аль нь байна.

Бодлогын түвшинд нэн даруй дараах чиглэлд анхаарал төвлөрүүлбэл зохино.

***Нэгдүгээрт,*** ”Насжилтын үндэсний цогц бодлого”-ын үзэл баримтлал, концепцийг шинээр тодорхойлох шаардлага тулгарч байна. Олон улсын түвшинд дэвшигдсэн зарчим, бодлого, тунхаглал, үйл ажиллагааны төлөвлөгөө, тэдгээрийн агуулга, мөн чанарыг нь сайтар ухаж ойлгохгүйгээр хийсвэрлэн хэлбэрдэж хуулбарлах, ерөнхийлөн хялбарчлах байдлаар ханддагаас бодлого, шийдвэрээ хэрэгжүүлдэггүй, дур зоргоор ханддаг, сайн бодлого байвч түүнийг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, хянах хариуцлагын тогтолцоо байдаггүй дутагдалдаа дүгнэлт хийж **бодлогын интеграцчилал** хийх нь юу юунаас чухал байна. Ахмад настны талаар баримтлах бодлогын чухал асуудлаар нэгдсэн ойлголцол бүрдүүлэхгүйгээр өөр өөрийн байр сууринаас асуудалд хандаж нэг хэсэг нь нөгөөгөө үгүйсгэн, бодлогын эрэмбэлэл, мөн чанарыг үнэгүйдүүлдэг буруу арга барил, амь бөхтэй зууралдсаар байгааг халж өөрчилбөл зохино.

***Хоёрдугаарт***, ”Хүн судлал” тэр дотроо “Ахмад настан” судлалын асуудалд шинжлэх ухаанчаар хандаж эрдэм шинжилгээний бие даасан салбарын түвшинд гаргаж тавих цаг нэгэнт болжээ. Геронтологийн үйлчилгээг өвчилсөн үедээ хэвтэн эмчлүүлэх эмнэлэг байх ёстой мэтээр хандаж ирсэн буруу ойлголтоосоо салж нийгмийн геронтологийн шинжлэх ухааны мөн чанарт нийцүүлж, ахмад настны бие

---

[16] Хавсралт лавлагаа-1.

махбодийн насжилт, сэтгэл зүйн насжилт, нийгэм, эдийн засаг, биологийн насжилтын гэх мэт бүх чиглэлээр цогц хэлбэрээр хөгжүүлэх шаардлагатай байна.

***Гуравдугаарт,*** НҮБ, бусад байгууллага, дэлхийн нийтээрээ хэрэгжүүлэхийн төлөө идэвхийлж буюу Мадридын Насжилтын олон улсын стратеги тунхаглал, Насжилтын үйл ажиллагааны төлөвлөгөө /2002 он/-г хэрэгжүүлэх талаар Монгол Улс өнгөрсөн 20 жилд Үндэсний хэмжээнд юу хийж ямар үр дүнд хүрсэнээ олон улсын шалгуураар нь үнэлэн цэгнэж, цаашдын зорилтоо цогц байдлаар цоо шинээр тодорхойлох шаардлагатай болсныг манай судалгаа харуулсан.

***Дөрөвдүгээрт,*** ахмадын эрхийн олон улсын баримт бичиг /конвенци/ баталж гаргах тухай НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2010 онд гаргасан санаачилга, шийдвэрийг дэмжиж идэвхтэй хамтран ажиллах талаар Монгол Улс, Засгийн газар идэвх чармайлт гаргаж ажиллах хэрэгцээ шаардлага байгаад анхаарвал зохино.

Эрдэм шинжилгээний суурь судалгааны үр дүнгээр дэвшүүлсэн судлаачдын санал, санаачилга, бодлогын болон үйл ажиллагааны Зөвлөмжийг төр, засаг, иргэн, иргэний нийгмийн байгууллагууд бүх түвшиндээ ажил хэрэг болгох чиглэлд ойлголт, хандлага, хүч оюунаа нэгтгэн дэвшил гаргах нь хүн ам цөөнтэй, хөдөлмөрийн нөөцөөр хязгаарлагдмал, өргөн уудам нутаг, асар их баялаг, нөөц чадавхтай Монгол үндэстний оршин тогтнохуйн үндсийг бататган бэхжүүлэхэд тус дэмтэй үйлс болно.

### *2.2 Ахмад настны амьжиргааны асуудал*

Ахмадуудын амьжиргааны түвшнээ үнэлсэн субьектив үнэлгээнд үндэслэн *дундаас дээш, дунд, дундаас доогуур, доод* гэсэн дөрвөн хэв маягт хуваан авч үзсэн. Ахмад настнуудын 20 хувь нь доод, 53.2 хувь нь дундаас доогуур, 18.1 хувь нь дунд, 8.6 хувь нь дундаас дээш түвшинд амьдарч байна. Харин хүйсийн хувьд доод, дундаас доогуур, дунд түвшинд эмэгтэйчүүд 53.6-66.5 хувийг эзэлж байхад дундаас дээш түвшинд эрэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлж байна. Орлогын эх үүсвэрийн хувьд доод түвшний ахмад настнуудад хүүхэд, ах дүүгийн туслалцаа бусад бүлгээсээ арай илүү байсан бол дунд түвшинд туслах аж ахуйн орлого, дундаас дээш түвшинд хувиараа хөдөлмөр эрхэлсний орлого, хадгаламжийн болон хувьцааны орлого бусад бүлгийнхнээсээ арай өндөр хувьтай байв.

*Орон сууцны нөхцөл*

Амьдарч буй сууцны нөхцөлийн хувьд судалгаанд оролцсон ахмадуудын 31.3 хувь нь орон сууцанд, 62.3 хувь нь бие даасан сууцанд, 6.3 хувь нь түрээсийн болон бусад хэлбэрийн сууцанд амьдарч байгаагаас олонх нь хашаа байшин (35.6%), гэр (26.0%), нэг өрөө (17.2%) байранд амьдардаг.

Сууцны хэлбэр, хэмжээ ийнхүү ялгаатай байгаа нь нэгд, суурьшиж буй газраас хамаарч ялгарах ба *Улаанбаатар хотоос судалгаанд оролцсон ахмадуудын* 51.9 хувь нь орон сууцанд, 40.9 хувь нь бие даасан сууцанд, *аймгийн төвд амьдардаг ахмадуудын* 21.4 хувь нь орон сууцанд, 70.7 хувь нь бие даасан сууцанд, *сумын төвд амьдарч буй ахмадуудын* 95.8 хувь нь бие даасан сууцанд амьдардаг. Суурьшлын бүсийн аль хэсэгт хамаарч байгаагаас хамаарч тухайлбал, хотын төв, төвд ойролцоо амьдарч буй ахмадуудын 64.7 хувь нь орон сууцанд, захын дүүрэг хороодод амьдарч буй ахмадуудын 68.5 хувь нь бие даасан сууцанд амьдардаг.

*Өмчлөлийн байдал*

Өмчийн хувьд 50.4 хувь нь өөрийн өмчлөл бүхий газар, 35.6 хувь нь орон сууц, 29.2 хувь нь машин техник, 25.0 хувь нь хашаа байшин, 16.8 хувь нь малтай бөгөөд эдгээрийг ахмадуудын гол өмчид тооцож болно.

Ахмад настнуудын 40.5 хувь нь өөрийн гэсэн нэг өмчтэй бол 28.8 хувь нь хоёр, 22.3 хувь нь гурав, 8.4 хувь нь дөрөв ба түүнээс дээш тооны өмчтэй. Өмчийн эзэмшил нь хүн ам зүйн болон нийгмийн шинж байдлаас тухайлбал, жендерээс хамаарсан ялгаа байхгүй. Өөрөөр хэлбэл, өрхийн өмчлөгч нь эрэгтэй хүн байх ёстой гэх уламжлалт хандлага өөрчлөгдсөнийг харуулж байна.

*Орлогын бүтэц, хэмжээ*

Судалгаа хийх үед буюу 2020, 2021 онд ахмад настны өрхийн орлого нь тэтгэвэр, тэтгэмж (58.3%), ахмад настан болон тэдний өрхөд багтаж буй гишүүдийн ажил эрхлэх байдлаас хамаарч үндсэн ажлын хөлс (16.5%), хүүхэд, ах дүүгийн туслалцаа (8.3%), хувиараа хөдөлмөр эрхэлсний (5.8%), бусад эх үүсвэрээс (11.1%) бүрдэж байна. Нийт ахмадуудын 55.5 хувь нь нэмэлт орлого олоход чиглэсэн идэвхтэй үйл эрхэлдэг. Тэдний 67.6 хувь нь ямар нэг ажил эрхэлдэггүй, 32.4 хувь нь ажил эрхэлдэг байв. Хөдөлмөр эрхэлж буй эсэхээс хамаарч орлогын бүтэц, хэмжээ ялгаатай байна.

Хөдөлмөр эрхэлж буй ахмадууд хоёр эх үүсвэрээс өрхийн орлогыг бүрдүүлдэг бөгөөд тэтгэвэр (90.4%) гол эх үүсвэр болж, үндсэн ажлын хөлс (39.5%), хувиараа хөдөлмөр эрхэлж олсон орлого (21.0%), түр ба цагийн ажил (10.3%) орлого бүрдүүлэх нэмэлт үүсвэр болдог. Ажил хөдөлмөр эрхэлдэг ахмадуудын тухайд 93.3 хувь нь идэвхтэй ажил хөдөлмөр эрхлэх байдлаар орлогоо бүрдүүлдэг. Ажил хөдөлмөр эрхэлдэггүй ахмадууд болоод тэдний өрхийн орлогын 37.2 хувь нь л тэтгэврээс гадна өөр нэмэлт эх үүсвэрээс бүрддэг.

Судалгаанд оролцсон ахмадууд сард дунджаар 934.912 төгрөгийн орлоготой бөгөөд тухайн өрхийн орлогын эх үүсвэрийн тооноос хамаарч орлогын ялгаатай байдал бий болж байна. Ахмадууд өрхийн орлогын 5-100 хүртэл хувийг бүрдүүлдэг бөгөөд 7.9 хувь нь орлогын 25 хүртэл хувийг, 37.7 хувь нь 26-50 хувийг, 24.4 хувь нь 51-75 хувийг, 30.0 хувь нь 76-аас дээш хувийг бүрдүүлдэг.

*Орлого, зарлагын харьцаа*

Ахмадууд олж буй орлогынхоо дийлэнх хэсгийг өдөр тутмын хэрэглээнд (80.1%) зарцуулдаг бөгөөд таван ахмад настан тутмын дөрөв нь зөвхөн хоол хүнсний хэрэгцээгээ хангахад орлогоо зарцуулдаг. Орлогын үлдсэн хэсгийг, мөн бусдын дэмжлэг туслалцаатайгаар нэгд эмчилгээ, эм тариа  (56.7%), өөрийн хэрэглээнд (50.2%), хоёрт үр хүүхэд, ач зээ (28.0%), байрны төлбөр (25%), гуравт өр зээл (19.0%), сургалтын төлбөрт (10.7%), хуримтлал үүсгэхэд (9.0%) зориулдаг. Өрхийн зардлын дийлэнх хэсгийг амин зуулгын болоод аюулгүй байдлын хэрэгцээгээ хангах төдийд хязгаарлагддаг гэж үзэж болох бөгөөд амьжиргааны түвшний үнэлгээгээр судалгаанд оролцогчдын 54.1 хувь нь хоол, хүнсий зардлаа болгох төдий амьдардаг (773.132 төгрөгийн орлоготой), 19.2 хувь нь хоол хүнснээс гадна хувцас хэрэглэл, байрны зардлаа болгодог (968.701 төгрөгийн орлоготой), 18.1 хувь нь үнэ бүхий зүйл худалдан авахад зээл хэрэгтэй болдог (1.099.567 төгрөгийн орлоготой), 8.6 хувь нь л орлогод санаа зовох зүйлгүй амьдардаг (1.452.763 төгрөгийн орлоготой) гэсэн нь ихэнх ахмад настнуудын өрхийн орлого хэрэглээндээ хүрэлцэхгүй байгааг илэрхийлнэ.

*Өрхийн орлогод нөлөөлж буй хүчин зүйлс*

Ахмад настнуудын орлого, амьжиргааны түвшний ялгаатай байдалд анх тогтоосон тэтгэврийн хэмжээ шууд нөлөөлдөг бөгөөд “Ахмад настны тухай” хуулийн 8.3-д үнийн өсөлтийг харгалзан тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлнэ гэж заасан

байдаг. Хуулийн энэ заалтад үндэслэн тухайн үеийн үнийн өсөлт[17], 2016 оны тэтгэврийн доод хэмжээ[18]-г баримжаалан тооцоход 2020 онд тэтгэврийн доод суурь 303.197 төгрөгтэй тэнцэхээр байна. Тухайн үеийн тэтгэврийн жишиг доод хэмжээг үнийн өсөлтийн түвшингээс харьцангуй дээгүүр тогтоосон мэт боловч Ахмад настны тухай хуулийн 8.3-т заасанчлан “орлогын баталгаа” нь амин зуулгын хэрэгцээнд ч хүрэлцдэггүй. Ахмад настнуудын орлогын хүрэлцээгүй байдлыг тэдний үр хүүхэд (57.9%), ах дүү (25.2%), найз нөхөд, танил (16.3%)-ууд нөхдөг.

Судалгаанд оролцсон ахмадуудын тэтгэврийн дундаж 431.909 төгрөг бол хамгийн бага нь 237.000 төгрөг, хамгийн их нь 1.450.000 төгрөгийн тэтгэвэр авдаг. Их болон бага тэтгэвэр 6.1 дахины зөрүүтэй. Харьцуулсан үр дүнгээс цэрэг болон хуулийн салбарт ажиллаж байсан ахмадуудын тэтгэврийн дундаж байгууллага, газрын дарга нарынхаас, техникийн болон үйлчилгээний ажилтнуудын тэтгэврийн дундаж мэргэшсэн ажилчдынхаас өндөр г.м ялгаатай байгаа нь тухайн ахмад настны ажлын байран дахь статус бус хүлээсэн үүргийн нөлөөлөл (r = -0.367**) хүчтэй байгааг илэрхийлнэ.

*Өр зээл ба амьжиргаа*

Судалгаанд оролцогч ахмадуудын 56.9 хувь нь өр зээлтэй, үүнээс 28.0 хувь нь тэтгэврийн, 15.3 хувь нь хэрэглээний, 5.1 хувь нь барьцаалан зээлдүүлэх газарт, 4.4 хувь нь хувь хүнд, 4.0 хувь нь бусад эх үүсвэрээс зээлсэн өр зээлтэй.

Судалгаанд оролцогч ахмад настнуудын өрхийн сарын дундаж орлого 934,912 (mode 700,000) төгрөг бөгөөд түүнээс зээл төлөөд үлдэж буй сарын дундаж орлого 687,896 (mode 350,000) төгрөг байв.

Зээлийн төлөлттэй холбоотой нэмж тодруулахад, ачаалал нь өрхийн орлогоос хамаарах ба харьцангуй өндөр орлоготой ахмадуудын хувьд төлөлт хийхэд бэрхшээл бага гардаг бол бага орлоготой ахмадуудын хувьд зээлээ төлж чадахгүйд хүрэх магадлал өндөр.

Өрхийн орлого өндөр байхад ам бүлийн тоо (ро = 0.399**), амьдарч буй сууцны хэлбэр (ро = 0.261**), өөрийн боловсролын түвшин (ро = 0.238**), эцгийн боловсрол, мэргэжил (аавын боловсрол ро = 0.058*, аавын мэргэжил ро = 0.094*), тэтгэвэр

[17] Инфляцийн жилийн түвшин. ҮСХ. 2017-2020, 2022
[18] Нийгмийн даатгал, халамж. ҮСХ. 2017, p. 23

тогтоолгосон нас (ро = 0.05*), шилжилт хөдөлгөөн хийсэн эсэх (шилжиж ирсэн ро = 0.68, уугуул ро = 0.026*) нь өрхийн орлогод эерэг нөлөө үзүүлдэг. Эсрэгээр хэн хэнтэйгээ амьдардаг (ро = -0.404**), гэрлэлтийн байдал (ро = -0.383**), эрхэлж байсан ажил (ро = -0.276**), оршин сууж буй газар (хот, аймаг, сум, хөдөө ро = -0.195**), оршин сууж буй газрын байршил (суурьшлын бүсийн төв, ойролцоо, захад г.м ро = -0.137**), хүйс (ро = -0.092**), нас (ро = -0.073**) зэрэг үзүүлэлтүүд сөргөөр нөлөөлдөг.

Ахмад настнуудын өрхийн орлогын хэмжээ нэгд анх тогтоосон тэтгэврийн хэмжээнээс, хоёр хөдөлмөр эрхлэлтийн байдлаас хамаарч, гуравт нийгмийн бусад хүчин зүйлс тухайлбал, ам бүлийн тоо, амьдарч буй газар, боловсролын түвшин г.м олон хүчин зүйлээс хамаардаг. Тэтгэвэр тогтоож (тогтоосон) буй зарчим, тэтгэврийн доод хэмжээ зэрэг нь тэгшитгэлийн шинжтэй шударга бус хуваарилалт болсны дээр тэтгэврийн насны олон ахмадуудын хувьд тэтгэвэр нь амин зуулгын хэрэгцээнд ч хүрэлцдэггүй.

Монголын төр хуулиар хүлээсэн үүргээ хариуцлагатайгаар гүйцэтгэхгүй байгаагийн зэрэгцээ иргэдийг хоёр хэлбэрээр шимэгчилж байна. Нэгд ахмад настнуудын нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэлтэй дүйх, бусдаас хамааралгүйгээр амьжиргаагаа тэтгэх хэмжээний тэтгэвэр олгодоггүй, мөн ялгаварлаж ханддаг. Эрт нас баралтын улмаас олонх ахмад үр шимийг огт хүртэж чаддаггүй. Хоёрт тэтгэврийн хүрэлцээгүй байдлаас үүдэлтэй ажил хөдөлмөр эрхэлж буй залуус бүтээж буй баялгийнхаа тодорхой хэсгийг эцэг эх (уламжлалт харилцааг үгүйсгээгүй)-дээ зориулах байдлаар төрийн үүрэх хариуцлагыг давхар үүрдэг.

Ахмад настнуудын өрхийн орлогын хэмжээ нэгд анх тогтоосон тэтгэврийн хэмжээнээс, хоёр хөдөлмөр эрхлэлтийн байдлаас хамаарч, гуравт нийгмийн бусад хүчин зүйлс тухайлбал, ам бүлийн тоо, амьдарч буй газар, боловсролын түвшин г.м олон хүчин зүйлээс хамаардаг. Тэтгэвэр тогтоож (тогтоосон) буй зарчим, тэтгэврийн доод хэмжээ зэрэг нь тэгшитгэлийн шинжтэй шударга бус хуваарилалт болсны дээр тэтгэврийн насны олон ахмадуудын хувьд тэтгэвэр нь амин зуулгын хэрэгцээнд ч хүрэлцдэггүй.

Ахмад настнуудын 67.6 хувь нь ямар нэг ажил эрхэлдэггүй, 32.4 хувь нь ажил эрхэлдэг. Мөн тэдний амьжиргааны нөөц боломжийн индексийг гаргахад нийгмийн

нөөц эерэг утгатай гарсан бол эдийн засгийн нөөц болон мэргэшлийн нөөц хасах утгатай буюу эрсдэлтэй байв.

Амьжиргааны түвшнээс доод түвшинд амьдарч буй ахмадууд нөөцгүй, маш бага нөөцтэй гэсэн бүлэгт хамаарах нь их байгаа бол дунд болон дундаас дээгүүр түвшинд амьдарч буй ахмад настнууд нөөцтэй, өндөр нөөцтэй бүлэгт хамаарч байв. Тус түвшинд нөлөөтэй нэг үзүүлэлт бол тэдний ирээдүйдээ итгэх итгэл бөгөөд тус түвшин буурах тутам ирээдүйд итгэх байдал буурч байгаа бол уг түвшин дээшлэхэд ирээдүйн амьдралаа эергээр харж байгаа байдал нэмэгдэж байна.

Амьжиргааны доод түвшинд буй ахмадуудын хувьд хөрөнгө мөнгөөр дутагдах (24.1%), эрүүл мэнд муудах (16.3%), нийгмийн зүгээс анхаарал халамж суларсан (13%) зэрэг асуудал өндөр хувьтай байгаа бол дунд болон дундаас доогуур түвшин дэх ахмадуудын хувьд  мөн адил хөрөнгө мөнгө, эрүүл мэндийн байдал муудах, уулзаж ярилцах, сэтгэл санаагаа хуваалцах хүмүүс ховордсон зэрэг асуудал голложээ. Дундаас дээш түвшинд буй ахмадуудын хувьд хөрөнгө мөнгө, нийгмийн зүгээс анхаарал халамж суларсан зэрэг асуудал нь хамгийн их санаа зовоож буй асуудалд орсон бөгөөд эрүүл мэндийн байдал муудах нь бусад бүлгийнхнээс арай өндөр хувьтай байна. Үүнээс үзэхэд ахмад настнуудад амьжиргааны аль түвшинд байхаас үл хамааран санхүү, эрүүл мэндийн асуудал хамгийн их тулгамдаж байна.

### *2.3 Ахмад настны эрүүл мэнд, сэтгэл зүйн байдал*

Монгол Улсын хүн амын дундаж наслалт нэмэгдэж байгаа бөгөөд сүүлийн 4 жилийн байдлаар нэг жилээр өсч 71.01 болжээ.[19] Эмэгтэйчүүдийн дундаж наслалт 76.47, эрэгтэйчүүдийнх 67.05 жил буюу эмэгтэйчүүд бараг 10 жилээр илүү наслаж байна.

Ахмадуудын хамгийн их эрхэмлэж буй зүйл нь эрүүл мэнд байна. Эрүүл энх байхыг  “маш чухал, чухал үнэт зүйл” хэмээн 98.7 хувь нь үнэлсэн юм.

Монгол Улсын хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү одоогийн байдлаар 10 жил байгаа бөгөөд энэ нь эрүүл мэндэд хандаж байгаа байдлыг мөн илэрхийлж байгаа юм. Тиймээс дундаж наслалтанд зөвхөн хүмүүсийн субьектив хандлага бус улсын нийгэм, эдийн засгийн түвшний хөгжил ч мөн нөлөөлж байна.

---

[19] ҮСХ. (2022, 04 20). Хүн амын дундаж наслалт. Улаанбаатар, Монгол Улс. //http://www.1212.mn

Ахмадуудын дийлэнх нь ямар нэгэн зовиуртай, бие нь заримдаа өвддөг бөгөөд тэдгээрийн эрүүл мэндийн үнэлгээнд хүйс, боловсрол хүчтэй нөлөөлж байна. Боловсролын түвшин ихсэх тусам эрүүл мэндийн байдал нь илүү байх хандлагатай. Нөгөөтэйгүүр боловсролын түвшин багасах тусам хүнд өвчтэй хүмүүс ихсэж байгаа нь анхаарал татаж байна. Түүнчлэн эрүүл мэндийн байдалд өрхийн орлогын түвшин нөлөөлдөг бөгөөд нэг сая төгрөгнөөс дээш орлоготой айл өрхийн бараг гуравны нэг нь эрүүл мэндийн хувьд асуудалгүй байна.

Эрүүл мэндийн үйлчилгээг ахмадуудын дийлэнх хувь нь жилд ганц, хоёр удаа очиж авдаг бөгөөд хүнд өвчтэй хүмүүсийн дийлэнх нь эмчийн байнгын хяналтанд байдаг ажээ. Амралт сувилал, рашаан сувилал, сэргээн засах үйлчилгээ авахад хотын ахмадууд илүү их хамрагдаж байгаа нь мэдээлэл авах боломж, рашаан сувилалд хамрагдах боломжоос их хамаардаг. Мөн түүнд санхүүгийн асуудал гэсэн хүчин зүйл нэмэгдэж байгаа. Аливаа нэгэн төрийн үйлчилгээ авахад хамгийн түрүүнд иргэн бүрт мэдээлэл хүргэх нь хамгийн чухал бөгөөд үүнд төрийн байгууллагууд маш их анхаарах хэрэгтэй. Харин эрүүл мэндийн үйлчилгээ авахад тулгардаг асуудалд ахмадууд эм тарианы үнэ болон оочер дарааллыг нэрлэсэн билээ. Эрүүл мэндийн байдалд хувь хүний дадал хэвшил ихээр нөлөөлдөг бөгөөд эрэгтэйчүүдийн архи, тамхины хэрэглээ эмэгтэйчүүдийнхээс бараг 3, 4 дахин их байна.

Ахмадын судалгааны тоон ба чанарын үр дүнг нэгтгэн дүгнэхэд эрүүл мэндийг ихэвчлэн анагаах ухааны эрүүл мэндийн загвараар буюу өвчин эмгэг, шинж тэмдэггүй гэх, дараа нь доройтол бол насжилтын үр дагавар, биологийн зүй тогтол хэмээн үзэх био-анагаахын хандлага газар авсан байна. Үүнээс улбаалан эрүүл мэндийг өвчин эмгэг, шинж тэмдгийг илрүүлэх, анагаах үйл ажиллагааг төрд даатган хариуцлагыг оногдуулах үзэл элбэг байна. Гэхдээ үнэт зүйлс-нийгмийн загвар бас ахмадын дунд байгааг тэмдэглэх хэрэгтэй. Эрүүл мэнд бол хувь хүний хөдөлмөр зүтгэл, сахилга бат гэсэн ойлголт нь улс төр, нийгэм-соёлын суурь дэвсгэрээс (контекст) гадна өөрсдийн идэвх, зүтгэл, мэргэжил, боловсрол, гэр бүлийн хүмүүжлээс хамааралтай аж.

Ахмадын эрүүл мэндэд хандах нийтлэг хандлагыг 3 үзүүлэлтээр шинжлэхэд саармаг дүр зураг гарч байна. Нэгд, эрүүл мэндийн өөрийн үнэлгээгээр таван хүний дөрөв нь аливаа нэгэн эмгэг зовиуртай гэв. Хоёрт, бүгд эрүүл мэндийг дээд үнэт зүйлд онцлов. Гуравт, зан үйлийн үзүүлэлтээр, тухайлбал, урьдчилан сэргийлэх үзлэгт

хамрагдах, эрүүл дадал хэвшүүлэх зэрэг дээр хойрго, хойшоо суух нь түгээмэл байна. Өөрөөр хэлбэл, бүгд эрүүл мэндийг чухалчилдаг, ахмадын ихэнх нь аливаа нэгэн зовиуртай боловч эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа буюу хувийн зүгээс эрүүл мэндийг сахих болон сайжруулах чармайлалт дутмаг аж. Ер нь манай ахмадуудад өөрсдийн хэрэгцээг арагш тавин үр хүүхдийн төлөө харамгүй зүтгэх нийгэм- соёлын шинж түгээмэл байна.

### *2.4 Ахмад настны хөдөлмөр эрхлэлт*

Ахмад настнуудын 50 гаруй хувь нь ядуурлын шугамнаас доогуур түвшинд амьдарч буй бөгөөд хөдөлмөр эрхэлж буй ахмадуудын орлого харьцангуй өндөр байгаа нь хөдөлмөр эрхлэх хэрэгцээ, ач холбогдол өндөр болохыг харуулж байна. Цаашид үзэл баримтлалын хувьд уян хатан ажлын байрны зохицуулалт хийх, хөдөлмөрийн зах зээлийг тэлэх нь ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломж олгоно. ҮСХ-ны мэдээллээр судалгаа хийх үед 76.389 ахмад настан хөдөлмөр эрхэлж байсан бол “Ахмад настны социаль асуудал: үр дагавар, төлөв хандлага” судалгааны мэдээлэлд хийсэн шинжилгээгээр ахмадуудын 53.3 хувь нь (нийт ахмадуудад үр дүнг буулгаж тооцвол 183.694) ажиллах сонирхолтой, боломжтой гэсэн нь тэдэнд чиглэсэн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй бус байгааг илэрхийлж байна.

Ахмадуудын 51.2 хувь нь 60 насанд хүрэхээс өмнө, 64 хувь нь 65 насанд хүрэхээс өмнө нас барж байгаагаас гадна нь хөдөлмөр эрхэлж байх хугацаандаа нас барсан хүн нийгмийн даатгалын санд төлсөн шимтгэлийн үр шимийг хүртэж чаддаггүй.

Хууль хүчин төгөлдөр болсон учир нэмэлтээр “ахмад ажилтан” буюу хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын санд шимтгэл төлж буй ахмад настнуудын эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг бий болговол зохино. Ажилчдын нас (ахмад ажилчид)-аас хамаарч эрсдлийн даатгалын үйлчилгээг төр хариуцан нэвтрүүлэх, эрсдлээс хамгаалах нийгмийн үйлчилгээ үзүүлэх, нас барсан тохиолдолд тэдгээр хүмүүсийн нийгмийн даатгалын санд төлөх шимтгэлийн үр шимийг гэр бүл, үр хүүхдэд дамжуулах байдлаар эрх ашгийг нь хохироохгүйгээр зохистой гарцыг бий болгох шаардлагатай.

Төр асуудлаас зугтах байдлаар бус, харин иргэдийн сайн сайхан байдлыг баримжаалсан хувилбарт тулгуурлах нь бодлогын хувьд оновчтой шийдэл болно.

## *2.5 Ахмад настны нийгмийн оролцоо*

Ахмад настны олонх нь нийгмийн идэвх, оролцооны дундаж, оролцоо өндөр бүлэгт хамаарагдаж байна. Ахмадуудын нийгмийн идэвх, оролцоо харьцангуй сайн байна. Судалгаанд оролцогч ахмадуудын 3/5 нь оролцоо маш өндөр, өндөр байгаа бол дундаж оролцоотой, 1/3 нь оролцоо дундаж, ойролцоогоор 1/10 нь оролцоо бага, маш бага болон оролцоогүй байна. Насны бүлгээр ахмадуудын идэвх оролцоо буурч байгаа ч нийгэм улс төрийн, олон нийтийн гэх мэт зарим үйл ажиллагаанд өтөл өндөр настангууд илүү идэвх оролцоотой байна.

Ахмадууд гэр бүлийн хүрээнд бүрэн дүүрэн дүүрэн оролцоотой (82.3) байж, нийгмийн харилцаанд болон нийгмийн амьдралд идэвхтэй оролцохын сацуу өөрсдийн санаа бодлыг нэмэрлэж, сэтгэгдлээ илэрхийлэх, мэдээлэл олж авах гэх мэтээр сэтгэл зүйн оролцоо сайтай байдаг байна. Харин эдийн засгийн оролцоо маш дутмаг. Энэ нь ажил эрхлэж буй ахмадуудын тоо туйлын хангалтгүй байгаа, ажил эрхлэх боломж төдийлөн хангагдахгүй байна гэж үзсэнтэй холбоотой. Мөн ахмадууд ажил эрхэлнэ гэхээр ихэвчлэн ямар нэг байгууллага, компанид цалин хөлстэй ажил эрхлэхээр ойлгох, төрөөс хэн нэг эрх мэдэлтэн ахмадуудад зориулсан ажлын байр бий болгохыг хүсэж хүлээн суугаа нь нийтлэг байгаа төдийгүй өөрсдөө ажлын байраа бий болгох боломжтой гэж харж байгаа ахмадууд тун бага, тэтгэврийн насны ахмадуудыг төрийн байгууллагад ажиллуулахыг багасгах бодлого барьж буй зэрэг нь тэдний ажил хөдөлмөр эрхлэлтийн оролцоо өсөх магадлал цаашид ч бага байгааг харуулж байна. Ахмад настнуудын олон нийтийн үйл ажиллагааны оролцоо дундаж, дунжаас дээгүүр байна. Ойролцоогоор 1/3 нь дундаж, ¼ нь өндөр, 1/5 нь илүү өндөр түвшинд оролцдог. Ахмадууд нийгэм, улс төр, сэтгэл зүй, олон нийтийн дунджаар 1,8 (Median 2, Mode 1) үйл ажиллагаанд оролцож байна.

Ахмад настны цахим хэрэглээг нэмэгдүүлэхэд анхаарч, дэмжих нь ахмад насны нийгмийн оролцоог нэмэгдүүлэх нэг үр дүнтэй шийдэл болно.

Ахмад настны нийгмийн оролцооны нэг хэлбэр нь төрийн байгууллагаас үйлчилгээ авахаар халамжийн байгууллага, мэргэжилтэнтэй холбогдож, тэдэнтэй харилцаж, төрийн үйлчилгээнд хамрагдагдаж буйгаар илэрч байна. Судалгаанд оролцогч ахмадуудын ойролцоогоор 1/5 ямар ч үйлчилгээнд хамрагдаагүй, хөнгөлөлт авдаггүй, 4/5 нь 1-5 төрлийн үйлчилгээнд хамрагджээ.

Ажил эрхэлдэг, тэтгэврээс өөр орлоготой, бусдын дэмжлэг туслалцаагүй харилцах чадвартай, гишүүнчлэлтэй, нийгмийн капиталтай, боловсролын түвшин өндөр, эрүүл мэнд нь харьцангүй сайн ахмадууд нийгмийн оролцоо илүү байна. Нийгмийн оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлсийн загварыг тодорхойлбол нийгмийн оролцоонд *хувь хүний болон нийгмийн, орчны хүчин зүйлс* нөлөөлж байна.

Аймгийн төв, сумын төв, хөдөөд ахмадуудын оролцоо ялгавартай байна. Аймгийн төв, суурин газарт ахмад настнууд олноороо амьдарч буй учир ахмадын холбоо, төрийн зохих албад хүн хүч хүрэлцэхгүй, хүн бүрийн оролцоо хангагдахгүй байна. Аймгийн төвд амьдардаг дундаж, дунджаас доогуур амьжиргаатай ахмадууд өөрсдийн нийгмийн оролцооны байдалд туйлын сэтгэл ханамжгүй байгаа юм. Ахмадын холбооны үйл ажиллагаанд идэвх, сонирхолтой ахмадууд, тэнд ажиллагсдын ойр тойрны хүрээллийн хүмүүс, гэр ойр ахмадууд голчлон хамрагдаж, дийлэнх олонх нь үйл ажиллагаанд оролцдоггүй, оролцох нөхцөл боломжгүй, мэдээлэлгүй байв. МАхХ зохиогдож байгаа арга хэмжээнүүд хязгаарлагдмал, хамрах хүрээ бага, дандаа хамрагддаг тодорхой хүрээнд л эргэлдээд байгаа аж.

Ахмад настны нийгмийн оролцоог дэмжих, нийгмийн идэвхтэй гишүүн байлгахын тулд өөрсдийнх нь оролцоо санаачилгад тулгуурлан ажиллаж, ажил орлого олох боломж бололцоогоор хангах, ажил эрхлэлтийг дэмжих, мэдээлэл, сургалтад хамруулах, боловсролыг нь дээшлүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, гэр бүлийн ажиллагааг идэвхжүүлэн ажиллах, тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлын үр дүн сайн гарахгүй байна. Нийгмийн оролцоо, идэвхийг дээшлүүлэхээр хийсэн ажлууд нь цогц өргөн хүрээнд бус, хүртээмж, өгөөж багатай, санхүүжилтийн асуудалтай зэргээс их элсэнд шингэх мэт далайцтай үр дүн, өөрчлөлт болж харагдахгүй байгаа дүр зураг ажиглагдаж байна.

Зарим ахмад гэрийн ажлаа хийгээд, үр хүүхдээ асраад гэртээ байж байх сонирхолтой. Эдгээр ахмадын хувьд утсаар, цахим сүлжээгээр бусад хүмүүстэй харилцаж холбогдож байна. Гэтэл хараны, сонсголын, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй ахмадууд, асрамжийн газрын ахмад настнуудын хувьд гэртээ, асрамжийн газрын байран дотроо л ихэвчлэн байх учраас амьдрах орон зай нь хязгаарлагдмал, бусадтай харилцах, нийгмийн оролцоо нь хумигдмал байв. Иймээс зөвхөн гадна орчинд явагдах нийгмийн оролцооны байдлыг анхаарах бус тэдэнд

чиглэсэн тэдний дотор орчинд зориулсан зохион байгуулалттай үйл ажиллагааг өргөжүүлж сайжруулах, тэдгээр ахмадуудад хүргэж буй төрийн үйлчилгээг чанарын өөр түвшинд хүргэх, асрамжийн газрыг тэдний оролцоог дэмжсэн, хөгжих орчин болгох, тэдний оюун санааны, харилцааны хэрэгцээг хангах, өөрсдөө хийж бүтээх, өсөж хөгжих боломж бололцоогоор хангах нь нэн чухал байна. Тэдгээр ахмадууд ч хэрэв өөрсдийн хийж бүтээх зүйлтэй, бусдад туслах ажилтай болвол сэтгэл ханамжтай, өөдрөг амьдралд хандах урам зоригтой болж, урт наслахад нь ч дэм болно.

Мөн харж асрамжлах хүнгүй, ганц бие, ганцаараа амьдардаг, эрүүл мэнд тааруу өндөр настангуудад зориулсан нийгмийн үйлчилгээг өргөжүүлэх, тэдэнд тулгарах саад бэрхшээл, эрсдэлийг даван туулах стратегийг бий болгох шаардлагатай байна. Тухайн ахмадын гэрээр нь очих, цахим сүлжээ ашиглаж чаддаг болгох, ойр дотно харилцаатай байх, ахмадуудтай зөвлөлдөх, асарч сувилах, бие бялдрын чийрэгжүүлэлт, хүртээмжийг сайжруулах, нийгэмд ийм ахмад настангуудад туслах байнгын нээлттэй үйл ажиллагааг явуулах, хүссэн хүн туслах боломжтой үедээ очоод сайн дурын үйл ажиллагаанд нэгдэж оролцох боломжтой байх,  байгууллага хамт олныг сайн дурын харилцан дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд татан оруулах, дэмжих зэрэг арга хэмжээ явуулж болох юм.

Ахмад настнууд нийгмийн харилцааны 4 кластерт хуваагдаж, “гэр бүлийн”, “танил талын”, “ажил хэрэгч”, “төрөл бүрийн” гэсэн 4 төрлийн нийгмийн сүлжээнд хамаарч байна. Хотын төвийн ахмадууд (насны аль ч бүлэг ялгаагүй) харилцаа өргөн, илүү өргөн бүлэгт буюу “ажил хэрэгч”, “төрөл бүрийн” сүлжээнд хамаарагдах нь илүү байгаа бол хотын захын ахмадууд “гэр бүлийн” болон “танил, тал”-ын сүлжээнд илүү олноороо байна.

Нийт ахмадуудын 39.6 хувь нийгмийн капитал тааруу болон муу, 1/10 нь дундаж, ½ нь нийгмийн капитал сайтай байв.

Нийгмийн оролцоо, дасан зохицол нь ахмад настны эрүүл мэндэд нөлөөлж байна. Эрүүл мэндийн асуудалтай ахмадуудын дотор нийгмийн оролцоо бага байна. Нийгмийн оролцоо багатай байх нь эрүүл мэндийн асуудалд оруулж байна.

Ахмад настны сайн сайхан байдлын үзүүлэлт 47.6 хувь нь маш сайн, сайн, 38,2 хувь нь муу, маш муу байна. Ахмад настны сайн сайхан байдалд боловсрол(r=-.095),

хот, хөдөө (r=-.284), нийгмийн капитал (r=.121), нийгмийн оролцооны түвшин(r=-.262), санхүүгийн нөөц(r=.214), амьжиргааны түвшний үнэлгээ(r=.340), дасан зохицол (r=.308), стресс (r=.289) зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

Манай ахмадуудын хувьд нийгмийн сүлжээ олон байгаа ихэнх нь сүлжээний гишүүдтэй идэвхгүй харилцаатай, хэрэгцээ гарсан үед л холбогддог. Харилцах давтамж сул байна. Нэг гол онцлог нь  гэр бүлийн харилцаа маш нягт, гэр бүл, ах дүүгийн сүлжээнд тогтмол харилцаатай байна. Гэхдээ гэр бүлийн ойр дотны цөөн гишүүдийн хүрээнд тогтвортой нягт гүнзгий харилцаатай байгаа нь нийтлэг ажиглагдав.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад гэр бүлийн тогтвортой нягт сайн харилцаа нь ахмадуудын тэтгэврийн дараах сэтгэлзүйн хямралыг даван туулж, шинэ амьдралын хэв маягт хурдан дасан зохицоход туслах нэг гол хүчин зүйл болж байна.

Байнгын идэвхтэй нийгмийн оролцоо нь ахмадуудын хувьд эрүүл мэнд харьцангуй сайн, амьдралын идэвхтэй, сэтгэл өөдрөг байх нэг хүчин зүйл болж байна. Эсрэгээрээ оролцоо багатай, харилцаа холбоо сул ахмадуудын хувьд эрүүл мэнд суларч доройтох, стресст өртөх,  өтлөлт илүү хурдан явагдах, амьдралын сайн сайхан байдал бага байх явдал ажиглагдаж байна.

Тэтгэвэрт гарах, эхнэр нөхөр нь нас барах, хамт амьдарч байсан хүүхэд нь нас барж ганцаараа үлдэх, амьжиргаагаа залгуулах боломжгүй болох, эрүүл мэнд муудах зэргээс шалтгаалан нийгмийн үүрэг хариуцлага алга болж, харилцаа холбоо буурсан, нийгмийн оролцоо багассан тохиолдлууд байна. Өтөл настай хүмүүсийн дунд харилцааны давтамж, нийгмийн оролцооны идэвх илүү их ажиглагдаж байгаа нь нийгмийн үүрэг, найз нөхөд, гэр бүлийн гишүүдээ алдсан харилцаагаа нөхөж орлуулах үүднээс шинэ харилцаа холбоо тогтоож, илүү их харилцаанд орж байгаатай холбоотой бөгөөд мөн харилцааны энэ алдагдлаа даван туулж, дасан зохицож байгааг илтгэнэ. Мөн нөгөө талаар олон ахмадууд гэр бүл, үр хүүхдээ авч явах, амьжиргаагаа залгуулахын тулд идэвхтэй оролцоотой байхаар хичээж, эрмэлзэж байгаатай, өөр нэг шалтгаан нь амьдралын тогтсон хэвшил, дадаж сурсан зан, хүмүүжил, боловсролтой нь холбоотой байна.

Ахмадуудын хувьд нийгмийн капиталын нөөц баялаг нь “холбогч нийгмийн капитал” байна. Өөрөөр хэлбэл, холбогч нийгмийн капитал давамгайлж, “гүүр бологч

капитал" буюу босоо хэлхээ холбоо харьцангуй доогуур сул байна. Ингэснээр нийгмийн оролцоог хангадаг, мэдээлэл, үзэл санаа, хэм хэмжээ, үнэт зүйлийн солилцоо болж байдаг гүүр бологч нийгмийн капиталыг бий болгох, бэхжүүлэх шаардлагатай.

### *2.6 Ахмад настны гэр бүлийн анхаарал халамж*

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор нийт өндөр настан тэргүүлэгчтэй өрхийн бүтцийн хувьд авч үзвэл дан гэр бүл 40.6 хувийг эзэлж, нийлмэл өрх 32, ганц бие өрх 25.4, холимог өрх 2 хувийг эзэлж байжээ. Судалгаанд оролцогч ахмад настны гэр бүлийн бүтцийг дээрх ангиллаар авч үзвэл хоёр ахмад тутмын нэг нь дан гэр бүлээр амьдарч байгаа бол таван ахмад тутмын нэг нь нийлмэл гэр бүл (2 ба түүнээс дээш үеэс бүрдсэн)-ээр амьдарч байна. Харин өрөөсгөл гэр бүл 10.9 хувь, ганц бие 14.4 хувийг эзэлжээ. Дан гэр бүл хөдөөд 69.6 хувьтай буюу хотын дан гэр бүлээс 5.8 хувиар илүү аж. Өрөөсгөл гэр бүл хотод 14.9 хувьтай байгаа бол хөдөөд 11 хувьтай буюу хот, хөдөөд төдийлөн ялгаа байхгүй байв.

Хоёр ам бүлээрээ амьдарч буй гэр бүл 36.6 хувийг эзэлж, тус өрх хөдөөд хотынхоос 7.8 хувиар илүү байв. Ам бүлийн тоо цөөн 3 түүнээс доош ам бүлтэй өрх 61 хувь нь байна.

Ахмад настнуудын гэр бүлд хэд хэдэн бэрхшээл буй. 2010 оны судалгаагаар ахмад гэр бүлд залуу гэр бүлүүдэд тохиолдох бэрхшээл тэр бүр байхгүй ч ганцаардах, өвчин хуучтай болох, бие доройтох, асрамжинд орох, сэтгэц муудах, найз нөхөдгүй болохоос айхын зэрэгцээ үр хүүдүүдийнхээ төлөө байнга санаа зовдог[20]. 2020 оны судалгааны дүнгээс үзэхэд ахмад настнуудад эрүүл мэнд (18.4), санхүүгийн байдал (20.7), сэтгэл санааны байдал муу байх (10.7) нь хамгийн их хүндрэл бэрхшээл учруулж байдаг бөгөөд тэдний дийлэнх нь тэтгэвэр, тэтгэмжийн (58.3) мөнгөөрөө амьдарч, түүнийгээ ихэвчлэн өдөр тутмын хэрэглээ (28.7), эрүүл мэнд (20.4)-дээ зарцуулдаг байна. Бүр тодруулбал, судлан буй гэр бүлийн 4 хэв маягт хөрөнгө мөнгөөр дутагдах, эрүүл мэндийн байдал муудах (43-56.4%) нь санаа зовоож буй асуудлын тэргүүн эгнээнд байв. Үүний дараагаар г***анц бие*** болон ***өрөөсгөл*** гэр бүлтэй

[20] Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. ШУА-ийн ФХ. Судалгааны тайлан. УБ., 2010. 66 дахь тал.

ахмадуудад орон сууцны нөхцөл тааруу, нийгмийн зүгээс анхаарал халамж суларсан, ганцаардах, уйдах, хийх юмгүй байх, нийгмийн харилцаа багассан зэрэг асуудал санаа зовоож байна гэжээ. Нийлмэл гэр бүлд бусдад тоогдохгүй, үнэлэгдэхгүй байх нь бусад гэр бүлээсээ хамгийн өндөр хувьтай байв.

Тусламж дэмжлэг авах хэрэгцээ шаардлагыг тодруулахад а) огт шаардлагагүй (15.2%), б) бага зэрэг дэмжлэг шаардагатай (63.9%), в) дэмжлэг их шаардлагатай (15.4%), г) маш их шаардлагатай (5.5%) байна. Бусдын туслалцаа дэмжлэг бага зэрэг шаардлагатай гэж хариулагсад 55-59 насныхан түлхүү байсан бол “их болон маш их” шаардлагатай гэж хариулагсдын хувь нь нас ахих тусам нэмэгдэж байв. Эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээсээ илүү тусламж, дэмжлэг шаардлагатай байдаг байна. Харин бусдын тусламж огт шаардлагагүй гэж эрэгтэйчүүд хариулах нь элбэг байв. Ахмад настнуудын 29.4 хувьд нь гэр доторх ажил, 23.9 хувьд гэрийн гадуурх, 19.6 хувьд эмнэлгийн үйлчилгээ, 18.4 хувь нь нийгмийн үйлчилгээ, 7.4 хувь нь бусадтай харилцах, сэтгэл санаагаа хуваалцах, 1.2 хувьд нь санхүүгийн дэмжлэг авах хэрэгцээ гардаг гэжээ. Энэ ч утгаараа ахмад настнуудыг асран халамжлах асуудлыг хөндөх хэрэгцээ буйг харуулж байна.

Ахмад настнуудын дийлэнх хэсэг буюу 42.1 хувь нь гэрийн гадуур дотуур ажлаа зохицуулах, 39.1 хувь нь амьжиргаа, эдийн засгийн асуудал, 18.1 хувь нь үр хүүхэд гэрийнхнээ асардаг байна.

### *2.7Ахмад настны нийгмийн шилжилт, дасан зохицол*

Манай улсын нийгмийн бүтцэд эзлэх тэтгэврийнхний хэмжээ бага биш бөгөөд урьдчилан тогтсон институтчилэгдсэн нөхцөл (эрх зүйн орчин)-ийн дагуу наснаас хамааран хөдөлмөр эрхлэлтийг хязгаарлаж, албадлагын шинжтэй механик байдлаар тус бүлэг бүрдэж байна.

Тэдний эдийн засгийн байдал, санхүүгийн боломж, амьжиргааны түвшин сайжраагүй хэрнээ жил ирэх тусам нэмэгдэж буй өргөн хэрэглээний барааны үнийн өсөлттэй хамааралтайгаар амьжиргааны түвшинд уруудах чиглэлийн өөрчлөлт гарч байна. Түүнчлэн ахмад настнуудын дундах хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хөдөлмөрлөх сэдэл нэмэгдэж байгаа боловч тэдний нас, биеийн онцлогт тохирсон

ажлын байр байхгүй, ажил олгогчид ахмадуудыг ажилд авах хүсэлгүй байдагтай холбоотойгоор хөдөлмөр эрхлэх боломж хомс хэвээр байгаа юм.

Сүүлийн 30 жилийн хугацаанд тэтгэврийнхний боловсролын түвшинд эрс өөрчлөлт гарч дунд болон дээд боловсролтой ахмадуудын тоо жилээс жилд нэмэгдэж, бага болон боловсролгүй ахмадуудын тоо буурч, үе хоорондын босоо шилжилт хөдөлгөөн 80 хувьд нь гарсны 70 орчим хувь нь өгсөх чиглэлтэй байв. Түүнчлэн ажил мэргэжлийн ангиллын дагуу ахмадуудын нийгмийн статусыг авч үзвэл 60 гаруй хувь нь мэргэжилтэн, техникч болон туслах/дэд мэргэжилтэн байсан бөгөөд үе хоорондын босоо шилжилт хөдөлгөөн 80 орчим хувьд нь гарсны 50 хувь нь уруудах чиглэлтэй байв.

Нийгмийн зүгээс ахмадуудыг хүндлэх байдалд тэд сэтгэл дундуур байгаа бөгөөд харьцуулсан мэдээлэл хомс тул өөрчлөлтийн динамикийг гаргах боломжгүй байв. Харин ахмадуудын сэтгэл ханамжийн байдал сүүлийн 10 орчим жилд ойролцоогоор 2 дахин буурчээ.

Нийгмийн шилжилт хөдөлгөөнийг тайлбарладаг онолуудад “хүний насны тодорхой үеүдэд тохиож буй үйл явдлууд нь тэдний нийгмийн байр суурьт дам болон шууд байдлаар нөлөөлдөг... гээд хүүхдийн хөгжлийн үе, сургууль, коллеж төгсөх нас гэх мэтийг жишээ болгон” авч үздэг. Ихэнх тохиолдолд нийгмийн шилжилтийн хөндлөн чиглэлийн, дам нөлөөлөгч хүчин зүйл гэж үзэх нь бий. Харин манай улсын хувьд нас (тэтгэврийн нас) нь хүмүүсийн нийгмийн байр суурьт босоо чиглэлийн, шууд нөлөөлөгч хүчин зүйл болж байна.

Тэтгэвэрт гарснаар хүмүүсийн нийгмийн байр суурь босоо чиглэлд, уруудах хөдөлгөөнд зонхилон орж байна. Түүнчлэн нийгмийн шилжилтийн зай засвар дундаж, харьцангуй нам байгаа ч огцом өөрчлөлт 20 орчим хувьд нь гарсныг анхаарахгүй байж болохгүй. Нийгмийн шилжилт хөдөлгөөн зарим талаар нийгмийн хөгжил, нээлттэй байдлыг илтгэдэг ч уруудах чиглэлийн шилжилт ийм өндөр байх нь тэтгэврийнхний бүлгийн бүрдлийг анхаарч, чиглэсэн бодлого авч хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Наснаас хамааран тэтгэврийн бүлэгт, албан шахалтаар орж буй хүмүүсийн нийгмийн байр суурьт гарч буй хөдөлгөөн, нийгмийн шилжилтэд тэтгэвэрт гарахаас өмнө эрхэлж байсан ажил, хөдөлмөр, суурьшин амьдарч буй бүс нутаг, хот хөдөөгийн

ялгаа, амьжиргааны түвшин, эрүүл мэнд, тэдний бие даасан байдал нөлөөлж буй хүчин зүйлс болж байна.

Нэг талаас, хүн хөдөлмөр эрхлэгчээс тэтгэвэрт авагч болон шилжих нь зайлшгүй тохиолдох зүйл мөн боловч нөгөө талаас, хэзээ тэтгэвэр авагч болох, хэрхэн төлөвлөсөн, ямар үе шатыг дамжиж, хэр дасан зохицсон, түүнд нь юу нөлөөлсөн, тухайн хүн сэтгэл ханамжтай байгаа эсэх зэрэг хувь хүний төдийгүй улс төр, эрх зүй, нийгэм, эдийн засгийн олон талт хүчин зүйлс, нөөцтэй шууд болон дам байдлаар холбоотой. Хүн тэтгэвэрт гарч, тэтгэвэр авагч болох үе шат, түүнд хандах хандлага, тулгарч буй бэрхшээл нь тухайн улсын хүн амын насжилт, эрүүл мэндийн байдал, газар зүйн байрлал төдийгүй уур амьсгалаас эхлээд ахмад настанд чиглэсэн бодлого, явуулж буй үйл ажиллагаа, тухайн үндэстний үнэлэмж, ёс заншил, зан суртахуун гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалан харилцан адилгүй байна. Иймээс манай ахмадуудын тэтгэвэрт гарах үйл явцыг 1) тэтгэвэрт гарахын өмнөх үе, 2) шилжилтийн үе, 3) дасан зохицлын үе, 4) тэтгэвэрт гарсны дараах үе шат хэмээн 4 хуваан авч үзсэн.

1) *Тэтгэвэрт гарахын өмнөх үе.* Энэ үе шатанд байгаа хүмүүсийн 1/3 нь өр зээлтэй, ¾ нь ямар ч хадгаламж хуримтлалгүй, түүнчлэн тэтгэвэрт гараад ямар халамж, үйлчилгээ эдлэх талаар мэдээлэлгүй байгаа зэргийг авч үзэхэд тэтгэвэрт гарсны дараа тулгарах асуудлуудын талаарх урьдчилсан төсөөлөл, тэтгэвэрт гарчихаад хийх зүйлс, өдөр тутмын үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө байхгүй өөрөөр хэлбэл, *тэтгэвэрт гарахдаа бэлтгэх, төлөвлөх үе шат* үндсэндээ орхигдож байна.

2) *Шилжилтийн болон дасан зохицлын үе.* Тэтгэврийн шилжилтийн үед ахмадуудад санхүүгийн (*хөрөнгө мөнгөөр дутагдах, орон байрны нөхцөл тааруу),* сэтгэл зүйн *(ганцаардах, бусдад тоогдохгүй, үнэлэгдэхгүй байх)* болон эрүүл мэндийн асуудал тулгарч байна. Өөрөөр хэлбэл энэ үед байгаа ахмадуудад санхүү, эрүүл мэнд, сэтгэл зүйн байдал доошилсон (25-50%), нийгмийн байр суурь, бусадтай харилцах, олны дунд байх, танилын хүрээ багассан (30%) зэрэг өөрчлөлт мэдрэгджээ. Түүнчлэн тэтгэвэрт гарахаасаа өмнө хөдөлмөр эрхлэлтийн ямар бүлэгт байсан нь тэтгэврийн шилжилтийн үед төдийгүй, дасан зохицлын үед ч чухал ач холбогдолтой байв. Эл үе шатад хамаарч буй дасан зохицоогүй болон дасан зохицож эхэлж буй

ахмадуудын ойролцоогоор 70 орчим хувь нь сэтгэл ханамж тааруу, эсхүл ханамжгүй байна.

3) *Тэтгэвэрт гарсны дараах үе.* Тэтгэвэрт гарсны дараа ахмадуудын амьдралын суурь хэрэгцээ (хооллолт, хувцаслалт, орон байр, сууцны нөхцөл), хувийн аюулгүй байдал харьцангуй тогтвортой байдаг бол санхүү, эрүүл мэндийн байдал, танилын хүрээ, нийгмийн харилцаа нэлээд өөрчлөгддөг байна. Эдгээр өөрчлөлтүүдийн дийлэнх нь сөрөг өөрчлөлт байгааг анхаарах шаардлагатай. Тэтгэврийн дараах үе шатад хамаарч буй ахмадуудын сэтгэл ханамжгүй байдал (14.8%) шилжилтийн болон дасан зохицлын үеийнхнээс ойролцоогоор 30-50%-иар бага бол сэтгэл ханамжтай (85%) байх нь мөн л 30-50%-иар өндөр байна.

Тэтгэврийн дараах дасан зохицох нөөцөд суурилсан динамик загварын үүднээс бие махбодийн, танин мэдэхүйн, эдийн засгийн, нийгмийн, сэтгэл зүйн, бие даасан байдлын гэсэн 6 нөөцийн тус бүр хоёр индикаторыг сонгон авч эерэг (+1), сөрөг (-1) утга өгөн, нэгдсэн үзүүлэлтийг тооцож сайн дасан зохицсон (өндөр нөөцтэй, сайн нөөцтэй), харьцангуй дасан зохицсон (нөөцтэй), дасан зохицоогүй (нөөцийн дутагдалтай) гэсэн гурван хэв маягт хуваасан.

Судалгааны дүнгээс харахад манай ахмадуудын тэтгэврийн дараах дасан зохицолд 1) хувь хүний сэтгэл ханамж, биеийн эрүүл мэнд, эрүүл дадал хэвшил, боловсролын түвшин, 2) тэтгэвэрт гарахаасаа өмнө эрхэлж байсан ажил, 3) өөрийн төрүүлсэн хүүхэд бий эсэх, үр хүүхэд нь тусалж дэмждэг байдал, гэр бүлийн зарим хэв маяг, 4) хуулиар тогтоосон тэтгэврийн насандаа тэтгэвэрт гарсан эсэх, 5) тэтгэвэрт гарснаасаа хойш болон одоо ажил хийж байгаа эсэх, чөлөөт цагаа өөртөө зарцуулж, чанартай өнгөрүүлж буй байдал, 6) суурьшил, 7) нийгмийн оролцоо ба гишүүнчлэлийн байдал зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

### *2.8 Ахмад настанд хандах хандлага ба ялгаварлан гадуурхалт*

1990 онд дэлхий даяар насжилтыг нийгмийн үзэгдэл хэмээн хүлээн зөвшөөрч судлах үйл явц эрчимжсэнээр насжилтын социологи болон нийгмийн геронтологи хурдацтай хөгжсөн. Монгол Улсад 1950-иад оноос эхлэж хүн ам хурдацтай өссөн бөгөөд тухайн үед төрсөн хүүхдүүд өнөөдөр ахмадын эгнээг тэлж байна. Манай оронд ахмад, өндөр настны талаар социологийн үүднээс хийгдсэн дорвитой судалгааны

ажил байхгүй байсан учраас бусад орны судлаачдын судалгааны ажил, арга зүй, үр дүнгийн талаар түлхүү судалж, авч үзлээ. Насжилтын социологи болон нийгмийн геронтологийн хүрээнд насжилтын талаарх хэд хэдэн онол гаргасан ч эдгээр нь насжилтын үзэгдлийг цогцоор нь авч үзээгүй байна. Учир нь насжилт нь зөвхөн социологи, нийгмийн геронтологи гэх мэт аль нэг шинжлэх ухааны салбарын обьект бус бөгөөд түүнийг олон талаас нь судлах шаардлагатай. Ирээдүйд тухайн нийгмийн асуудал улам их ач холбогдолтой болох төлөвтэй байна.

Ахмадын талаарх ойлголт төсөөлөл тухайн нийгмийн уламжлал, соёл, эдийн засгийн байдлаас хамаардаг. Ахмад насны талаарх ойлголт төсөөлөл нь дэлхий даяар сөрөг хэвшмэл ойлголтыг агуулдаг учраас эйджеизм гэсэн нэр томьёог боловсруулж гаргасан юм. Насаар ялгаварлан гадуурхах үзэгдэлтэй тэмцэх шаардлага дэлхийн улс орнуудад нийтлэг тулгарч байна. Ахмад хүний талаарх сөрөг төсөөлөл, буруу хэвшмэл ойлголтыг өөрчлөх шаардлага манай нийгэмд ч тулгараад байна. Ахмад настнаа үл хүндлэх, ялгаварлан гадуурхах үзэл хандлагыг хазаарлах, гаргахгүй байлгах талаар анхаарч, төрийн бодлогын түвшинд авч үзэхгүй бол энэ асуудал нь ахмад настны нийгмийн харилцаа, нийгмийн оролцоог хязгаарлаж, эрүүл мэнд доройтох, өөрийн үнэлэмж буурах, сэтгэл гутралд хүргэх зэрэг олон талын сөрөг нөлөө ахмад настнуудад үзүүлэхийн зэрэгцээ нийгэмд тэгш бус байдал улам гүнзгийрч, нийгмийн нэгдэл нягтралд алдагдахад хүргэнэ.

Ялгаварлан гадуурхах хэд хэдэн хэлбэр байдаг бөгөөд манай ахмадууд олон төрлийн ялгаварлан гадуурхалтанд өртөж байна. Зөвхөн нас гэлтгүй гадаад үзэмж, амьжиргааны түвшнээр ялгаж хандах явдал ажиглагдаж байна.

Монгол Улсын Ахмадын холбооны дотоод мэдээ, судалгааны дагуу 2017 оны байдлаар нийт 277 мянган ахмад настан Монгол Улсад байгаагаас 70 хүртэл настай нь 183.4 мянга, 71-80 настай нь 99.4 мянга, 81-90 настай нь 17.1 мянга, 91 ба түүнээс дээш настай нь 2.3 мянга ажээ. Тэдгээрийн 16.7 хувь нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур, мөн 3963 ахмад настан ганц бие, харж хандах ах дүүгүй, 7815 ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй, хэвтэрт, 18.4 мянган ахмад настан бусдын байнгын

асрамжинд байгаа юм[21]. Монгол Улсад ахмадуудыг зөвхөн асарч халамжлах бус, ажлын байраар хангах, тэдний хүч хөдөлмөрийг нийгэмд ашиглах хэрэгцээ илүү их байгаа болно. Түүнчлэн насаар ялгаварлан гадуурхалтын эсрэг оновчтой хууль тогтоомж гаргаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр насжилтын талаарх зохистой мэдээлэл, мэдлэг олгох шаардлагатай байна.

### *2.9 Ахмад настны өнөөгийн байдал, нийгэмд эзлэх байр суурь, цаашдын хандлага*

2022 оны 01-р сарын 01-ний байдлаар нийгмийн даатгалын сангаас 353775 мянга, нийгмийн халамжийн сангаас 8 мянга шахам ахмад настан тэтгэвэр авч хөдөлмөр эрхэлж байсан хүмүүсийн улсын дундаж тэтгэвэр 547.2 мянган төгрөгт хүрч өмнөх 5 жилийнхээс 50 гаруй хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын багц хуулиуд, Ахмад настны тухай хуульд үнэ инфляцийн өсөлт, амьжиргааны өртгийн өөрчлөлт, цалин хөлсний хэмжээтэй уялдуулан тэтгэврийг жил бүр итгэлцүүр /индекс/-ээр нэмэгдүүлэн өөрчлөн тогтоож байхаар заасан боловч, энэхүү хуулийг үе үеийн Засгийн газрууд хэрэгжүүлээгүй байснаас тэтгэврийн зөрүү улам ихэсч ахмадууд бухимдсаар байсан билээ. Ийм хүнд нөхцөл байдлыг үндэслэн Монголын ахмадын холбооноос Улсын их хурал, Засгийн газарт тэтгэврийн зөрүүг арилгах, хэмжээг нь нэмэгдүүлэх шаардлага хүргүүлсэн юм.

2022 оны 2 дугаар сард Засгийн газар тогтоол гаргаж бүх төрлийн тэтгэврийг 15 хувиар нэмэгдүүлж бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийнхийг 400.000 төгрөг болгож өсгөн 637.3 тэрбум төгрөг нэмж зарцуулахаар улсын төсөвт тодотгол хийсэн билээ. Энэхүү арга хэмжээгээр 197.1 мянган хүний тэтгэвэр 52.1 мянгаас дээш төгрөгөөр, 72.3 мянган хүний тэтгэвэр 100.0 мянган төгрөгөөр, 200.0 мянган хүний тэтгэвэр 150.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнд ихэнх ахмадууд талархаж байна.

Гэвч тэтгэврийн зөрүүг арилгах, нэмэгдүүлэх шаардлагыг хэрэгжүүлэхдээ ахмадуудын анх тэтгэвэр тогтоолгосон цалинг нь өнөөгийн адил мэргэжил, адилхан

[21] Ц.Сүхбаатар. Монголын ахмадуудын өнөөгийн байдал, цаашдын хандлага зорилтын тухай. //Ахмадуудын нийгэм-эдийн засгийн байдал, цаашдын хандлага. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. ШУА-ийн Философийн хүрээлэн, Монголын Ахмадын холбоо. УБ., 2019. 22 дахь тал.

албан тушаалын цалинтай хүмүүсийн цалинтай дүйцүүлж тооцсон итгэлцүүрээр тэтгэврийг нь өөрчлөн бодоогүй харин ч өндөр цалин тэтгэвэртэй болон бага тэтгэвэр авч байгаа хүмүүсийг адилхан 15 хувиар нэмж доод хэмжээг хэт өндөрсгөж 500.0 мянган болгосон нь тэтгэврийн зөрүүг арилгаж чадаагүй шударга бус болсон гэж шүүмжилсээр байна. Ялангуяа 350.0-700.0 мянга хүртэл төгрөгийн тэтгэвэр авч байсан 80.0 шахам мянган ахмад настан хэт шударга бус нэмэгдүүлсэн. Тухайлбал 350.0 мян.төгрөг авч байсан хүн 150.0 мян төгрөгөөр нэмэгдэж байхад 600.0 мян.төгрөгийн тэтгэвэртэй хүн 90.0 мян.төгрөгөөр нэмэгдэх жишээтэй шударга бус болсон юм.

2022 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 339993 ахмад настан байгааг наслалтын байдлаар авч үзвэл 69 хүртэл настай 237311, 70-79 настай 63181, 80-89 настай 21588, 90-99 настай 2710, 100 ба түүнээс дээш настай 140 ахмад настан байна. Нийт ахмадуудын дотор хөдөлмөрийн баатар 158, ахмад дайчин 604, ардын болон гавьяат цолтон 1222, алдарт эхийн одонтой 116582 эхчүүд амьдарч ахмад настнуудаа болон залуу хойч үеэ үлгэрлэн манлайлсаар байна.

Ахмад настнуудын амьжиргаа нь жил тутам буурч, 23.6 хувь нь эмзэг бүлэгт хамрагдаж 26.8 мянган ахмад настан амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой, 5.8 мянган ахмад харж хандах хүнгүй ганц бие, 13.6 мян.ахмад настан бусдын байнгын асрамжинд байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй 7870 ахмад настан байна.

Улс орны эдийн засгийн байдал сүүлийн жилүүдэд дордож гадаадын хөрөнгө оруулалт хумигдаж, валютын ханш өсч, бараа бүтээгдэхүүний үнэ өдөр тутам нэмэгдэж ахмадуудын нэмэгдсэн тэтгэвэр нь амьжиргааны наад захын хэрэгцээг хангаж чадахгүй ахмадуудын амьдралд хүндээр тусч улмаар эмчилгээ халамжийн үйлчилгээний чанар, хүртээмж муудсаар байна. Ахмад настан байгаа өрхөд дунджаар 4 хүн амьдарч тэд тэтгэврээр тэжээлгэж тарчигхан амьдарч буй өрх айл олон байна.

Эдийн засгийн өсөлт, байгалийн баялаг ашигласны орлогоос ахмад настнууд хувь хишиг тэгш хүртэж чадахгүй эмзэглэж, цар тахлын улмаас болон жил тутам 8.3 мянга гаруй ахмад нас барж, хэдхэн жилийн өмнө 20 шахам мянга байсан ахмад дайчид өнөөдөр 300 гаруйхан болж хорвоогийн мөнх бусыг үзүүлж 1939 оны Халхын голын байлдаанд оролцсон ахмад настан бараг байхгүй болжээ. Эдгээр ахмадууд

тэтгэврийн зөрүүгээ ч аваагүй, Төрийн халамж үйлчилгээнд хамрагдаж чадаагүй ахмадууд билээ.

Монгол Улсын Их Хурлаас 2017 онд баталсан “Ахмад настны тухай” хууль нь зөвхөн нийгмийн халамжийн бодлого, үйл ажиллагааг зохицуулж байсан урьдах хуулийн үзэл баримтлалыг өөрчилж, ахмад настны эдлэх эрхийг хуульчлан баталгаажуулж, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл хүртээмжийг сайжруулах, ахмад настны нийгмийн хамгааллын талаар урд өмнө авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрсэн түвшинг дордуулахгүйгээр, харин ч халамж үйлчилгээ, дэмжлэг тусламж, хүндэтгэлийн нэр төрөл, хамрах хүрээг өргөжүүлсэн олон чухал заалтуудыг хуульд нэмж тусгаснаараа олон улсын байгууллагаас тогтоосон хэм хэмжээнд нийцсэн Монгол төрийн бодлогын чухал баримт бичиг болсон.

Ахмад настны хууль мөрдөгдсөнөөр ахмад настнуудын өмнө тулгамдсан бүх асуудал нэг мөр шийдэгдэж сайн сайхан болчихно гэсэн үг хараахан биш билээ. Цаашид эрдэмтэн судлаачдын судалгаа, дүгнэлт, ахмад настнуудын өөрсдийнх нь санал хүсэлтэнд үндэслэн нэн тэргүүн гол асуудалд анхаарлаа хандуулж бодлогоо зөв тодорхойлж холбогдох арга хэмжээ авахуулах нь зүйтэй гэж Монголын ахмадын холбоо үзэж байна. Үүнд:

**Нэгдүгээрт**, тэтгэврийн асуудалд урьдын адил онцгой анхаарч жил бүр жигд арга хэмжээ авах нь зүйтэй. Одоо үнэ тариф (инфляци) улам нэмэгдэж ахмадуудын амьдралд хүндээр тусч, эдийн засаг улам сөхөрч, өр зээлэнд баригдаж, улсын сан хөмрөг хэцүү байна энэ хүндхэн үед тэтгэврийнхээ ахмадуудыг орхилгүйгээр эдийн засаг сэргээж, зөв бодлого явуулдаг байх хэрэгтэй.

2000 оноос өмнөх үеийн үйлчлэгч, багш, эмч, хотын дарга байсан хүмүүс, өнөөдөр эдгээр ажил мэргэжил, албан тушаалыг хашиж байгаад тэтгэвэрт гарсан хүмүүсээс олон зуун мянган төгрөгөөр бага тэтгэвэр авч ирсэн нь дэндүү шударга бус байна. Үүнийг засах ганц арга бол тухайн үеийн ажил мэргэжил, албан тушаалын бага цалинг одоогийн адил ажил, мэргэжлийн албан тушаалтны цалинд ойртуулсан тооцооны итгэлцүүр /индекс/ тогтоож түүгээрээ тэтгэврийг нь өсгөн нэмэгдүүлж, шинэчлэн тогтоох замаар тэтгэврийн зөрүүг арилгах шийдвэртэй алхам хийх шаардлагатай байна.

**Хоёрдугаарт**, ахмад настны эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулахад онцлон анхаарах шаардлагатай. Ахмад настнууд эмнэлэгт оочерлоод анхны тусламж авч чадахгүй нас барах, хэвтэх болоход ор байхгүй, эм үнэтэй, хүрэлцээ хангамж муу, эмнэлгийн үйлчилгээ чирэгдэл, хүнд сурталтай болсныг ахмадууд шүүмжилж бухимдсаар байна. Эрүүл мэндийн байгууллага нь ахмад буурлууддаа хүндэтгэлтэй хандаж, шуурхай, хүртээмжтэй үйлчилдэг болмоор байна. Эмийн үнийг улсын хяналтанд авч, ахмадуудын байнга хэрэглэдэг эмийг үнэ төлбөргүй болгох буюу эмийн үнийн хөнгөлөлтийн хэмжээг нь нэмэгдүүлэх, тусгайлсан эмийн сангаар үйлчлэх, ахмадад зориулагдсан тусгай эмнэлэг байгуулах буюу нэгдсэн эмнэлгүүдэд ахмад настны хэвтэж эмчлүүлэх орны лимит тогтоож, тасаг нээх, өрхийн эмнэлэг ахмадын орон тооны мэргэжлийн эмч, сувилагч бий болгож, хэвтрийн өвчтэй, эмнэлэг тэр бүр ирж үйлчлүүлж чадахгүй ахмадуудыг гэрээр нь эмчлүүлж, сувилах үйлчилгээг чанарын өндөр түвшинд үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ нэн даруй авах шаардлагатай байна.

**Гуравдугаарт**, ахмадын орон сууцны асуудлыг ойрын жилүүдэд төрөөс бодлогоор дэмжиж нэг мөр шийдвэрлэх шаардлагатай байна. Ахмадын орон сууцны асуудлыг нийслэлд эхлүүлж, түрээсийн нэртэйгээр 300 гаруй ахмад настанд орон сууц олгосон боловч нас барахаар нь хураан авч үр, ач нарыг нь гомдоох, ахмад настанд зориулж барьсан орон сууцыг гэр хорооллын дахин төлөвлөлтөөр орон гэргүй болсон иргэдэд шилжүүлэн эзэмшүүлэх болсон зэрэг нь ахмадуудыг ихээхэн гомдоож, бухимдалд оруулсныг зориуд тэмдэглэн хэлье. Ахмад настанд түрээсээр олгосон орон сууцыг хувьчилж үнэ төлбөргүй өөрт нь өгөх, 1990 оноос өмнө нийгэмд үр бүтээлтэй хөдөлмөрлөж, улсаас хувьчлалаар орон сууц аваагүй ахмадууд болон ялангуяа эцэг эх нь хэлмэгдэж цаазлагдсан 80, 90 насалсан цөөн ахмадууд, тухайн үедээ орон сууц аваагүй ахмад дайчны гэр бүлд төрөөс орон сууц үнэ төлбөргүйгээр яаралтай олгох, ахмадын орон сууцны фондыг жил бүр тогоож 2021-2025 онд ахмадуудын орон сууцны асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар төр, засаг бодлогоо тодорхойлох шаардлагатай гэж үзэж байна.

**Дөрөвдүгээрт**, Нийгмийн даатгалын, Хөдөлмөрийн, Төрийн албаны тухай хуулиудад тэтгэвэрт гарах насыг 60 ба 55-аар тогтоосон байдаг. Гэтэл аж ахуйн нэгжүүд 55 настай эмэгтэй, 50 настай олон хүүхэдтэй эхчүүд, 50, 60 настай төрийн

албан хаагчдыг 60, 55, 50 нас хүрэнгүүт нь захиргааны санаачилгаар шууд ажлаас нь халчихдаг явдал газар авч байна. Тэрчлэн тэтгэвэр тогтоолгосон хэдий ч ажлын өндөр чадвартай ахмадуудыг ажилд авахгүй гадуурхаж тэдний ажлын арвин баялаг туршлага, мэдлэг, чадварыг хойч залуу үедээ өвлүүлэн эзэмшүүлэх чиглэлээр огт санаачилга гарахгүй байна. Иймд Ахмад настны тухай хуулийг бүтээлчээр хэрэгжүүлж, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний сүлжээ, бүртгэлийг улсын хэмжээнд буй болгон, ахмадуудын зөвлөх баг, хэсэг бүлэг байгуулж залуу мэргэжилтнүүдийг сургах, хамтран хөдөлмөр эрхэлж орлогоо нэмэгдүүлэх боломжийг тэдэнд нээн өгч байх асуудлыг жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сан, хөдөлмөр эрхлэлтийн сангаар дамжуулан хэрэгжүүлэх замаар ядуурал, ажилгүйдлийг бууруулж, ахмадуудын орлогыг нэмэгдүүлэх бодит арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

**Тавдугаарт**, ганц бие болон хэвтрийн, тахир дутуу ахмад настны тоо олширч, гэр оронгүй ахмадууд нэмэгдсээр байна. Үүнээс болж өнчрөл гансрал, ганцаардал бодит үзэл болох шинж ахмадуудын дунд бий боллоо. Нөгө талаар, хууль ёсны үр хүүхэд, ах дүү нь байгаа боловч, эцэг эх, өтгөс буурлуудаа харж хандах үүргээ биелүүлдэггүй зайлсхийх, үр хүүхэд нь эцэг, эхээ гадуурхан хавчих, хөөж туух, тэр бүү хэл зодох, амь насанд нь халдах, эд хөрөнгө тэтгэврийг нь завших зэргээр гэр бүлийн болон эрүүгийн хуулийг зөрчсөн, хүнлэг бус, бурангуй үзэгдэл цөөнгүй гардаг болжээ. Мөн энэ төрлийн зөрчлийн талаарх бодит мэдээлэл ч хомс байна. Ахмадуудын эрхийг зөрчүүлэхгүй байх, хамгаалалтанд байлгаж, хуульд заасан тэдний эмчилгээ, асаргаа, халамж үйлчилгээ, хөнгөлөлт эдлэх эрхийг төлөөлөн хамгаалах оновчтой зөв тогтолцоог төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоотойгоор шинээр бүрдүүлэх талаар онцлон анхаарах шаардлагатай болсон байна.

**Зургаадугаарт**, Азийн орнуудын туршлагаас суралцаж бие даан амьдрах чадваргүй болон өөрсдийнхөө хүсэлтээр асрамж халамжийн үйлчилгээ авахыг хүссэн ахмад настнуудад нийгмийн хамгааллын дунд болон урт хугацааны хөтөлбөр гарган тэдэнд төрийн болон сайн дурын үйлчилгээ үзүүлэх, тэдэнд зориулсан асрамж, халамжийн үйлчилгээний шинэ төвүүд байгуулах, үүнд хувийн хэвшлийг татан оролцуулж төрөөс дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

### *2.10 Судалгааны үр дүн*

Суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд “Ахмад настны социаль асуудал: үр дагавар, төлөв хандлага” хамтын бүтээл (24х.х) хэвлэгдсэн. Нийт эрдэм шинжилгээний 12 өгүүлэл, сурталчилгааны 3 өгүүлэл, 23 илтгэл, 1 судалгааны тайлан (13х.х), гаргасан.

Судалгааны үр дүнгээр санал зөвлөмж боловсруулж, УИХ, ЗГХЭГ, БШУЯ, НХХЯ-нд явуулсан.

*Tsetsenbileg Ts.*
Ph.D., Leading Researcher at the Institute of Philosophy,
Mongolian Academy of Sciences
Baruun Selbe-15, Chingeltei district, Ulaanbaatar, Mongolia
E-mail: tsetsenbileg@yahoo.com

*Purevkhand J.*
MA., Researcher at the Institute of Philosophy,
Mongolian Academy of Sciences
Baruun Selbe-15, Chingeltei district, Ulaanbaatar, Mongolia
E-mail: j.purevkhand@gmail.com

*Azbayar B.*
MA., Researcher at the Institute of Philosophy,
Mongolian Academy of Sciences
Baruun Selbe-15, Chingeltei district, Ulaanbaatar, Mongolia
E-mail: b.azbayar88@gmail.com

***Abstract:*** This article is intended to investigate the state of democratic responsibility in elderly's rehabilitation services. The study applies IDEA international methodology on assessment of Democratic Accountability in Service Delivery, which is measured according three principles: answerability, responsiveness and enforceability. The article is based on findings of qualitative research among elderly people who took service and duty bearers, service providers. The study is imperative for evaluation existing policies and their implementation in order to develop policy recommendations for enhancing public service delivery.

***Key words:*** Democratic accountability in service delivery; answerability; responsiveness; enforceability; rehabilitation service.

Монгол Улсад Нийгмийн зүгээс зайлшгүй дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдийг төр ивээлдээ авч, амьдралын баталгааг нь алдагдуулахгүй байх зорилгоор 1995 онд Нийгмийн халамжийн анхны бие даасан хуулийг УИХ-аас батлан, хэрэгжүүлснээс хойш 20 гаруй жил өнгөрчээ. Өнгөрсөн

[33] 2016-2018 онд Нийслэлийн засаг даргын тамгын газар, ШУА-ийн Философийн хүрээлэн, Нийслэлийн нийгмийн халамжийн газар, иргэний нийгмийн байгууллагууд хамтран Ардчилалд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (IDEA)-ийн төрийн үйлчилгээний ардчилсан эгэх хариуцлагыг үнэлэх арга зүйг ашиглаж "Улаанбаатар хотын төрийн үйлчилгээний эгэх хариуцлагын үнэлгээ"[33] төслийн хүрээнд гурван үйлчилгээнд үнэлгээ хийлээ.

хугацаанд Нийгмийн халамжийн багц хуульд хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан ба халамжийн чиглэлийн шинэ хуулиудыг ч нэмж баталжээ. Одоо нийгмийн халамжийн чиглэлээр 5 хуулийг дагаж мөрдөж байна. Эдгээр хуулийн хүрээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, алдар цолтой ахмад настан, хүүхэд, эхчүүд болон нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэдэд төрөөс тэтгэвэр, тэтгэмж олгож, тусламж, үйлчилгээ үзүүлж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээг тэтгэврийн насны иргэдийн 70 хувь нь хүртэж, арга хэмжээг 100 хувь улсын ба орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээг жилд дунджаар нийтдээ 730.0 мянга орчим иргэн хүртэж байна[34].

Ахмадын сэргээн засах үйлчилгээ нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрөл бөгөөд эл үйлчилгээнд 2017 онд нийслэлийн нийгмийн халамжийн газартай 32 байгууллага гэрээ байгуулан ажилласан бөгөөд эхний 11 сарын байдлаар 820 ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан байна[35].

Ахмад настны сэргээн засах үйлчилгээний үнэлгээ, түүний ил тод байдалд хийсэн шинжилгээг танилцуулахын өмнө ашигласан онолын тоймыг цухас дурдая. Сэргээн засах үйлчилгээ нь нийгмийн халамжийн үйлчилгээний нэг төрөл учир тус өгүүлэлдээ нийтийн сайн сайхны төлөө гэх онолыг иш үндэс болгон ашиглалаа.

Нийтийн сайн сайхны төлөө онолыг их олон янзаар тайлбарладаг. Тэр дундаа америкийн социологич Виленски “Нийтийн сайн сайхны төрийн мөн чанар нь буяны болон хүмүүнлэгийн үйл биш, харин нийгмийн эрх болохын хувьд иргэдэд баталгаажуулж буй орлого, хоол хүнс, эрүүл мэнд, аюулгүй байдал, боловсрол болон орон сууцны засгийн газраас хамгаалагдсан минимум стандарт”[36] хэмээн тодорхойлжээ. Төрийн зүгээс үйлчилгээ үзүүлэх эсвэл орлого дэмжих зэргээр өөрийн иргэдийн сайн сайханд шууд нөлөө үзүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй бодлого бөгөөд түүний цөмийг нийгмийн даатгал, нийгмийн тусламж, эрүүл мэнд, халамжийн үйлчилгээ орон сууцны бодлого бүрдүүлдэг. Өргөн утгаараа нийгмийн бодлого нь нийгмийн хамгаалал болон бусад бодлогыг багтаадагынхаа хувьд хүний амьдралын бүхий л үеүдийг институтчилэх, хэвийнжүүлэх арга хэрэгсэл юм. Нийгмийн хамгааллын талаар бүтэц чиг үүргийн, хүчний эх сурвалжийн, институцийн гэсэн 3 онол арга зүйн чиг хандлага байдаг. Институцийн хандлагын гол ялгаа нь нийгмийн хамгаалал болон ардчиллын хоорондын хамаарлыг шинжилдэгт оршдог. Аль нэг анги, бүлгийн ашиг сонирхол, зохион байгуулалт гэхээсээ, аливаа олонх болж буй бүлгүүдийн зүгээс зах зээлийн үеийн ядуу, эмзэг бүлгүүдэд нийгмийн баялгын хуваарилалт хийхийг ямагт дэмждэг. Ардчилал өөрөө олонхийн шаардлагыг сөрж чаддаггүй тийм мөн чанартай институц тул чухамдаа ардчиллын үед л хүн амын нийгмийн баталгааг хангах шийдвэрүүд өөр ямар ч улс төрийн дэглэмийн үед байхгүйгээр олноор төрөн гарна. Институцийн хандлагын сүүлийн

---

[34] Нийгмийн халамжийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар УИХ-ын чуулганд мэдээлэл. //Https://zasag.mn/news/view/15613.

[35] Ахмад настны сэргээн засах үйлчилгээний эгэх хариуцлагын үнэлгээ. Судалгааны тайлан. //ШУА-ын Философийн хүрээлэн. 2018.

[36] Г.Түмэннаст. Монголын нийгмийн халамжийн өнөөгийн тогтолцоонд хийсэн социологийн шинжилгээ. Докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2017. 20 дахь тал.

үеийн судалгаанд нийгмийн хамгааллын бодлогын хөгжил дэх үзэл санааны үүргийн талаар онцолж байгаа бөгөөд энэ шинэ урсгалыг дискурсын институцийн үзэл гэж нэрлэдэг. Нийтийн сайн сайхны төр болон олон нийтийн хандлага хоёрын хамаарлыг эмпирик байдлаар үндэслэн гаргасан ба энэ нь олон түмний улс төрийн итгэл үнэмшлээс хамаардаг. Судлаач Гелссон "Нийтийн сайн сайхны төрийн ертөнцүүд бол олон түмний зөвшөөрлийн ертөнцүүд мөн" болох талаар судлан дэвшүүлсэн[37]. Тиймээс бид ардчилсан эгэх хариуцлагын үнэлгээний аргачлалыг энэ онолын чиг хандлагын дагуу авч үзсэн.

Ардчилсан эгэх хариуцлага нь иргэд, тэдний төлөөлөгч сэтгэл түгшсэн асуудлаар тайлбар өгөхийг шаардах, шаардлагатай тохиолдолд сонгуульт болон сонгуульт бус албан тушаалтанд шийтгэл ногдуулах механизмыг санал болгодог[38] бөгөөд өнөө үед их ач холбогдолтой аргачлал юм. Төрийн үйлчилгээний талаар иргэд албан хаагчдад асуулт тавьж, санал хүсэлтээ илэрхийлж, харин улс төрийн албан тушаалтан, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, ажилтан тухайн санал хүсэлтийн дагуу ажиллаж, үр дагаврыг нь амсаж байвал төрийн үйлчилгээнд ардчилсан эгэх хариуцлага байна гэж хэлж болно[39] гэж үздэг. Бидний ашигласан ардчилсан эгэх хариуцлагыг үнэлэх аргачлал нь ардчилсан зарчим, бодлогын үйл явцын хоорондын уулзварт голчлон анхаардаг бөгөөд ардчилсан дадал зуршил сайтар хэрэгжиж буй эсэхийг судалдаг билээ. Бид энэ аргачлалыг төрийн үйлчилгээнийн ардчилсан эгэх хариуцлагыг үнэлэх арга зүйг нутагшуулах, цаашдын үнэлгээний жишиг болгох, чанар, хүртээмжийг сайжруулахад зорилгоор ашигласан болно.

*Ахмад настны сэргээн засах үйлчилгээнд ардчилсан эгэх хариуцлага хэрхэн хэрэгжиж буйг тодруулахын өмнө уг үйлчилгээний эрх зүйн орчинг товч тоймлон үзье.*

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас 2005 онд батлахдаа олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэмэлт өөрчлөлтөөр оруулснаар, 2006 оноос эхлэн нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлагад үндэслэсэн нийгмийн халамжийн шинэ үйлчилгээ болон хэрэгжиж эхэлсэн. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын оролцоотойгоор 12 бүлгийн өрх, иргэнд[40] арван төрлийн дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа юм. Бид олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэг төрөл болох сэргээн засах үйлчилгээг сонгон авч ардчилсан эгэх хариуцлага хэрхэн байгааг үнэлсэн.

Сэргээн засах үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.8-д заасны дагуу магадлан итгэмжлэх журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталдаг[41]. Нийслэлийн нийгмийн халамжийн газар сэргээн засах үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын дунд жил бүр тендер зарлан сонгон шалгаруулдаг бөгөөд

---

[37] Г.Түмэннаст. Монголын нийгмийн халамжийн өнөөгийн тогтолцоонд хийсэн социологийн шинжилгээ. Докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2017. 20 дахь тал.

[38] Democratic Accountability in Service Delivery. A practical guide to identify improvements through assessment. Sweden. 2014, P. 17-18.

[39] Мөн тэнд.

[40] Нийгмийн халамжийн тухай хууль. 2012 оны шинэчилсэн найруулга. //https://www.legalinfo.mn/law/details/393?lawid=393&sword=%D1%83%D1%80%D0%B0%D0%BC%D1%88%D1%83%D1%83%D0%BB%D0%BB%D1%8B%D0%BD 2018.9.25

[41] Мөн тэнд.

тендерт “Магадлан итгэмжлэлийн гэрчилгээ” авсан байгууллагууд оролцох эрхтэй. Иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ. Ингэж тендерт шалгарсан аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон дүүргүүдийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний хэлтэстэй 3 талт хамтын үйл ажиллагааны гэрээ байгуулан ажилладаг. Үйлчилгээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эдгэшгүй хүнд өвчтэй хүн, гэр оронгүй тэнэмэл иргэд, өрх толгойлсон эцэг эх гэх мэт 9 зорилтот бүлгийн иргэн хамрагдах боломжтой. Ахмад настны сэргээн засах үйлчилгээний үнэлгээ, тэр дундаа ил тод байдлыг тодруулахыг зорьсон энэхүү өгүүлэлдээ тус судалгааны хүрээнд хийгдсэн чанарын судалгааны дүнд шинжилгээ хийх замаар судалгааны үр дүнг танилцуулахыг зорив. Эл судалгааг нийслэлийн төвийн дүүргүүд болох Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул, төвөөс алслагдмал Налайх, Багануур дүүргийг сонгон авч фокус бүлгийн болон экспертийн ярилцлагын аргаар хийсэн. Ингэж цуглуулсан чанарын мэдээлэлд шинжилгээ хийлээ. Ярилцлагад оролцогчдыг сонгохдоо сонгогдсон хорооны нийгмийн ажилтан, хорооны засаг дарга болон ажилтнуудын туслалцаатайгаар фокус бүлгийн ярилцлагыг 3 удаа, нийтдээ 24 ахмад настны дунд зохион байгуулав. Харин экспертийн ярилцлагыг нийслэл, дүүрэг, хороодын олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон ахмадын асуудал хариуцсан мэргэжилтнээс авч дүн шинжилгээ хийсэн болно.

*Ахмад настны сэргээн засах үйлчилгээн дэх ил тод байдал.* Ил тод байдал бол төр, иргэдийн болон төрийн байгууллага хоорондын үйл ажиллагаа, төлөвлөлт, удирдлага, үүрэг амлалтын талаар нээлттэй, үнэн зөв, хүртээмжтэй мэдээлэл авах боломжийг илэрхийлдэг бол оролцоо нь эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, бодлогын үйл явцад нөлөөлөх зэрэг хүний эрхийг дагуулна[42].

Сэргээн засах үйлчилгээний ил тод байдлыг тоо, чанарын судалгаанд оролцогчдын үнэлгээгээр гаргах ба чанарын судалгаанд оролцогчдоор тус үйлчилгээг үзүүлж буй үүрэг хүлээгч талууд нэг талаас төрийн байгууллага, нөгөө талаас хувийн хэвшил буюу үйлчилгээ үзүүлж буй ААН-үүдийг мэдээлэл, тайлбар, сурталчилгаагаа хэрхэн хүргэж буйг тодруулсан. Үүрэг хүлээгч талууд ахмадуудад дараах хэлбэрээр мэдээлэл хүргэж байна.

*Хүснэгт 12. Мэдээлэл өгч буй хэлбэр*

| № | | **Мэдээлэл хүргэх хэлбэр** |
|---|---|---|
| 1 | Төрийн байгууллага (ХХҮЕГ, ННХГ, ДХХҮХ) | Сайт дээрээ тавьдаг. |
| | | Хороо, дүүргийн мэргэжилтнүүд ч тарааж байдаг. |
| | | Нээлттэй, тайлан мэдээллээ шилэн дансандаа байрлуулна. |
| | | Ахмадын холбоо, ахмадын зөвлөлийн даргаар дамжуулдаг. |
| | | Хэсгийн ахлагч нар |
| 2 | Хувийн хэвшил буюу сэргээн засах үйлчилгээ үзүүлж буй ААН | Ам дамжсан яриа |
| | | Хороо, дүүргийн мэргэжилтнүүд ч тарааж байдаг. |
| | | Сошиалаар, зурагтаар (ховор) гэх мэт мэдээллийн сүлжээг ашигладаг |

[42] Democratic Accountability in Service Delivery. A practical guide to identify improvements through assessment. Sweden. 2014, P. 17-18.

Үүрэг хүлээгч талууд мэдээллээ ихэвчлэн цахим хуудас дээрээ байршуулж, хорооны хэсгийн ахлагч нараар дамжуулан хүргэдэг байна. Харин иргэдийн хувьд мэдээлэл муутай ихэнх үйлчилгээг мэдэхгүй байлаа.

Байгууллагын ажилтнууд өдөр тутмын үйл ажиллагааныхаа талаар тайлангаа алба, хэлтэсийн дарга нартаа цаашлаад дээд шатны байгууллага руу явуулдаг байна.

> ...Албан ёсны тайлан бол сар сардаа албаны даргадаа өгдөг. Дээрээс улирлаар өгдөг мөн хагас жил, бүтэн жилээр гэрээ дүгнэдэг. Байнга тайлагнадаг.
>
> *Экспертийн ярилцлага. ННХГ, эмэгтэй*
>
> ...Манайх хөдөлмөр халамжийн ерөнхий газарт, нийслэлийн засаг даргад сар болгон 2 тийшээ явуулдаг.
>
> *Экспертийн ярилцлага. ДХХҮХ, эмэгтэй*
>
> ...Манай байгууллага жилд нэг удаа иргэдэд тайлан тавьдаг. Дүүрэг хувьд хороодуудаараа явж бүтэн жил хийсэн ажлаа тайлагнадаг. Энэ үеэр манайх ч гэсэн хийсэн ажлынхаа тайланг хүргэдэг...
>
> *Экспертийн ярилцлага. ДХХҮХ, эмэгтэй*

Байгууллагын ажилтнууд өдөр тутмын үйл ажиллагааныхаа талаар тайлангаа алба, хэлтсийн дарга нартаа цаашлаад дээд шатны байгууллага руу явуулдаг байна.

> ...Өөр, өөрийн чиг үүрэгтэй хүмүүс өөр өөрсдийнхөө л ажилд хяналт тавина шүү дээ. Мэдээж шаардлага тавих юм бол байж л таарна шүү дээ...
>
> *Экспертийн ярилцлага. ДХХҮХ, эрэгтэй*
>
> ...Шаардлага тавьдаг. Төрийн албаны ажил учир бүх албан үүрэг нь харилцан уялдаа холбоотой байдаг...
>
> *Экспертийн ярилцлага. ННХГ, эмэгтэй*
>
> ...Тавилгүй яахав. Юуны өмнө стандартаа барих, ажилдаа анхааралтай байх, ариун цэврийн хувьд халдвараас сэргийлэх арга хэмжээг тухай бүрд нь хийхийг шаарддаг...
>
> *Экспертийн ярилцлага. СЗГ, эмэгтэй*

Оролцоо нь эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, бодлогын үйл явцад нөлөөлөх зэргийг тусгадаг. Бид энэ хэсэгтээ сэргээн засах үйлчилгээний газрын холбоо байдаг эсэх, байдаг бол тухайн холбоо байгууллагуудтай нэгдэж, хамтарч ажиллах байдал хэрхэн байдгыг тодруулахыг эрмэлзсэн. Судалгаанд оролцогч үүрэг хүлээгч талууд болоод иргэд энэ холбооны талаар мэдээлэлгүй, байдаггүй тухай ярьсан юм. Эндээс харахад сэргээн засах үйлчилгээнд байгууллага, иргэдийн эрх ашгийг хамгаалах холбоо одоогийн байдлаар бий болоогүй байна. Энэ байдал магадгүй уг үйлчилгээний цар хүрээ хязгаарлагдмал байгаатай холбоотой байж болох талтай.

Нийгмийн халамж, үйлчилгээтэй холбоотой өөрт хамаарах мэдээллийг ерөнхийд нь сонирхдог боловч судалгаанд оролцогчдын өгсөн мэдээллийг эрэмбэлж үзэхэд нийгмийн халамж үйлчилгээ, ахмад настны сэргээн засах үйлчилгээний ерөнхий мэдээлэл буюу өөрт нь, амьдралд нь шууд үр дүнгээ өгөхүйц болон шууд хэрэглэгдэх мэдээллийг илүү сонирхдог бол үйлчилгээтэй холбоотой санал гомдол хэрхэн гаргах, хаана хандах талаарх мэдээллийг хамгийн бага сонирхдог байна.

Ахмад настнууд нийгмийн халамж, үйлчилгээтэй холбоотой өөрт хамаарах мэдээллийг ерөнхийд нь сонирхдог боловч судалгаанд оролцогчдын өгсөн мэдээллийг эрэмбэлж үзэхэд нийгмийн халамж үйлчилгээ (92.9%), СЗҮ-ний талаарх ерөнхий мэдээлэл (91) буюу өөрт нь, амьдралд нь шууд үр

дүнгээ өгөхүйц болон шууд хэрэглэгдэх мэдээллийг илүү сонирхдог бол СЗҮ-тэй холбоотой санал гомдол хэрхэн гаргах, хаана хандах, жишиг, шалгуур үзүүлэлтийн талаарх мэдээллийг хамгийн бага сонирхдог байна.

*Хүснэгт 2. Мэдээлэл авах сонирхол, мэдээллийн ил тод байдал*

| **Мэдээллийн төрөл** | **Мэдээлэл сонирхдог хүмүүсийн эзлэх хувь** | **Мэдээллийн нээлттэй, ил тод байдал (дундаж)** |
|---|---|---|
| НХҮ-ний талаарх мэдээлэл | 92.9 | 3.07 |
| Ахмадад хандсан НХҮ-ний талаар | 91.0 | 3.03 |
| СЗҮ-ний талаарх ерөнхий мэдээлэл | 91.0 | 2.96 |
| СЗҮ-ний газрууд, тэдгээрийн сонголт | 86.5 | 2.74 |
| СЗҮ-ний талаарх шийдвэр | 65.9 | 2.89 |
| СЗҮ-ний төрөл зүйл | 72.7 | 2.94 |
| СЗҮ-ний жишиг, шалгуур үзүүлэлт | 62.2 | 2.82 |
| СЗҮ-ний талаар санал, хүсэлт, гомдол өгөх газар, суваг | 66.9 | 2.85 |

*Тайлбар: Тухайн мэдээллийн нээлттэй ил тод байдал хэр байгааг маш сайн-4, сайн-3, тааруу-2, маш муу-1 гэсэн эрэмбийн шкалаар үнэлүүлж, үнэлгээний дунджаар харуулав.*

Ахмад настнууд нийгмийн халамжийн үйлчилгээний талаарх мэдээлэл, ахмад настанд хандсан НХҮ-ний талаарх мэдээллүүдийг нээлттэй, ил тод байдал сайн гэж үнэлжээ. Харин сэргээн засах үйлчилгээний бусад мэдээллийн ил тод байдлын үнэлгээ сайн үнэлгээ рүү хараахан хүрэхгүй байна. Ялангуяа сэргээн засах үйлчилгээний газрууд, тэдгээрийн сонголт, жишиг шалгуур үзүүлэлт, СЗҮ-ний талаар санал гомдол хэрхэн гаргах, өгөх талаарх мэдээлэл нээлттэй, ил тод байдаггүй гэсэн байна.

*Хүснэгт 3. СЗҮ-ний шалгуур үзүүлэлтийг хянах, шалгах үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал*

| **№** | | **Хувь** |
|---|---|---|
| **1** | Ил тод, нээлттэй явагддаг гэж бодож байна | 44.4 |
| **2** | Ил тод, нээлттэй явагддаг эсэх нь эргэлзээтэй | 43.0 |
| **3** | Ил тод, нээлттэй явагддаггүй гэж бодож байна | 12.6 |
| **НИЙТ** | | **100.0** |

Ахмадуудын 44.4 хувь нь СЗГ-дын үйлчилгээний чанарт тавигдах шалгуур үзүүлэлтийг хянах, шалгах үйл ажиллагаа ил тод, нээлттэй явагддаг гэж боддог бол 43 хувь нь ил тод, нээлттэй явагддагт нь эргэлзэж байв. Харин цөөн хувь нь ил тод, нээлттэй явагддаггүй гэж хариуллаа. Үйлчилгээний чанарт тавигдах шалгуур үзүүлэлтийг хянах, шалгах үйл ажиллагааны талаар мэдээлэл авах боломж байдаг гэж хоёр ахмад тутмын нэг нь үзсэн.

Сэргээн засах үйлчилгээний мэдээллийн ил тод байдлын талаарх үнэлгээ ерөнхийдөө тааруу хэмээн үнэлж буй иргэдийн үнэлгээ нь холбогдох мэдээллийг хэрхэн авах талаарх мэдээлэл дутмаг, мэдээллээ танил тал, найз нөхдөөсөө дам байдлаар сонсдог, албан ёсны эх сурвалжаас мэдээлэл авахгүй байгаатай нь холбоотой байх талтай. Иймээс нийгмийн халамж үйлчилгээний газраас ахмад настнуудад үзүүлдэг үйлчилгээ, тэдгээрийн ач холбогдол, хамрагдах боломж, тавигдах шаардлага зэрэг мэдээллийг илүү ил тод, нээлттэй болгоход анхаарч, зорилтот бүлгүүд буюу ахмад настнууд, хөгжлийн

бэрхшээлтэй иргэдэд зориулан гаргах, ойлгомжтой, энгийн товч мэдээлэл бэлтгэн түгээх, мэдээлэл авах арга замыг хялбар, амар болгох, ахмадын холбоодтой хамтран ажиллах, тэднээр дамжуулан мэдээлэл хүргэх боломжийг өргөжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Сэргээн засах үйлчилгээнд үнэлгээ хийж, асуудал дэвшүүлэх, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх шатанд хэрхэн байгааг гарган хариуцлагын харилцааны матрицыг гаргалаа.

*Хүснэгт 4. Хариуцлагын харилцаа*

| **Хариуцлагын харилцаа** | | | | |
|---|---|---|---|---|
| **Бодлогын үе шат** | **Үйлчилгээнд гарах хүндрэл бэрхшээл** | **Үүрэг хүлээгч** | **Шаардах эрхтэй этгээд** | **Нэгдэл холбоо, нөлөө** |
| | Үйлчилгээ зорилгодоо хүрэхэд саад болж буй зүйлс | Бэрхшээлд хариуцлага хүлээх этгээдүүд | Үйлчилгээний хэрэглэгчид, өөрчлөлтийг хүсч буй бүлгүүд | Оролцогчдын харилцаа: Шинэчлэлийг хэн эсэргүүцэж, хэн дэмжиж байна вэ? |
| **Асуудал дэвшүүлэх** | 1. Санхүүжилт,<br>2. Мэдээлэл муу<br>3. Оролцоо, идэвх<br>4. Үйлчилгээний хүртээмж | 1. СЗГ<br>2. Хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн,<br>3. ДХХҮХ<br>4. ННХГ | Ахмад настан, СЗГ | - |
| **Бодлого боловсруулах** | 1. Санхүүжилт,<br>2. Мэдээлэл муу<br>3. Оролцоо, идэвх<br>4. Үйлчилгээний хүртээмж | ХХҮЕГ | Ахмад настан, СЗГ | - |
| **Хэрэгжүүлэх** | 1. Санхүүжилт,<br>2. Мэдээлэл муу<br>3. Оролцоо, идэвх<br>4. Үйлчилгээний хүртээмж | 1. СЗГ<br>2. Хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн,<br>3. ДХХҮХ<br>4. ННХГ | Ахмад настан, СЗГ | - |

Хариуцлагын харилцааг тодорхойлж буй дээрх хүснэгтээс харахад бодлогын үе шат бүрт санхүүжилт, мэдээлэл муу байгаа байдал, оролцогч талуудын идэвх оролцоо сул байгаатай холбоотойгоор хүндрэл бэрхшээлүүд үүсч байна. Оролцогч талуудын аль алинаас нь шалтгаалсан хүчин зүйлүүдээс улбаалан дээрх хүндрэл бэрхшээлүүд үүсч байна. Тухайлбал, санхүүжилт дутмагаас үүдэн үйлчилгээний хүртээмж муу байна. Сэргээн засах үйлчилгээнд бэрхшээлд хариуцлага хүлээх этгээдүүд сэргээн засах газрууд, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн, ДХХҮХ, ННХГ, ХХҮЕГ багтдаг. Ахмад настнууд болон үйлчилгээ үзүүлж буй газрууд өөрчлөлтийг хүсч буй бүлгүүдэд багтаж байна. Сэргээн засах үйлчилгээнд шинэчлэлийг эсэргүүцэж эсвэл дамжсэн нэгдэл холбоод одоогоор хараахан бий болоогүй. Хариуцлагын харилцааны матрицаас харахад сэргээн засах үйлчилгээг боловсронгуй болгохын тулд бодлогын шат бүрт оролцогч талуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээтэй байна.

Төрийн байгууллагын зүгээс сэргээн засах үйлчилгээний тухай олон нийтэд тайлбарлаж зөвтгөх үүргээ биелүүлж, тухайн үйлчилгээнд алдаа дутагдал гаргасан бол хариуцлага хүлээлгэх механизм байдаг. Гэхдээ санал, хүсэлтийг тайлбарлан таниулж буй байдал хангалттай хэмжээнд биш. Энэ

байдал хоёр дахь үүрэг хүлээгч талд ч мөн адил байна. Хариуцлага нэхэх эрх бүхий талын шаардлагаа хэрхэн илэрхийлж байгаагаас энэ зарчмын үр нөлөө гардаг. Гэвч ахмад настнууд үйлчилгээ үзүүлэгч талуудад шаардлага тавих байдал тааруу, тэр бүр илэрхийлдэггүй. Сэргээн засах үйлчилгээнд хариулт өгөх боломжтой байх зарчим төдийлөн сайн хэрэгжихгүй байна. Энэ нь сэргээн засах үйлчилгээнд оролцогч талуудын идэвх оролцоо сул байгаатай холбоотой.

Бодлого, хууль батлагдахаас өмнө тэдгээрийн агуулга иргэдийн санал хүсэл, эрэлт хэрэгцээг тусгах байдал дутагдалтай бөгөөд шат шатнаас ирсэн чиглэлийн дагуу ажиллах нь элбэг. Асуудал тодорхойлох, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх шатууд дээр үүрэг хүлээгч талууд иргэдийн санал хүсэлтийг авч, тэдэнд танилцуулах байдал хангалтгүй. Гэхдээ ахмадууд сэргээн засах үйлчилгээ болон халамжийн үйлчилгээ, үүрэг хүлээгч талуудын харилцаа, уриалгахан үйлчилдэг байдалд сэтгэл хангалуун байдаг. Иргэдийн санал, хүсэлтийг авч ажиллах тал дээр анхаарах хэрэгцээ гарчээ.

Төрийн албан хаагчдын болон СЗҮ үзүүлж буй байгууллагуудын ажилтнуудад сайшаах эсвэл шийтгэх явцдаа иргэдийн санал, шүүмжийг харгалзах байдал бага байдаг. Гэхдээ сэргээн засах үйлчилгээнд ахмадуудын зүгээс ирсэн саналыг үндэслэн шагнах урамшуулах байдал бага, эсрэгээрээ шийтгэх явцдаа иргэдийн саналыг харгалзан үзэж арга хэмжээ авагддаг байна. Бодлого боловсруулах хүрээнд ахмадууд саналаа харьцангүй сайн хэлдэг бол хэрэгжүүлэх шатанд хангалтгүй байна. Бодлогын үе шат бүрт оролцогч талуудын идэвх оролцоо дутагдалтай байна.

**Литература:**


1. Ахмад настны сэргээн засах үйлчилгээний эгэх хариуцлагын үнэлгээ. Чанарын судалгааны тайлан. //ШУА-ын Философийн хүрээлэн. 2018.
2. Нийгмийн халамжийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар УИХ-ын чуулганд мэдээлэл. [Электронный ресурс]. //Https://zasag.mn/news/view/15613. (дата обращения: 12.10.2020).
3. Г.Түмэннаст. Монголын нийгмийн халамжийн өнөөгийн тогтолцоонд хийсэн социологийн шинжилгээ. Докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2017. 20 дахь тал.
4. Democratic Accountability in Service Delivery. A practical guide to identify improvements through assessment. Sweden. 2014, P. 17-18.
5. Нийгмийн халамжийн тухай хууль. 2012 оны шинэчилсэн найруулга. [Электронный ресурс]. // https://www.legalinfo.mn/law/details/393?lawid=393&sword=%D1%83%D1%80%D0%B0%D0%BC%D1%88%D1%83%D1%83%D0%BB%D0%BB%D1%8B%D0%BD. (дата обращения: 1.08.2020).
6. Ахмад настны нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа. ҮСХ. УБ., 2018. 3 дахь тал.

*Эрдэм шинжилгээний илтгэл (гадаад)*

**Ц.Цэцэнбилэг, Ц.Уянга.** Кризисы и жизненные циклы семей Монголии. //“Практическая психология в условиях современных кризисов: проблемы, перспективы и решения” Всероссийская научно-практическая конференция международным участием, посвященная 90-летию БГПИ-БГУ. Улан-Удэ, 23 сентября 2021.

## ГЭР БҮЛИЙН АМЬДРАЛЫН МӨЧЛӨГ, ШИНЖ БАЙДАЛ


**Ц.Цэцэнбилэг**

*Доктор (Ph. D), дэд профессор*
*ШУА, Философийн хүрээлэн, Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбар*
**Ц.Уянга**
*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын ЭША*



***Abstract:*** The article examines the current family life cycle in Mongolia based on a 2019 study conducted by the Labor and Social Welfare Research Institute. An issue that has been studied in relation to the family life cycle is the crisis in family relationships. Young families face adjustment challenges, while middle-aged families experience physical and psychological changes, parental care, and separation. Elderly families, on the other hand, face crises related to social status, health, and expectations of children. Therefore, the government's family policy and family-oriented development and support services should be based on the specific needs of the family life cycle.



**Keywords:** family, life cycle, family age group, crisis


Оросын алдарт зохиолч, сэтгэгч Лев Толстой “Анна Каренина” зохиолоо “Бүх аз жаргалтай гэр бүлүүд адилхан, аз жаргалгүй гэр бүл бүр өөр өөрийнхөөрөө аз жаргалгүй байдаг” хэмээх үгийг урьтал болгож Облонскийн гэр бүлд үүссэн эмх замбраагүй байдлаас эхэлдэг[43]. Сайтар уншваас уг зохиол нь уран зохиолын гайхамшигтай бүтээл төдийгүй үүнийг нийгэм судлалын үүднээс шүүхэд тэрээр янз бүрийн гэр бүлүүдийн эхлэл, дунд үе, төгсгөл, тэдгээрийг дагалдсан аз жаргал, хямрал, гарц шийдлийг агуулсан гэр бүлийн социологийн тодорхой жишээ, шинжилгээ болох аж. Нэг талаас тухайн үеийн нийгэм, түүх соёлын суурь ба нөлөөлөл, нөгөө талаас хувь хүмүүсийн итгэл тэмцэлийг агуулсан түүх ажгуу. Хэдийгээр эхний тал нь маш хүчтэй бөгөөд үүнд олон гэр бүл мөхөс болдог ч гэсэн Левины гэр бүлийн жишээгээр аз жаргалтай гэр бүл хэрхэн бүрэлдэж ямар дүр төрхтэй байдгийг өгүүлсэн сургамж бөлгөө. Үүгээр үзэхэд нийгмийн хямралын үед гэр бүл хамгийн их өртдөг байна.

1990 оноос хойш ихсэж буй монгол гэр бүл салалтын статистикийг харсан хүн бүр гэр бүл хэмээх нийгмийн байгууламжийн хямралын тухайд сэтгэл зовним.[44] Гэрлэлт, цуцлалтын тоон харьцааг 30 жилээр харьцуулахад 1990 онд 1000 хүн тутамд 8.7 гэрлэлт 0,1 цуцлалт ноогдож байсан бол 2011 оноос

---

[43] Лев Толстой. Анна Каренина. Источник: Л. Н. Толстой. Собрание сочинений в восьми томах. Т. 5. М., "Лексика", 1996. “Все счастливые семьи похожи друг на друга, каждая несчастливая семья несчастлива по-своему.”

[44] Гэрлэлт, цуцлалт, 1000 хүнд ногдохоор, аймаг, нийслэлээр. Хүн амын статистик. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. ҮСХ. Мэдээлэл шинэчлэгдсэн: 2020-06-11. 2020-03-23 //https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_020V1

хойш энэ тооны харьцаа 20 гаруй дахин өсөж бөгөөд 2019 онд 1000 хүн тутмын 9.8 нь гэрлэж 2,1 нь салсан байна. Үүний үр дагавар болсон ганц бие өрх толгойлсон гэр бүл, өнчин болон хагас өнчин хүүхдүүдийн тоо ихсэж, хойд эцэг, эхийн дарангуйлал, хүүхдийн үл хайрхал, гаж хүмүүжил, хүнийсэл зэрэг асуудал яах аргагүй анхаарал татам. Гэр бүлийн төлөвшлийг хөгжлийн сэтгэл зүйтэй холбож үүсэл, хөгжил, мөхөл хэмээх үе шатаар авч үздэг. Гэр бүлийн сэтгэлзүй, сэтгэлзүйн эмчилгээнд ихэвчлэн ашигладаг системийн хандлагын хүрээнд гэр бүл нь гадаад ертөнц (хүрээлэн буй орчин) -той байнгын харилцан уялдаатай, харилцан солилцоонд байдаг өөрөө зохион байгуулалттай нийгмийн тогтолцоо гэж тодорхойлогддог. Энэхүү хандлагын хүрээнд гэр бүлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй хоёр хуулийг ялгаж салгасан болно. Үүнд:

Гомеостазын тухай хууль. Энэ хуулийн дагуу гэр бүлийн үйл ажиллагаа нь тогтвортой байдал, тогтвортой байдлыг хадгалахад чиглэгддэг.

Хөгжлийн тухай хууль. Энэ хууль нь гэр бүл нь түүхэн шинж чанар, үүсэл, хөгжил, татан буулгах гэсэн гурван нэр томъёогоор тодорхойлогддог болохыг харуулж байна.

Хоёрдахь хуулиас харахад гэр бүлийн амьдралын тодорхой мөчлөг байдаг бөгөөд түүний үечилсэн, тогтвортой өөрчлөлтийн тухай ярьж болно. Гэр бүлийн амьдралын мөчлөгийн үе шат бүр нь түүний онцлог шинж чанаруудыг агуулдаг.

Бид энэ өгүүлэлд гэр бүлийн хөгжил, үе шатыг монголын гэр бүлд тулгамддаг асуудлуудын тухайн үетэй холбон авч үзэв.

Хүний амьдралд гэр бүл түүний үнэ цэнэ чухал байр суурь эзэлдэг бөгөөд энэхүү гэр бүлийн амьдрал нь тодорхой мөчлөгт хуваагдан, нийтлэг шинжээр тайлбарлагддаг. Гэр бүлийн амьдралын мөчлөг бол гэр бүл хөгжлийнхөө явцад дамждаг үе шатуудын логик дараалал юм. Амьдралын мөчлөгийн үе шатууд, эсвэл үе шатууд нь ялгаатай байдаг, өөрөөр хэлбэл гэр бүл нь гэр бүлийн нэг үйл явдлаас нөгөө үйл явдлын хооронд оршин тогтнох хугацаа юм.

"Гэр бүлийн амьдралын мөчлөг" гэсэн нэр томъёог Э.Дувалл, Р.Хилл нар 1948 онд ашигласан[45]. Тэд гэр бүлийн хөгжлийн үе шат бүрт хувь хүний шийдвэрлэсэн даалгаврын өвөрмөц байдлын талаар Э.Эриксоны онолыг үндэслэн гэр бүлийн хөгжлийн динамикийг судлав.

Гэр бүлийн социологийн анхны сурах бичгийн зохиогч Т.Бүрэнжаргалын тодорхойлсноор “Гэр бүлийн мөчлөг гэдэг нь гэр бүл үүсэхээс эхлэн дуусгавар болох хүртэлх нийгэм-хүн ам зүйн үеийн үечлэлийг багтаасан он цагийн дэс дараалал гэж ойлгож болно. Энэхүү үечлэлд гэрлэх, анхны хүүхэд төрөх, удаах хүүхдүүд төрөх, хүүхдүүд гэрлэн өрх тусгаарлах, гэр бүл дуусгавар болох зэрэг үе шатууд багтдаг. Аливаа гэр бүл амьдралынхаа явцад чанарын хувьд харилцан адилгүй үе шатыг дамждаг бөгөөд үүнийг гэр бүлийн түүх ч гэж нэрлэдэг. Энэ үе шатыг социологийн шинжлэх ухаанд гэр бүлийн амьдралын мөчлөг хэмээн авч үздэг юм. Гэр бүлийн амьдралын хэв маяг, нөхцөл байдал, амьжиргаа нь мөчлөг болгонд ялгаатай байдаг”.[46]

---

[45] Duvall, E. M. & Hill, R. L. Report of the Committee on the Dynamics of Family Interaction. Washington, D.C. National Conference on Family Life, 1948
[46] Т.Бүрэнжаргал. Гэр бүлийн социологи. УБ., 2005. 110 дахь тал.

Гэхдээ гэр бүлийн амьдралын мөчлөгийг судлаачид шалгуур болгож буй үзүүлэлтээсээ хамаарч харилцан адилгүй ангилдаг.

Гэр бүлийн амьдралын мөчлөг – гэр бүл анх бий болсон цагаас мөхөх хүртэлх туулах тодорхой үе шатуудын дарааллыг нэрлэнэ. Энэхүү нэр томьёог анх Э.Дюваль, Р.Хипл[47] нар дурджээ. Гэр бүлийн амьдралын мөчлөгийн асуудлын талаар хөндсөн судлаач Э.Дюваль[48], Б.Картер, М.Макголдрик[49] нарын ажлуудтай танилцахад гэр бүлийн амьдралын мөчлөгийг олон янзын үеүдэд хувааж, харилцан адилгүй шалгуур үзүүлэлтээр тайлбарласан байдаг. Жишээ нь:

- Гэр бүл хүүхэдтэй эсэх, хүүхдийн насны ангиллаар;
- Хосуудын насны ангиллаар;
- Хамтран амьдарсан хугацаагаар;
- Гэр бүлийн бүтцийн өөрчлөлтөөр;
- Гэр бүлийн гишүүдийн харилцаанд гарч буй өөрчлөлтөөр.

Харин манай орны эрдэмтэд, судлаачид энэхүү асуудлыг мөн хөндөн, судалсан бөгөөд судлаач Н.Хавх гэр бүлийн амьдралын мөчлөгийг эхний буюу доод нэгдлийн үе (хоёр биеийг холбогч сэтгэл санааны нэгдэл) тэмцлийн шат (энэ үеэс амьдралын зөрчил бий болно), дээд нэгдлийн үе (эмээ өвөө болох үе) хэмээн гурав ангилан үзжээ.[50] Ц.Хурцбилэг гэр бүлийн амьдралын мөчлөгийг гэр бүл болсон үеэс анхны хүүхэд төрөх үе, анхны хүүхэд гэрлэх буюу өрх тусгаарлах, бүх хүүхэд өрх тусгаарласан эцэг, эхийн аль нэг нь нас барах хүртэлх үе хэмээн тав ангилсан байна[51]. Д.Тунгалаг гэр бүлийн амьдралын мөчлөгийг амьдралын эхэн, дунд, тогтсон амьдрал хэмээн гурав ангилсан байдаг. Монгол Улсын 1989 оноос хойших 10 жил бүрийн статистик үзүүлэлт гэр бүл цуцлалт гэр бүл байсан хугацаатай хамаарч өөрчлөгдөж ирснийг доорх хүснэгтээс харж болно. 1990 оны үед гэр бүлүүд ихэвчлэн эхний 6 жилд буюу дасан зохицол, төлөвшлил, хүүхэдтэй болох үед салдаг байсан бол сүүлийн 10 жилд 10 ба түүнээс жил хамт амьдарч гэр бүлээ цуцалдаг болжээ.

*Хүснэгт 1.Гэр бүлийн цуцлалтыг гэр бүл байсан хугацаатай харьцуулсан байдал[52]*

| Гэр бүл байсан хугацаагаар | 1989 | 1990 | 2000 | 2010 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бүгд | 1,014. | 1,127. | 815. | 3,054. | 3,873. | 4,003. | 3,945. | 4,201. | 4,262. |
| 1 хүртэлх жил | 77. | 68. | 30. | 101. | 37. | 24. | 13. | 21. | 58. |

[47] Duvall, E. M. & Hill, R. L. Report of the Committee on the Dynamics of Family Interaction. Washington, D.C. National Conference on Family Life, 1948

[48] Duvall, E. M. ***Family development*** (2nd ed.). Philadelphia: Lippincott. 1962.

[49] Carter B. & McGoldrick M. (eds.) The changing family life cycle — a framework to family therapy. Boston: Allyn & Bacon, 1988.

[50] Н.Хавх. Эх хүнд оюун санааны, эм хүнд сэтгэлийн баялгийг байгаль илүү заяажээ. //"Хос мөр" сэтгүүл. УБ., 1994. №1. 2-3 дахь тал.

[51] Ц.Хурцбилэг. "Социологи". Улс төрийн боловсролын академи.Лекцийн цуврал. УБ., 1995. №4.

[52] Гэр бүл цуцлалтын тоо, гэр бүл байсан хугацаагаар. Хүн амын статистик. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. ҮСХ. Мэдээлэл шинэчлэгдсэн: 2020-03-23.
Энэ тоо баримт дээр тулгуурлан зохиогчдын хийсэн тооцоо.
https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_021V1

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1- 3 | 243. | 261. | 112. | 576. | 259. | 262. | 249. | 280. | 272. |
| 4- 6 | 327. | 368. | 185. | 601. | 608. | 589. | 538. | 519. | 539. |
| 7-9 | 159. | 191. | 170. | 395. | 1,186. | 1,062. | 835. | 773. | 637. |
| 10 ба түүнээс дээш | 207. | 239. | 318. | **1,381.** | **1,783.** | **2,066.** | **2,310.** | **2,608.** | **2,756.** |

Иймээс гэр бүлийн амьдралын мөчлөг болон тэдгээрт тулгарч буй асуудал, бэрхшээлтэй нь гэр бүлийн системын онол үүднээс авч үзлээ. Бид энэхүү судалгаандаа гэр бүлийн амьдралын мөчлөгт бий болдог хямралыг В.Сатирын онолтой (гэр бүлийн хэвийн хямралын үе шат) холбон, харилцаанд гарах өөрчлөлтийг тодруулахыг хичээсэн юм. [53] Тус онолын тайлбар буюу гэр бүлийн амьдралын мөчлөгтэй уялдан илэрдэг хямралын шинж байдалд анхаарал хандуулж төрөөс баримтлах бодлогодоо анхаарвал зохистой гэдгийг тэмдэглэхийг зорьсон болно.

*Хүснэгт 2. В.Сатирын онолын дагуух гэр бүлийн харилцааны хямралын үе шат, агуулга*

| Амьдралын мөчлөг | Хямралын үе, агуулга |
|---|---|
| **Залуу гэр бүл** | Анхны хүүхэд төрөх үе. Гэр бүлд хүүхэд төрөхөд гэр бүлийн харилцааны хэв маяг нь хувь хүний амиа хичээсэн шинж байдлаас нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх хэлбэр лүү шилждэг. Өөрөөр хэлвэл хосууд хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлж, өөрсдийн үүрэг, хариуцлагыг дахин өөрчлөх шаардлагатай болдог. |
| | Хүүхдийн хэл яриа хөгжих үе. Хүүхдийн хэл, ярианы хөгжил нь эцэг, эхчүүдтэй харилцах харилцаанаас хамаардаг бөгөөд тэдний зүгээс нэлээд чармайлт шаардлагатай болдог. |
| | Хүүхэд өөрийн хүрээлж буй орчинтой дасан зохицох үе. Энэ шатанд эцэг, эхчүүд сургуулийн болон бусдын орчинд дасан зохицох, тухайн орчны дэг, журмын талаар мэдлэгтэй болдог. Энэ үед эдгээр өөрчлөлт, шилжилттэй холбоотойгоор гэр бүлийн хосуудын харилцааны тодорхой хямрал бий болдог. |
| **Дунд насны гэр бүл** | Хүүхэд өсвөр насанд шилжих үе. Энэ үед хүүхдийн өсвөр насны сэтгэлзүйн онцлогоос шалтгаалж эцэг-хүүхэд, эх-хүүхэд, хүүхдүүд хоорондын харилцааны зөрчил үүсэх хандлага ажиглагддаг. Хүүхэд шүүмж хүлээж авах байдал эмзэг болж, эцэг эхчүүд өөрсдийн эрх мэдлийн төлөө тэмцэх, сэтгэлзүйн тогтворгүй байдлын шинж илэрч, улмаар гэр бүлийн сэтгэлзүйн микро орчин доройтох хандлагатай. |
| | Хүүхэд төрж, өссөн гэр бүлээ орхих үе. Энэ үед эцэг, эхчүүд “хоосон үүр” гэж нэрлэгдэх синдромд автаж, эмзгээр хүлээж авдаг. |
| | Том хүүхдүүд өөрийн гэр бүлээ зохиох үе. Хосуудын хувьд энэ үед шинэ хүмүүстэй харилцаа тогтоох, гэр бүлийн хүрээлэлд өөр нэгнийг оруулах шаардлага бий болдог. |
| | Эмэгтэйчүүдэд биологийн хувьд цэвэршилт явагдах үе. Энэ үед нөхөн үржихүйн нас дуусаж, бие организмд гарах өөрчлөлтүүдийг хүндээр хүлээж авдаг. |
| **Ахмад насны гэр бүл** | Эрчүүдийн хувьд бэлгийн харьцааны идэвх буурах үе. |
| | Ач, зээ төрөх үе. Өвөө, эмээ болж үүрэг, хариуцлага өөрчлөгдөх шаардлага бий болдог. |
| | Хосуудын аль нэг нь нас барах үе. Энэ үед маш хүнд хямрал тохиолдож, бусад ойр дотны хүмүүсийн дэмжлэг ихээр шаардлагатай болдог байна. |

Гэр бүлийн амьдралын мөчлөгийн онолыг судалж, тус судалгааны хамрах хүрээ, онцлогийг харгалзан үзсэний хүрээнд бид гэр бүлийн харилцааг гишүүдийн насны бүлгийн хүрээнд залуу, дунд,

[53] Satir, V. The New Peoplemaking. Mountain View. Calif.: Science andf Behavior Books. 1988.

ахмад гэр бүлээр ангиллаа. Энэхүү ангиллыг авч үзэхдээ хосуудын насыг шалгуур үзүүлэлт болгосон. “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай” хуулийн 3.1 дүгээр заалтын дагуу 18-34 насыг залуу, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн насыг харгалзан 50-аас дээш насныхныг ахмад үе, харин эдгээр насны бүлгийн завсрын үе болох 35-49 насныхныг дунд үе хэмээн ангилан үзсэн болно.

*Зураг 2.Судалгаанд хамрагдсан өрхийн тэргүүний эхнэр/нөхөр, хамтран амьдрагчтайгаа хамт амьдарсан хугацаа, өрхийн тэргүүний насны бүлэг, жилээр*




Энэхүү амьдралын мөчлөгөөр тодруулбал судалгаанд хамрагдсан иргэдийн 652 (32.3 хувь) залуу, 758 (37.6 хувь) дунд, 607 (30.1 хувь) ахмад гэр бүлийн төлөөлөл байв.

**Залуу гэр бүл**

Монгол Улсын нийт хүн амын 64.2 хувь буюу 2,039 мянган иргэн залуучуудын төлөөллийг бүрдүүлж байна.[54]

1970 – аад оны сүүлчээс гэр бүл судлалын шинжлэх ухаанд хамгийн их хэрэглэгдэх болсон солилцооны онол нь хосуудын хооронд сэтгэл зүйн болон үр ашигтай харилцан солилцоо хэрхэн явагдаж байгаа нь чухал гэж үздэг.

Энэхүү онол нь залуу хосуудын харилцаа харилцан үүрэг хүлээж, бэрхшээлийг давах итгэл найдвар дээр суурилсан солилцоонд үндэслэн явагддаг учраас хамгийн эмзэг байдаг хэмээн тайлбарладаг. Иймээс хамтын амьдралын эхний 5 жил хамгийн их хямралтай байдаг бөгөөд харилцан солилцоо үр ашгийг авчрахгүй бол аюултай гэж тайлбарладаг.

Энэхүү судалгаанд хамрагдсан 34 хүртэлх насны гэр бүлийн хувьд ихэнх нь (88.8 хувь) 10 хүртэлх жил хамт амьдарчээ.

Залуу гэр бүлүүдийг санхүүгийн хувьд бие даадаж амжаагүй, анхны хүүхдээ төрүүлсэн хосууд бүрдүүлж байдаг тул хүүхэд харах, амьдрах сууцтай болох, хөдөлмөр эрхлэх хэрэгцээ шаардлага үүссэн, харилцааны хувьд нэлээд тогтворгүй үе болдог байна. Энэ нь бусад насны гэр бүлүүдээс ялгарах шинж нь болно.

[54] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Монгол Улсын хүн амын тоо, насны бүлгээр. http://1212.mn/ 2018 оны 4-р сарын дүн

*Зураг 2. Залуу гэр бүлд шаардлагатай дэмжлэг*




Шинээр гэр бүл болж буй хосуудад ямар дэмжлэг хамгийн чухал вэ? гэсэн асуултад залуу гэр бүлүүд ажлын байр, орон сууцны хөнгөлөлт орлого нэмэгдүүлэх боломжийг өргөжүүлэх зэрэг дэмжлэгийг чухалчилсан байна. Энэхүү үзүүлэлтийг 2010 оны суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад хүсэмжилж буй дэмжлэгийн төрөл төдийлөн өөрчлөгдөөгүй ч эрэмбэ, дараалалд өөрчлөлт оржээ.

*Зураг 3.Залуу гэр бүлд шаардлагатай дэмжлэг, оноор, хувиар*




Хамгийн анхаарал татсан үзүүлэлт нь ажлын байраар хангах дэмжлэг хамгийн чухал болж, орон сууцтай болох дэмжлэг нь 22.2 хувиар буурсан байгаа юм. Энэ нь залуусын үзэл бодолд төрөөс санхүүгийн бэлэн дэмжлэг бус материаллаг хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлэхийг хүсэж буй эерэг хандлага юм.

Энэ талаар чанарын судалгаанаас тодруулан, сийрүүлье.

*Хан-Уул дүүргийн иргэн Х.Э-ийн ярилцлагаас:*
*“Өнөөгийн залуучуудад гэр бүлүүдийн хувьд тулгамдаж буй асуудал нь байрны урьдчилгаа. Бидэнд банкны нөхцөл, шаардлагыг хангах боломж төдийлөн бүрддэггүй. Иймд төрөөс орон сууцны бага хүүтэй зээлийн үйлчилгээг хэрэгжүүлбэл тохиромжтой санагддаг. Энэ талаас нь бодлого боловсруулбал ач холбогдол ихтэй. 2 өрөө байр хамгийн багадаа 60 гаруй саяын үнэтэй байна, нийгмийн даатгал төлдөггүй хүний хувьд зээл авахад орлого нотлох зүйл байхгүй гэх зэрэг хүндрэлүүд тулгамддаг.”*

Судалгааны үр дүнгээс харахад залуучуудын 50,8 хувь нь ажлын байраар хангах дэмжлэг, 22,5 хувь орон сууц хүссэн бол 16,3 хувь орлого нэмэгдүүлэх боломж хүсжээ. Эндээс манай өнөөгийн залуучуудын хувьд материаллаг хэрэгцээгээ хангах нь нэн тэргүүний асуудал болсныг харж болно. Үр хүүхдээ зөв өсгөн хүмүүжүүлэх, өөрсдөө сурч боловсорч хөгжих нь чухал ч анхдагч хэрэгцээ буюу ажил

орлого, орон байртай байх хэрэгцээ хангагдаагүй тул оюуны хэрэгцээ буюу хөгжих хэрэгцээ үүсэхгүй байна.

Дэлхийн ихэнх улс орны гэр бүлийн бодлогод залуу гэр бүлийн дэмжлэг томоохон байр суурийг эзэлдэг.

Залуучуудын гэрлэлтэд хандах "эрүүл, зөв ойлголт" нь өөрийн гэр бүлийг зөв эхлүүлэн үргэлжлүүлэх үндэс болохоос гадна нийгмийн харилцааны тогтвортой байдалд ч чухал нөлөөтэй гэж үздэг учраас гэрлэхээс нь өмнө гэр бүлийн боловсрол олгодог. Харин гэрлэснийх нь дараа анхны бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлдэг. Энэ нь өрхийн санхүү болон хүүхэд төрүүлж асарч өсгөх байдал дээр голлон төвлөрдөг. Манай улсын хувьд ч залуу гэр бүлийг ажил орлоготой байх тал дээр голлон анхаарах шаардлагатай байна. Залуу гэр бүлд чиглэсэн дэмжлэг хэрэгжүүлснээр гэр бүлд үүсэх олон сөрөг асуудлаас урьдчилан сэргийлэх боломжтой гэж үздэг.

**Дунд насны гэр бүл**

Энэхүү судалгаанд дунд насны гэр бүлийг 35-49 насны иргэдийг хамруулан, тооцлоо. Судалгаанд хамрагдсан дунд насны гэр бүлийн бүлгийг дунджаар 11 жил хамт амьдарч байгаа хосууд бүрдүүлсэн байна. Энэ насны эцэг, эхчүүдийн хувьд хүүхэд нь өсвөр насанд хүрэх, өөрийн гэр бүлээ зохиож, төрсөн эцэг эхээ орхин тусдаа гарах үе шаттай холбоотой сэтгэлзүйн хямралтай тулгардаг байна.[55]

Дунд нас нь зарим нэгэнд ололт амжилтын үе байхад нөгөө нэгэнд нь түгшүүр, сэтгэл хангалуун бус байдлын үе байдаг. Бие хүний хөгжлийн онолуудад дунд насны онцлогийг дараах байдлаар тайлбарладаг. Бие махбод болон сэтгэл санааны мэдэгдэхүйц өөрчлөлт гарч эхэлснээр дунд насны үе эхлэх бөгөөд хосуудын хоорондын харилцаа сэтгэл хөдлөлөөр бус дасан зохицол, хамтын үүрэг хариуцлагаар илүү холбогддог гэж үздэг.

Дэлхийн олон оронд дунд насны хямралыг даван туулахад чиглэсэн сургалт, зөвлөгөөний хөтөлбөрүүд хэрэгждэг. Настай аав, ээжийгээ асрах, үр хүүхдээ амьдралд бэлдэж тусгаарлах, бие физиологи, сэтгэл зүйн шилжилт өөрчлөлтийг даван туулах гээд дунд насны гэр бүл маш их ачаалалтай байдаг. Дунд насны гэр бүл орлого болон нийгмийн байр суурийн хувьд тогтсон байдаг тул тэдэнд чиглэсэн үйлчилгээ дэмжлэгийн ихэнх хувь нь сэтгэл зүйн дэмжлэг байдаг.

Чанарын судалгаанд дунд насны төлөөлөл хамрагдсан бөгөөд тэд дараах нийтлэг санал бодлыг бататган, илэрхийлж байсан.

*Иргэн О.Б-ийн ярилцлагаас:*
*"Бид хөдөөгийн малчин гэр бүл. Том хүүхэд оюутан, Дарханд сурч байгаа. Бага хүүхэд маань саяхан сургуульд орсон тул нөхөр мал дээр ганцаараа үлдээд би хичээлийн жилийн хугацаанд сумын төвд амьдрах шаардлагатай болсон. Бид 4 гурван тийш салж амьдарч байгаа нь өрхийн санхүү, мал аж ахуй эрхлэх болон гэр бүлийн харилцаанд муугаар нөлөөлж байна. Энэ талаас, ялангуяа малчин айлын хүүхдийг сумын төвд биш багийн төвд сургах, эсхүл гэрээр боловсрол олгох арга зам хэрэгжүүлэх шаардлагатай байна. Орон нутагт энэ асуудал нэлээд бэрхшээл дагуулж байна."*

[55] Duvall, E. M. & Hill, R. L. Report of the Committee on the Dynamics of Family Interaction. Washington, D.C. National Conference on Family Life, 1948

*Баянзүрх дүүргийн иргэн Г.У-ын ярилцлагаас:*
*"Бага наснаас нь гэр бүлийн боловсролыг багш, эцэг эх нь заах хэрэгтэй байна. Эрүүл мэндийн хичээл энэ жил хэрэгжиж байгаа. Би маш их дэмжиж байгаа. Нөхөн үржихүйн боловсролыг олгох хэрэгтэй."*
*Чингэлтэй дүүргийн иргэн Ч.Г-ийн ярилцлагаас:*
*"Төрөөс санхүүгийн бололцоо муутай, зорилтот гэр бүлүүдэд чиглэсэн үйлчилгээнд анхаарал хандуулмаар байна. Жишээлбэл, хүүхэд нь сурлага сайтай бол үнэгүй боловсрол олгоод, эргээд тэр хүүхэд ажилд орсноор нөхөн төлдөг механизмтай болох гэх мэт. Одоо харахад хүүхдээ сургаж чадахгүй, хохироож байгаа эцэг, эхчүүд маш их байна. Төрөөс хүүхдийн мөнгө болон бусад халамжийн мөнгө авч байгаа хүмүүс, ялангуяа залуучууд ажилгүй л суугаад байя гэсэн бэлэнчлэх сэтгэлгээтэй болчихсон байна."*

**Ахмад насны гэр бүл**

Тус судалгаанд бид ахмад насны гэр бүлийг 50-аас дээш насныхнаар төлөөлүүлэн авч, үзлээ.

Ахмад настан бол сэтгэл зүй, бие махбодын хувьд өөрчлөгдөж буй хүн бөгөөд нийгмийн өөрчлөлтөө дагаад нийгмийн харилцаа нь өнгөрсөн үед харьяалагддаг._Олон улсын хөгшрөлтийн талаарх эрдэм шинжилгээний хурлаас /1951 он/ ахмад настнуудыг:

1. Орчны өөрчлөлтөд тохиромжтой хандах бие махбодын боломж дутагдалтай хүн,
2. Өөрийгөө дүгнэх чадвар буурч яваа хүн,
3. Бие махбод, эрхтний систем доройтон эхэлж буй болон доройтож байгаа хүн,
4. Амьдралд хандах, тохирох идэвхээр дутагдмал болж буй хүн,
5. Эд эс болон эрхтний удаан байх чадвар багасаж буй хүн-хэмээн тодорхойлжээ.

Гэр бүлийн амьдралын мөчлөг нь өтөл нас буюу тэтгэврийн насны үеэр бүрэн төгс болдог. Тэтгэвэрт гарснаар өндөр настнууд ганцаардаж, сэтгэл санааны хямралд ордог. Энэ байдал нь тухайн өндөр настанд төдийгүй гэр бүлийн доторх асрамж, халамж, өндөр настныг хамгаалах бодлого, нийгмийн байдалд ч ихээхэн нөлөөлнө. Тиймээс ахмадууд өөрөө, мөн нийгмийн зүгээс ч гэсэн тэднийг үзэх үзэл, хандах хандлагыг өөрчлөх бодит дэмжих үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай. Ахмадуудад зориулсан хөтөлбөрүүд нь тэднийг нийгмийн идэвхтэй байлгаж сэтгэл санааг нь дэмжсэнээр эрүүл байх нөхцөл бололцоог бүрдүүлж үр хүүхдэд болон нийгмийн эрүүл мэндийн салбарт ирэх ачааллыг бууруулдаг. Манай улсын хувьд ахмадуудад чиглэсэн эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, тэдний туршлага мэдлэгийг ашиглах тухайлсан үйлчилгээ нэн чухал байна.

Харин чанарын судалгаанд ахмад насны гэр бүлийн төлөөллийн санал бодлыг дараах байдлаар тоймлон оруулъя.

*Сүхбаатар дүүргийн Т.Ю-ийн ярилцлагаас:*
*"Хүргэн бэрүүдээ хараад байхад багаас нь гэр бүлийн боловсролыг олгох нь маш чухал юм шиг санагдсан. Жишээлбэл, 13-14 наснаас гэр бүлийн харилцаа, нөхөн үржихүйн асуудлын талаар хичээл орох хэрэгтэй байна. Энэ жилээс БСШУЯ-аас хичээлийн хөтөлбөрт эрүүл мэндийн хичээл орсон сурагтай байсан. Гэр бүлд чиглэсэн төвүүдтэй болмоор байна, Гал голомт хөдөлгөөний тэргүүн гэх мэт олон жил энэ асуудлаар судалсан хүнээр чиглүүлээд байж болно доо. Дээр үед бид нарт лекц ордог байсан, одоо бараг багийн хуралдаа ч ирэхгүй байна. Гэр бүл маш чухал нарийн асуудал шүү дээ. Нэгдүгээрт, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар төвүүдтэй болох хэрэгтэй байна. Хоёрдугаарт, эрдэмтэн мэргэдээр хичээл заалгамаар байна. Тэгээд ахмадууд энэ сургалтад ирж оролцоод өөрсдийн амьдралын туршлагаасаа бас ярилцаж, залуучуудад үлгэр дуурайл өгөх."*
*Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэн Н.З-ийн ярилцлагаас:*

*“Би тэтгэвэрт гарчихсан, хүүхдүүд, хүргэн бэрүүдтэйгээ хамт амьдарч байна. Гэртээ сууж байгаа юм чинь жижиг дунд үйлдвэрлэлийн төсөл бичье гэж бодоод цаг заваа гаргаад бичээд өгөхөд, араас нь маш их материал нэхэгддэг юм байна лээ. Тэгээд л их чирэгдэлтэй болохоор нь би авах ч юм билүү, үгүй ч юм билүү гээд хаясан. Тэгээд мэргэжлээрээ хүүхэд харах үйлчилгээний ажлыг хийе гэж бодоод очтол сургалтад хамрагдаж, сертификат авсан байх ёстой гэсэн. Хөдөлмөр эрхлэх гэхээр ийм асуудлууд үүсэж байна. Сумд бол дэлгүүрт зогсох ажил байвал байна, гэхдээ бидний насныхан тэгж чадахгүй. Одоо би ач зээгээ хараад л байж байна.”*

*Хан-Уул дүүргийн О.Б-ын ярилцлагаас:*

*“Ахмад настай хүн хүүхдийнхээ гэр бүлтэй нийлмэл байдлаар амьдрах маш хүндрэлтэй. Бүх зүйл дээр ялгаа гардаг. Хэрэглээ болон хэв маягийн хувьд зөрчил үүснэ. Жишээлбэл, тэд нарын хийж байгаа хоол, авч байгаа хүнс, үзэж байгаа суваг гээд өдөр тутмын амьдралын хэв маягаас хамаарсан зөрчил их үүснэ. Тэр бүү хэл сүүлдээ төрсөн хүүхэд нь ч бүү хэл, хүргэн/бэрүүд гэрт сууж байгаа ажилгүй настан гэж хараад хүүхдээ харуулж, гэр орны ажилд зараад эхэлдэг. Би хувьдаа залуучууд гэр бүлтэй болоод тусдаа гарах нь л зөв гэж үзэж байна. Хосуудын хооронд хэрүүл гарахад яалт ч үгүй хүүхдээ өмөөрнө, энэ мэтчилэн зөрчил, маргаан ч их тохиолдоно.”*

Харин энэ бүлгийн гэр бүлийн талаар үзэл бодлоо хэрхэн илэрхийлсэн талаар тодруулъя.

*“Good neighbors” ОУБ-ын зөвлөх Х.Б-тай хийсэн ярилцлагаас:*

***“**Ахмад гэр бүлд ажиглагддаг нэг зүйл бол ихэвчлэн эрчүүд нь өөд болоод настай эмгэн ганцаараа үлдээд, сайхан ярилцаад, цайгаа хуваагаад уучих хүнтэй байх хувь хүний хэрэгцээ үүсдэг. Гэтэл энэ талаар манай уламжлал сэтгэлгээ нь хөгшин хүн дахиж гэр бүл үүсгэх талаар сөрөг ойлголт, хандлагатай хүлээж авдаг. Энэ чинь хандлагын хоцрогдол яваад байна, глобал асуудал шүү дээ, тэгж байж л тэр хүн ганцаардлаа даван туулна, хэрэв ээжийгээ урт наслуулъя гэвэл ахмадуудын чөлөөт цагийн танхимууд, ахмадууд хамтраад амьдардаггүй юм аа гэхэд өдрийнхөө цагийг үе тэнгийн хүмүүстэйгээ яриад, тоглоод өнгөрөөх нь зөв хэмээн дэмжих хэрэгтэй.”*

Гэр бүлийн амьдралын мөчлөгтэй холбогдон, судлагдаж байдаг асуудал бол гэр бүлийн харилцааны хямрал юм.

Судлаачид гэр бүлийн мөчлөгийн үе шатуудын өөрчлөлт буюу нэг үеэс нөгөө үед шилжих явцад бий болох хосуудын сэтгэлзүйн хүндрэлийг гэр бүлийн харилцааны хямрал гэж нэрлэдэг. Гэр бүлийн харилцааны хямралыг судлаачид хэвийн болон хэвийн бус гэж ангилан авч үздэг.[56]

Гэр бүлийн харилцааны хэвийн хямрал нь гэр бүлд нийтлэг тохиолддог, “байгалийн” хямрал гэж ойлгоно. Харин харилцааны хэвийн бус хямралын хувьд гэнэтийн тохиолдлоос үүдэлтэйгээр зөвхөн тодорхой гэр бүлд бий болдог онцлогтой. Энэ нь эрүүл мэндийн, ахуйн асуудал болон эргэн тойрны харилцаанд оролцогч гуравдагч этгээдийн зөрчилдөөнтэй байдал, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлийн нөлөөллөөр бий болдог. Нөлөөлөгч хүчин зүйлийг дараах байдлаар ангилах боломжтой:

- Гэр бүлийн аль нэг гишүүн нь нас барах, хууран мэхлэлт, салалт гэнэтийн эрүүл мэндийн асуудал, нийгэмд эзлэх байр суурьт өөрчлөлт гарах, гэнэтийн цочром үйл явдлаас шалтгаалсан;
- Биеийн, сэтгэл санааны ачаалал ихсэх, ахуйн асуудал, гэр бүлийн гишүүд хоорондын урт хугацааны зөрчилдөөн зэрэг.

Хэдийгээр гэр бүлүүдийн амьдралын мөчлөг ерөнхийдөө төсөөтэй боловч гэр бүлийн хэлбэр, онцлогоос хамаарч цаг хугацааны хувьд өөр байдлаар өрнөх боломжтой. Тус судалгаанд бид гэр бүлийн амьдралын мөчлөгийг насны бүлгээр авч үзсэн учраас харилцааны хямралын тохиох ерөнхий

[56] Erik H. Erikson. Identity, youth and crisis. New York: W. W. Norton Company, 1968

төлөвийг тоймлон оруулав. Эдгээр харилцаанд гарах өөрчлөлтөөс харахад дунд насны гэр бүлийн хувьд гэр бүлийн харилцааны хямралын олон янзын хэлбэр илэрдэг бөгөөд гишүүд сэтгэлзүйн хувьд илүү ачаалалтай болдог онцлогтой. Гэр бүлийг амьдралын мөчлөг, тэр дундаа хямралын үеийг нарийвчлан судалж, төрөөс гэр бүлийн чиглэлээр баримтлах бодлогод ашиглан, үйл ажиллагааны үр дүнг өсгөх боломжтой.

**Дүгнэлт.** Гэр бүл нэгэнт тогтсон зүйл биш өөрчлөгдөж хувирдаг болохыг гэр бүлийн хөгжлийн үе шат, зүй тогтол байдгийг эрдэмтэд нотолсон билээ. Гэр бүлийн амьдралын мөчлөгийг гишүүдийн насны бүлгийн хүрээнд залуу, дунд, ахмад гэр бүлээр ангилан шинжлэхэд судалгаанд хамрагдсан иргэдийн 652 (32.3 хувь) залуу, 758 (37.6 хувь) дунд, 607 (30.1 хувь) ахмад гэр бүлийн төлөөллийг бүрдүүлж байв. 34 хүртэлх насны залуу гэр бүлийн ихэнх нь (88.8 хувь) 10 хүртэл жил хамт амьдарчээ. Залуу гэр бүлийн 50.8 хувь нь ажлын байраар хангах дэмжлэг, 22.5 хувь орон сууц хүссэн бол 16.3 хувь орлого нэмэгдүүлэх боломж хүсжээ. 35-49 хоорондох дунд насны гэр бүлүүд дунджаар 11 жил хамт амьдарсан хосууд байж тэдэнд санхүү, хүүхдийн боловсрол, хүмүүжлийн асуудал тулгамдаж байна. Гэр бүлүүдэд тулгамдсан асуудлын түрүүнд материаллаг хэрэгцээ болон ахуйн наад захын хэрэгцээний асуудал жин дарж, эрэмбэлэгдлээ. Гурван гэр бүл тутмын нэг нь санхүүгийн, таван гэр бүл тутмын нэг нь орон байрны асуудал юуны өмнө ихээр санаа зовоож байна хэмээн хариулжээ. Харин удаах байранд гэр бүлийн гишүүдийн боловсролын асуудал оржээ.

Гэр бүл нийгмийн институт, анхан шатны бүл, нэгжийн хувьд нийгмийн хямралыг дагаад биеэрээ бодитоор туулдаг. Нийгмийн нэг асуудал гэр бүлийн гишүүдийн тоо болон тэдний төсөөллийн дагуу үржигдэнэ. Түүнчлэн гэр бүлийн амьдралын мөчлөгийн зүй тогтлыг бас анхаарах зайлшгүй шаардлагатай байдаг. Гэр бүлийн сэтгэл заслын эх хэмээн алдаршсан гэр бүлийн системын онолын үндэслэгч Америкийн сэтгэл зүйч Вирджини Сатирын  онолын дагуу гэр бүлийг ямар үе дээр явж хямралын ямар төрөлтэй тулгарч байгааг сайтар харж тэдгээрт зориулсан ажил, хандлага, хөтөлбөр өөр байхыг анхааруулж байсан. Манай улсад сүүлийн 10 жилийн статистик баримтаар гэр бүлийн хувьд дунд үеийн хямрал хүнд тусч гэр бүлээ цуцлалт нэмэгдэж байна. Иймээс гэр бүлийн амьдралын мөчлөгтэй уялдан илэрдэг хямралын шинж байдалд анхаарал хандуулж төрөөс баримтлах бодлогодоо анхаарвал зохистой билээ.

Асуудал нь гэр бүл зохиох эрдэм, аз жаргалтай гэр болохын төлөө хүн бүр цаг, хүч, хөдөлмөр, хичээл зүтгэл гаргах ёстойг умартана. Хүүхэд төрөнгүйтээ алхаж ярьдаггүйн адил хурим хийсний дараа гэр бүлийн аз жаргал шууд бий болдоггүй билээ. Үүний адилаар гэр бүл насан туршид төлөвшиж, хөгжин өөрчлөгдөн хямралтай учирч, давах эсэх бэрхшээлтэй тулгардаг бөлгөө. Гэр бүлийн хямралд амьдралын мөчлөгийн онцлогийг харгалзвал гишүүд бие биендээ арай хүлээцтэй, ойлгох үүднээс хандаж байвал цуцлалтын тоо багасч Толстойн дүрсэлсэн Левины аз жаргалтай бүл олшрох болой.

***Эрдэм шинжилгээний илтгэл (дотоод)***

О.Баасантогтох. Боловсролын салбар дахь ахмад настны үүрэг оролцоо (2.6 х.х) //“Дээд боловсрол ба тогтвортой хөгжил: онол арга зүй, хөгжлийн чиг хандлага” ЭШБХ. Зохион байгуулагч: Отгонтэнгэр их сургууль. УБ., 2021.11.10.

## THE ROLE OF ELDERLY PEOPLE IN EDUCATION

## БОЛОВСРОЛЫН САЛБАР ДАХЬ АХМАД НАСТНЫ ҮҮРЭГ ОРОЛЦОО

*О.Баасантогтох, МУИС-ийндокторант*
*ШУА-ийн Философийн хүрээлэн, СНСЗС-ын ЭШДэА*
*Утас: 95343716, E-mail*; oyu_baasan@yahoo.com

**Abstract:** Labor relations in Mongolia, not only in the education sector but also in other sectors of society, are regulated by the Law about Labor (July 2, 2021) and Employment Promotion Law (June 17, 2011), also Law about the elderly people (January 26, 2017) provides for the employment of the elderly (Article 9). Despite such a legal framework, there is a tendency for the public to view the elderly as an “experienced workforce” rather than a surplus in the labor market. It is reasonable to assume that the subject can continue to work even if he or she has reached retirement age and his or her “health, mental and psychological capacity” is maintained. The use of this “intellectual resources, competencies and experience” is particularly important in the scientific and educational fields of intellectual labor, as it contributes to the development of students and newcomers to the field, and to the development of “healthy competence based on skills” between older and younger professionals.

Based on quantitative and qualitative data and other data from the basic research project “Social issues, consequences and attitudes of the elderly” conducted by the Institute of Philosophy of the Mongolian Academy of Sciences the issue of employment opportunities should be addressed, taking into account “knowledge and experience do not age” or “health status, mental and psychological capacity”.

**Key words:**Education, elderly people, employment, participation, resources, efficiency, health, intellectual capacity, psychological capacity.

### *Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэх боломж*

Олон улсын хөдөлмөрийн байгууллага “Ахмад ажилчдын зөвлөмж-№162” (5 дугаар зүйл)-д ахмад ажилчдыг насаар ялгаварлахгүйгээр a). Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах, b). Хувийн ур чадвар, туршлага, мэргэшлийг харгалзан үзэх, c). Хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгох, цуцлахтай холбоотой үндэсний хууль тогтоомжийг харгалзах, d). Адил хэмжээний цалин хөлс олгох, e). Нийгмийн хамгааллын тэтгэмж, арга хэмжээнээс хүртэх, f). Хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс хүртэх, g). Орон сууц, нийгмийн болон эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээнд хамрагдах (ILO, International Labour Organization, 1980) боломжтой байхаар зохицуулж, ахмад ажилтан гэдэгт 55-64 хүртэл насныхныг хамруулдаг (ILO, International Labour Organization, 2015).

Монгол улсад ахмадуудын хөдөлмөр эрхлэх эрхийг нь “Хөдөлмөрийн тухай хууль” (УИХ, 2021)-иар хангаж өгсөн бөгөөд тус хуулийн 145.1 “Ахмад настан, тэтгэвэр авагч хөдөлмөр эрхэлж болно” гэж ахмадуудын хөдөлмөр эрхлэх боломжтой болохыг, 145.2 “Ажилтан өндөр насны тэтгэвэр авч байгаа нь түүний цалин хөлсийг бууруулах болон энэ хуульд заасан бусад эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.”

хөдөлмөрийн урамшуулал болон бусад эрх адил тэнцүү болохыг, 145.3 “Ажил олгогч ахмад настны хүсэлтээр ажлын цагийг богиносгож, бүтэн бус цагаар ажиллуулж, эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлэх асуудлыг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна.” гэжээ. Хөдөлмөрийн хуулиас гадна “Ахмад настны тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх ахмадуудын мэдээллийн сан бүрдүүлэх, ахмадууд өөрсдөө төлбөртэй сургалт зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээлийн дэмжлэг үзүүлэхээр тусгасны зэрэгцээ тус хуулийн 6-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагатай ахмад настныг үргэлжлүүлэн ажиллуулж болно.” гэсэн нь дээр дурдсан хууль, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зөвлөмжийн 5 дугаар зүйлийн 3-7-д заасан нөхцлийг зохих хэмжээгээр хангаж байгаа юм. Тухайлан ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нэмэгдүүлэх чиглэлээр Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” (ХХҮЕГ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, 2021)-ийг “Ахмад настны тухай хууль”-нд нийцүүлэх байдлаар 1) ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах, 2) ахмадын төрийн бус байгууллагаар зөвлөх үйлчилгээг зохион байгуулах, 3) аж ахуй өрхийн үйлдвэрлэлд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох гэж гурван чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжихээр тусгасан.

Монгол улсын хэмжээнд “Нийгмийн халамжийн тухай хууль”-ийн (УИХ, Нийгмийн халамжийн тухай, 2012) 12.1.1-д “эрэгтэй 60, эмэгтэй 55 болон түүнээс дээш настай иргэн” гэж өндөр насны тэтгэвэрт гарах насны хязгаарыг тогтоосныг баримжаа болгон хүн амын дундах ахмад настнуудын эзлэх хэмжээ, өөрчлөлтийг статистикийн баримтаас харвал сүүлийн хориод жилийн хугацаанд нийт хүн амын дундах ахмадуудын эзлэх хэмжээ 6.65 хувь (2000)-иас 9.79 хувь (2020) болж, ахмадуудын хувийн жин 2 дахин өсжээ (ҮСХ, Монгол улсын хүн амын тоо (насны бүлэг, хүйсээр), 2021). Хүн амын өсөлтийн хэтийн тооцоогоор нийт хүн амын дундах ахмадуудын эзлэх хэмжээ цаашид ч өсөх (2030 онд 11.9, 2050 он гэхэд хүн амын 21.1 хувийг эзлэх) хандлагатай байгаа юм (Сүхбаатар.Ц, 2019, хууд. 21).

***График - 1.*** *Хөдөлмөрийн насны хүн ам ба ахмадууд*



Бодлогын түвшинд нэг талаас хүн амын дундах ахмад настнуудын эзлэх хэмжээ ийнхүү өссөнтэй холбоотой, нөгөө талаас энэхүү өсөлтөөс үүдэлтэй тэтгэврийн санд ачаалал нэмэгдэх эрсдэл үүссэн (KAS, 2020, pp. 34-35)-тэй холбоотой 2018 онд “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-ийн (УИХ, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, 1994) 4.1-дөөрчлөлт оруулж “Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 65 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно.” гэж 65 нас хүртлээ хөдөлмөр эрхлэх бололцоотой байхаар зохицуулсан. Энэ нь “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого” (УИХ, Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай, 2015; Ариунзаяа.А, 2021)-той уялдаатай юм. Тэтгэвэрт гарах насыг ийнхүү нэмснээр хөдөлмөр эрхлэх хугацаа уртсах, орлогын тогтвортой байдал хангагдах зэрэг эерэг боломжууд бий болохын зэрэгцээ эрэгтэйчүүдийн нас баралтыг бууруулах, хувийн тэтгэврийн сан байгуулах, тэтгэвэр өвлүүлэх г.м нэн даруй шийдэх шаардлагатай асуудал олон.

***Ахмадуудын хөдөлмөр эрхлэлт***

Хөдөлмөр эрхлэлтийн дүр зургийг харвал, Монгол улсын хэмжээнд 2020 оны байдлаар 2.290.227 хүн хөдөлмөр эрхэлж байгаагийн 93.2 хувь нь хөдөлмөрийн насны (2.140.306), 6.8 хувь нь тэтгэврийн насныхан (149.921) байна. Хөдөлмөр эрхлэж буй ахмадууд хүйсийн хувьд эмэгтэйчүүд (74.7%) давамгайлж байгаа юм.

Хөдөлмөрийн хэлбэр, статус насны бүлгүүдэд харилцан адилгүй. Статистикийн мэдээллээр ахмадуудын 28.0 хувь нь хувиараа (Цалин хөлстэй ажиллагчгүй бие даасан ажиллагч), 27.8 хувь нь өрхийн аж ахуй (Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч) эрхэлдэг бол үлдсэн хэсэг нь ажил олгогч, хувиараа үйлдвэрлэл эрхлэгчийн статустайгаар хөдөлмөр эрхэлдэг. Хөдөлмөрийн насныхны хувьд дийлэнх хэсэг нь цалин хөлстэй хөдөлмөр эрхэлж байгаа нь тэтгэврийн насныхантай харьцуулахад 1.6 дахин өндөр үзүүлэлт юм (ҮСХ, 15, түүнээс дээш насны ажиллагчид (хөдөлмөр эрхлэлтийн статусын ангиллаар, хүйс, насны бүлэг, аймаг, нийслэлээр улирал, жилээр), 2021).

***Хүснэгт–1. 15 болон түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн статус***

| **Хөдөлмөрийн статус** | | **Хөдөлмөрийн насныхан** | **Ахмадууд** |
|---|---|---|---|
| Ахмадууд давамгайлсан хөдөлмөр | Цалин хөлстэй ажиллагчгүй бие даасан ажиллагч | 16.8 | 28 |
| | Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч | 17.4 | 27.8 |
| | Гэр бүлийн гишүүдэд хувь нэмрээ оруулагч | | |
| | Цалин хөлстэй ажиллагчгүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч | 0.6 | 1.9 |
| | Ажил олгогч | 1.4 | 1.8 |
| | Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч | 0.8 | 1.1 |
| | Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч | 0.6 | 0.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хөдөлмөрийн насныхан давамгайлсан | Цалин хөлстэй ажиллагч | 31.0 | 62.0 | 19.2 | 38.4 |
| | Цалин хөлстэй байнгын ажиллагч | 14.3 | | 7.3 | |
| | Цалин хөлстэй түр ажиллагч | 14.1 | | 9.7 | |
| | Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч | 2.6 | | 2.2 | |
| | Гүйцэтгэх гэрээлэгч | 0.1 | | - | |
| | Эдгээр статуст хамрагдаагүй ажиллагчид | 0.1 | | 0.1 | |
| **Нийт** | | **100.0** | | **100.0** | |

“Ахмад ажилчдын дунд төлөвшсөн байдал, найдвартай, тогтвортой байдлын шинж чанар илүү түгээмэл байдаг. ... ур чадвартай, ажлаас гарах, ажлаа солих нь бага, үйлдвэрийн осолд ... бага өртдөг мөн хөдөлмөрт хандах хандлага нь бусад насны бүлгүүдтэй харьцуулбал илүү эерэг байдаг.” (Ундрал.Ё, 2019, p. 54)  гэж үздэг боловч баримт, үр дүнгээс харахад Монгол улсад нэгд тэтгэврийн насанд хүрэхэд хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгодог хуулийн зохицуулалттай, хоёрт ажил олгогчдын сонирхолтой холбоотой цалин хөлс бүхий хөдөлмөрийн талбараас түрэгдэж хувийн талбарт шилждэг гэж болохуйц дүр зураг харагдаж байна. Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой ийм дүр зураг бүрэн төлөвшсөн гэж болохуйц баримт цөөнгүй. Тухайлбал, “... өндөр мэргэжлийн дадлага туршлага бүхий зөвлөх мэргэжилтэн 768 ахмад настан байгаа боловч өнөөдөр 38.5 мянган ахмад настан ажил хийж түүний 9 мянга орчим нь байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа нь ... тэдний хүч хөдөлмөрийг нийгэмд ашиглаж чадахгүй байгааг харуулж байна. Хөдөлмөр эрхэлж байгаа ахмад настныг салбараар нь авч үзвэл үйлчилгээний ажилд 3.7 мянга, барилга, тээвэр, үйлдвэрлэлд 1.2 мянга, мал аж ахуйд 20.7 мянга, газар тариаланд 4.9 мянган ахмад настан ажиллаж байна” (Сүхбаатар.Ц, 2019, p. 22) гэж тэмдэглэсэн байдаг. Ерөнхий дүр зургийн хувьд албан ёсны хөдөлмөрийн харилцаанд ахмадуудыг тэр бүр хүлээн зөвшөөрдөггүй болох нь үүнээс харагдах ба хэрэв тэтгэвэрт гарах насны дээд хязгаар (65)-ыг мөрдүүлж эхэлсэн тохиолдолд ажил хөдөлмөр эрхлээгүй ахмад настнуудын амьдралын баталгаа улам бүр эрсдэлд орох магадлалтай болно.

Нийт хүн амын дундах ахмадуудын хөдөлмөр эрхлэлт дээрх дүр зурагтай байгаа бол боловсролын салбарт ахмадуудыг харьцангуй хүлээн зөвшөөрөх хандлага илүү ажиглагддаг. Боловсролын салбарт ажиллаж буй ахмадуудын эзлэх хэмжээ нийт хүн амын дундах хөдөлмөр эрхэлж буй ахмадуудаас бараг хоёр дахин өндөр үзүүлэлттэй аж. Боловсролын түвшнээс хамаарч хөдөлмөр эрхлэх боломж нь нэмэгддэг гэж үздэг бөгөөд “... бүрэн дундаас дээш боловсролтой ахмадуудын бараг тал хувь нь (46.7%) хөдөлмөрийн зах зээлд хэрэгцээтэй ... Боловсролын түвшин дээшлэх тусам тэтгэвэртээ гарсаны дараа ажил эрхлэх магадлал нь өсөж байна.” (Ундрал.Ё, 2019, p. 55) гэж тэмдэглэсэн лугаа дүр зураг шууд ажиглагдаж байна.

*График – 2. Их, дээд сургууль дахь ахмадууд*




Хөдөлмөрийн статусын хувьд эрэгтэйчүүдийн 92.4 хувь нь, эмэгтэйчүүдийн 91.7 хувь нь үндсэн багшаар ажилладаг. Хүйсийн хувьд их дээд сургуульд ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хэмжээ эрэгтэйчүүдээс харьцангуй өндөр (60.3%) бөгөөд удирдах албан тушаалтнуудын 57.6 хувийг, үндсэн багш нарын 55.3 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг (БШУЯ, 2021).

Ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийн ерөнхий дүр зургийг дээрх Монгол улсын нийт ахмадуудын 45.6 хувь (ҮСХ, 15, түүнээс дээш насны ажиллагчид (хөдөлмөр эрхлэлтийн статусын ангиллаар, хүйс, насны бүлэг, аймаг, нийслэлээр улирал, жилээр), 2021) нь хөдөлмөр эрхэлж буй боловч ажиллах хэрэгцээ, сонирхол харьцангуй өндөр. ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбараас хийж буй "Ахмад настны социаль асуудлууд, үр дагавар, төлөв хандлага" сэдэвт суурь судалгааны үр дүнгээс харахад судалгаанд оролцсон дээд боловсрол эзэмшсэн ахмадуудын 41.5 хувь нь, боловсролын салбарт ажиллаж байсан ахмадуудын 42.9 хувь нь хөдөлмөр эрхэлдэг гэсэн, хөдөлмөр эрхлэх сонирхлын хувьд дээд боловсролтой ахмадуудын 80.0 хувь нь, боловсролын салбарт ажиллаж байсан ахмадуудын 84.6 нь хөдөлмөр эрхлэх сонирхолтой гэдгээ илэрхийлсэн. Хөдөлмөр эрхлэх сонирхолтой холбоотой өөр нэгэн судалгаанд "Тэтгэвэрт гарсан ахмад настнуудын 67.5 хувь нь буюу 180 гаруй мянган ахмад настан ямар нэгэн ажил хөдөлмөр хийх хүсэлтэй ..." (Сүхбаатар.Ц, 2019, p. 22) гэж тэмдэглэснээс өндөр үзүүлэлт юм.

Ахмадуудын хөдөлмөр эрхлэх сонирхол өндөр буюу нийгэм-эдийн засгийн талаас хөдөлмөр зах зээлийн хувьд туршлага бүхий ажиллах хүчний нөөцийг үргэлжлүүлэн ашиглаж үр шимийг нь хүртэх боломжтой, мөн зохих хуулиар хөдөлмөрлөх эрхийг нь баталгаажуулсан боловч ажил олгогдчын зүгээс ахмадуудыг ажиллуулах сонирхол бага, ажлын байр гардаггүй.

*График – 3. Хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээл*



Хүн ам, хөгжлийн асуудлаарх ОУ-ын бага хуралд (Кайр, 1994) “Өөрийн хүчинд тулгуурлаасан бие даасан байдлыг дэмжих” /48/ тухай тэмдэгдэглэсэн байдаг. Хөдөлмөр эрхлэх тухай асуудал нь нэг талаас ажил олгогчийн, нөгөө талаас хувь хүний өөрийн сонирхолтой холбоотой бөгөөд эдгээрийн хоорондох харилцааг зохих хуулиар зохицуулдаг. Ялангуяа тэтгэврийн насныхны үргэлжлүүлэн ажиллах эсэх нь хувь хүний сонирхол, чадамж (бие эрхтэн, оюун ухаан, сэтгэл зүйн)-ийн талаарх өөрийн үнэлгээнээс хамаарна.

***Схем – 1. Хөдөлмөр эрхлэх боломж***




Ажилтан үргэлжлүүлэн ажиллах сонирхолтой байгаа нь дээрх нөхцөл (бие махбод, оюун санаа, сэтгэл зүйн)-ийг илэрхийлэх бөгөөд хуулиар олгосон боломжийг нь олгох, эрхийг нь хамгаалах талын ажил чамлалттай. Арга зүйн хувьд хөдөлмөрийн онцлог буюу биеийн хүч голлосон, биеийн болон оюуны хөдөлмөр хосолсон, оюуны хөдөлмөр давамгайлсан гэх гурван түвшинд гурван чадамжийн аль нь чухал болохыг тодорхойлон хувь хүний өөрийн үнэлэмжид тулгуурлан хөдөлмөр эрхлэх боломжийг нь нээлттэй үлдээх хэрэгцээ байгаа нь дээрх үр дүнгүүдээр баталгаажиж байгаа юм. Боловсролын салбарт энэ боломж харьцангуй өндөр юм. Гол нь хөдөлмөрийн нөөцийг бүрэн ашиглаж чадахгүй, үнэгүйдүүлэх хандлагыг засаж, залруулах бодит хэрэгцээ.

**Дүгнэлт, зөвлөмж**

Нэг. Ахмадуудын хөдөлмөрийн насыг нэмж, хөдөлмөр эрхлэх боломжийг зохих хууль эрх зүйн актаар баталгаажуулж, ажилтны өөрийн хүсэл сонирхлыг харгалзан үзэхээр зохицуулсан ч ажил олгогчдын хандлагаас үүдэлтэй хөдөлмөр эрхлэх боломж нь хязгаарлагддаг болох нь ахмадуудын дунд хийсэн судалгааны үр дүн, статистик мэдээллээс тодорхой ажиглагдаж байна.

Хоёр. Ажилтны сонирхол нь өөртөө биеийн, оюуны чадамж, сэтгэл зүйн буюу хүсэл тэмүүллийг агуулах бөгөөд үүнийгээ баталгаажуулан илэрхийлж буй нь үргэлжлүүлэн хөдөлмөрлөх боломжтойг илэрхийлэх баталгаа болно. Үүнийг хөдөлмөрийн халамжийн тухай хууль болон хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулсныг хэрэглээ болгох нь хязгаарлагдмал байна.

Гурав. “Боловсролын түвшин дээшлэх тусам тэтгэвэртээ гарсаны дараа ажил эрхлэх магадлал нь өсдөг” гэж үздэг бөгөөд боловсролын салбарт ажиллагсдын дундах ахмадуудын эзлэх хэмжээ хөдөлмөр эрхэлж буй нийт ахмадуудын эзлэх хэмжээнээс өндөр байгаа ч хөдөлмөр эрхлэлтийн статистик мэдээллийг нарийвчлах байдлаар нөөцийг үр ашигтай ашиглах талын ажил хязгаарлагдмал аж.

**Ашигласан материал**


1. ILO. (1980, 6 23). *International Labour Organization*. Retrieved 11 8, 2021, from International Labour Organization Web site: https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12100:0::NO::P12100_ILO_CODE:R162
2. ILO. (2015, 4 7). *International Labour Organization*. Retrieved 11 8, 2021, from International Labour Organization Web site: https://www.ilo.org/global/about-the-ilo/multimedia/audio/WCMS_358943/lang--en/index.htm
3. KAS. (2020). *Монгол улсын ахмад настны нийгмийн хамгааллын эрх зүйн зохицуулалт.* Улаанбаатар.
4. Ариунзаяа.А. (2021, 10 21). НДС энэ байдлаараа алдагдалтай байвал 2040-2045 он гэхэд бүрэн дампуурна. (Бурмаа.Б, Interviewer)
5. Батхишиг.Б. (2019). Тэтгэврийн тогтолцоог шинэчлэх асуудал. *Ахмадуудын нийгэм-эдийн засгийн байдал, цаашдын хандлага* (pp. 27-35). Улаанбаатар: Содпресс ХХК.
6. БШУЯ. (2021, 1 20). *Боловсрол, шинжлэх ухааны яамны веб сайт.* Retrieved 11 5, 2021, from https://www.meds.gov.mn/post/64834
7. Сүхбаатар.Ц. (2019). Монголын ахмадуудын өнөөгийн байдал, цаашдын хандлага зорилтын тухай. *Ахмадуудын нийгэм-эдийн засгийн байдал, цаашдын хандлага* (pp. 21-26). Улаанбаатар: Содпресс ХХК.
8. УИХ. (1994, 6 7). Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай. Улаанбаатар, Монгол.
9. УИХ. (2012, 1 19). Нийгмийн халамжийн тухай. Улаанбаатар, Монгол.
10. УИХ. (2015, 6 16). Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого. Улаанбаатар, Монгол.
11. УИХ. (2015, 6 16). Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай. Улаанбаатар, Монгол.
12. УИХ. (2021, 7 2). Хөдөлмөрийн тухай (Шинэчилсэн найруулга). Улаанбаатар, Монгол.
13. Ундрал.Ё. (2019). Ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга зам. *Ахмадуудын нийгэм-эдийн засгийн байдал, цаашдын хандлага* (pp. 52-59). Улаанбаатар: Содпресс ХХК.
14. ҮСХ. (2021). 15, түүнээс дээш насны ажиллагчид (хөдөлмөр эрхлэлтийн статусын ангиллаар, хүйс, насны бүлэг, аймаг, нийслэлээр улирал, жилээр). Улаанбаатар, Монгол.
15. ҮСХ. (2021, 4 22). Монгол улсын хүн амын тоо (насны бүлэг, хүйсээр). Улаанбаатар, Монгол.
16. ҮСХ. (2021, 7 5). Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо (төрлөөр). Улаанбаатар, Монгол.
17. ХХҮЕГ. (2021). *Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар.* Retrieved from Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын веб сайт: http://www.hudulmur-halamj.gov.mn/uploads/files/%D0%90%D1%85%D0%BC%D0%B0%D0%B4%D1%8B%D0%BD%20%D0%A5%D0%AD%D0%94%D0%A5.pdf

***Эрдэм шинжилгээний илтгэл (дотоод)***

**Ж.Батжаргал.** Ахмад настны нийгмийн оролцоо. (44 слайд //“XXI зуун-гэр бүл: ахмад настны нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх арга зам” ЭШБХ. Зохион байгуулагч: ОУУБИС. Гэр бүл, сэтгэл судлалын тэнхим. УБ., 2022 оны 6 сарын 03.


















## Ахмадуудын нийгмийн оролцоог тодорхойлоход ашигласан үзүүлэлтүүд

| Эерэг үнэлгээ (+1) | Сөрөг үнэлгээ (-1) |
|---|---|
| I. Нийгмийн амьдралын идэвх оролцоо, хувь сонирхол | |
| Маш их, их сонирхож идэвхтэй оролцдог | Идэвх сонирхол бага, өөрөө оролцдоггүй |
| Оролцох хувь их, оролцох сонирхол байдаг | Оролцох хувь бараг байдаггүй, огт оролцдоггүй |
| II. Эдийн засгийн оролцоо | |
| Ажил хийдэг | Ажил хийдэггүй |
| Ажил хийх, орлого олох боломж бүрэн бүрдсэн | Огт бүрдээгүй |
| III. Гэр бүлийн оролцоо | |
| Гэр бүлдээ үүрэг оролцоо өндөр | Гэр бүлдээ оролцоо бага, оролцоогүй |
| Ахуй хангамжийн боломж бүрэн бүрдсэн | Ахуй хангамжийн боломж огт бүрдээгүй |
| IV. ОН-ийн үйл ажиллагааны оролцоо | |
| ОН үйл ажиллагааны оролцоо өндөр | Оролцоо байхгүй |
| ОН-ийн ҮА-нд оролцох бүрэн боломжтой | Огт бүрдээгүй |
| V. Нийгэм улс төрийн үйл ажиллагааны оролцоо | |
| Сонгуулийн, иргэний үйл ажиллагаа, хурал цуглаанд оролцдог | Оролцоо байхгүй |
| Тэгш оролцох боломж бүрэн бүрдсэн | огт бүрдээгүй |
| VI. Шийдвэр гаргах оролцоо | |
| Асуудлыг бие дааж өөрөө шийдвэрлэдэг | Асуудал бусдын нөлөөгөөр л шийддэг |
| Шийдвэр гаргахад оролцох боломж бүрэн бүрдсэн | Шийдвэр гаргахад оролцох боломж огт бүрдээгүй |
| VII. Сэтгэлзүйн оролцоо | |
| ОН-ийн мэдээллийн сувгаар нэгдэж, санал бодлоо илэрхийлдэг | ОН-ийн мэдээллийн сувгаар нэгдэж, санал бодлоо илэрхийлдэггүй |
| Бусдад үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх боломж бүрэн бүрдсэн | Бусдад үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх боломж огт бүрдээгүй |
| VIII. Төрийн болон нийгмийн үйлчилгээний хамрагдалт | |
| Асрамж сувилал, эрүүл мэнд, рашаан сувиллаар хамрагддаг | Асрамж сувилал, эрүүл мэнд, рашаан сувиллаар хамрагдаагүй |
| Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломж бүрэн бүрдсэн | огт бүрдээгүй |
| IX. Нийгмийн харилцаа | |
| Хүмүүстэй тогтмол харилцдаг | Ямар нэг бүлгийн хүмүүстэй харилцдаггүй |
| Бусдын туслалцаа, дэмжлэг их, маш их шаардлагатай | Бусдын туслалцаа, дэмжлэг шаардлагагүй, бага зэрэг шаардлагатай |

7

## Нийгмийн оролцооны индекс, шалгуур үзүүлэлтүүд

- Нийгмийн оролцоог хэмжиж буй эдгээр 9 үзүүлэлт бүгд адил жинтэй, тус бүр 2 шалгуур үзүүлэлтээс бүрдэж буй бөгөөд онцлох эерэг хариулт (+1), онцлох сөрөг хариултанд (-1), бусад хариултанд (0) утга оноосон. Нийгмийн оролцооны нэгдсэн индексийг тооцоолоход тархалт нь -17-оос +17-гийн хооронд, медиан утга 4.6, дундаж нь 5, мод нь 7 байв. Сөрөг үнэлгээтэй нь 19.6 хувийг эзэлж байгаа бол эерэг үнэлгээтэй нь 80.4 хувь байна.
- Нийгмийн оролцооны индексийн тархалт




8


Нийгмийн оролцооны төлөв
Нийгмийн идэвх, оролцоо дундаж бүлэгт олонх нь хамаарагдаж байна. Ахмадуудын нийгмийн идэвх, оролцоо харьцангуй сайн байна. Судалгаанд оролцогч ахмадуудын 3/5 нь оролцоо маш өндөр, өндөр байгаа бол дундаж оролцоотой, 1/3 нь оролцоо дундаж, ойролцоогоор 1/10 нь оролцоо бага, маш бага болон оролцоогүй байна.
8.6
0.7
14.8
30.3
45.6
9


Олон хүчин зүйлийн регрессийн коэффициентүүд
Олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээний үр дүнд үүссэн загвар нь статистик ач холбогдолтой (F=751.824, p=0.000) буюу нийгмийн оролцооны ерөнхий индекс ба доорх 9 хүчин зүйлийн хооронд шугаман хамаарал байна гэдгийг нотлож байна.

| Model | | Unstandardized Coefficients B | Std. Error | Standardized Coefficients Beta | t | Sig. |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | (Constant) | -.034 | .024 | | -1.426 | .154 |
| | Нийгмийн амьдралын идэвх оролцоо | .162 | .010 | .284 | 16.816 | .000 |
| | Эдийн засгийн оролцоо /ажиллах/ | .149 | .006 | .279 | 23.878 | .000 |
| | Гэр бүлийн оролцоо | .162 | .012 | .169 | 13.976 | .000 |
| | ОН-ийн үйл ажиллагааны оролцоо | .141 | .012 | .204 | 11.847 | .000 |
| | Нийгэм улс төрийн YA-ны оролцоо | .134 | .010 | .166 | 13.185 | .000 |
| | Шийдвэр гаргах оролцоо | .140 | .009 | .187 | 14.934 | .000 |
| | Сэтгэл зүйн оролцоо | .138 | .013 | .154 | 10.942 | .000 |
| | Нийгмийн харилцаа | .135 | .010 | .155 | 12.974 | .000 |
| | Төрийн болон НҮ-ний хамрагдалт | .138 | .010 | .221 | 13.476 | .000 |

a. Dependent Variable: Participation_index_PS_ch
10


Нийгмийн оролцоо НХАЗ-н бүлгээр
Нийгмийн оролцооны түвшин ахимаг, ахмад өндөр, өтөл настан гэсэн насны 4 бүлгээр харьцангуй ойролцоо тархалттай буюу өндөр, илүү өндөр оролцоотой ахмадууд 57-63 хувийн давтамжтай байв. 70-аас дээш насныхан дунд оролцоо маш бага, болон ямар ч оролцоогүй байдаг ахмадууд харьцангуй олонх буюу эл үзүүлэлт ахимаг насныхны тухайн бүлгээс 4 пунктээр их, ахмад, болон өндөр настны бүлгээс 2-3 дахин өндөр байв.
Эмэгтэйчүүдийн нийгмийн идэвх оролцоо эрэгтэйчүүдээсээ арай давамгай байна. Зурагт нийгмийн оролцооны түвшин өндөр бүлэгт харъяалагдаж байгаа эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 4 пунктээр л илүү байна.
Оршин суугаа газар
Хөдөө
Хот
Хүйс
Эмэгтэй
Эрэгтэй
Насны бүлэг
70-аас дээш
65-69 нас
60-64 нас
55-59 нас
Боловсрол
Тусгай дунд, дээд
Бүрэн дунд
ББД, түүнээс доош
0 10 20 30 40 50 60
Оролцоо байхгүй
Оролцоо бага
Оролцоо дундаж
Оролцоо өндөр
Илүү өндөр
11


12


Нийгмийн оролцооны түвшин ба хүчин зүйлсийн хоорондын хамаарлын матриц

| | АЭЭ | ТӨО | ТХ | БД | ХЭ | НК | ЭМ | БОЛ | ГБ | ТБХ | НОИ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ажил эрхэлдэг эсэх | 1 | | | | | | | | | | |
| Тэтгэврээс өөр орлого | .749 | 1 | | | | | | | | | |
| Тэтгэврийн хэмжээ | .077 | .112 | 1 | | | | | | | | |
| Бусдын дэмжлэг | .093 | .074 | .139 | 1 | | | | | | | |
| Хуримтлалтай эсэх | .241 | .151 | .090 | .095 | 1 | | | | | | |
| Нийгмийн капитал | .236 | .136 | -.093 | .054 | -.021 | 1 | | | | | |
| Эрүүл мэнд | .127 | .097 | .166 | .160 | .171 | .075 | 1 | | | | |
| Боловсрол | .111 | .086 | .367 | .059 | .096 | -.055 | .067 | 1 | | | |
| Гэрлэлтийн байдал | -.120 | -.100 | -.179 | -.137 | -.051 | -.037 | -.120 | .006 | 1 | | |
| Тэтгэвэр  байгаа хугацаа | .152 | -.066 | .060 | -.023 | .003 | .024 | .086 | -.023 | -.034 | 1 | |
| Нийгмийн оролцоо | .358 | .309 | .221 | .230 | .276 | .236 | .146 | .209 | .020 | .085 | 1 |

Ажил эрхэлдэг, тэтгэврээс өөр орлоготой, бусдын дэмжлэг туслалцаагүй харилцах чадвартай, пишүүнчлэлтэй, нийгмийн капиталтай, боловсролын түвшин өндөр, эрүүл мэнд нь харьцангуй сайн ахмадууд нийгмийн оролцоо илүү байна
13


Нийгмийн оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлсийн ерөнхий загвар
Хувь хүний хүчин зүйл
Эрүүл мэнд, ХБ
Санхүүгийн байдал, чадвар
Гэрлэлтийн байдал, Зан төлөв, темперамент
Ажил амьдралын зохицуулах
Ажлын амлалт
Боловсрол, ажил эрхлэлт
Бие даасан байдал
Амьдралд болж гол үйл явдал
Нийгмийн орчны хүчин зүйл
Зохион байгуулалттай үйл ажиллагаа, бүлгийн бүтэц, зохион байгуулалт
Нийгмийн үйл ажиллагаанд оролцох боломж, хүртээмжтэй байдал
Нийгмийн оролцоонд хандах соёлын хандлага
Бүлгийн хэмжээ, интграл
14


Нийгмийн оролцооны хүрээ ба хэлбэрүүд
НХҮ-ний хамрагдалт
Гэр бүл дэх оролцоо
Нийгэм-улс төрийн
Нийгэм-ОН-ийн оролцоо
Сэтгэл зүйн оролцоо
15





*Нийгмийн оролцооны хүчин зүйлсийн тархалт, хувиар*

| Оролцооны түвшин | ИОХ | ЭЭО | ГБО | ОНО | НУТ | ШГО | СЭО | НҮХ | НХ | НОЕИ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Маш бага, оролцоогүй | 3.5 | 51.9 | .2 | 12.8 | 4.6 | 2.9 | 2.2 | 23.0 | 2.0 | .7 |
| Оролцоо бага | 5.2 | 1.0 | 7.7 | 9.7 | 37.0 | 14.6 | 12.8 | 14.6 | 4.3 | 8.6 |
| Дундаж | 12.2 | 25.2 | 9.8 | 34.0 | 6.4 | 17.6 | 16.6 | 26.3 | 20.1 | 30.3 |
| Өндөр | 18.6 | - | 41.5 | 24.6 | 49.6 | 31.4 | 53.1 | 19.6 | 31.2 | 45.6 |
| Маш өндөр | 60.5 | 21.9 | 40.8 | 18.9 | 2.4 | 33.5 | 15.4 | 16.5 | 42.3 | 14.8 |

17

**Гэр бүл дэх оролцоо**

*Ц–Тэтгэврээрээ дандаа зээл авсаар гар дээрээ мөнгө авч үзээгүй. Тэтгэврээр зээл авч 3 хүүхэд сургаж, сургалтын мөнгө төллөө. Одоо тэтгэврийн зээлтэй, 6 сараар бас авчихсан. Тариа тарих гээд мөнгө шаардлагатай болоод зээл аваад өгчихсөн. Тариагаа хураагаад олсон мөнгө нь зээлэндээ ихэнхийг өгчихдөг. … Надад ер нь цаг зав байхгүй. Би чинь гэр бүл байхгүй. Хэдэн хүүхдийнхээ дунд бүх зүйлийг нь зохицуулах гээд явдаг. Тэднийхээ хоол унд, хувцас хунар, сургууль соёл, наашцааш нь болгох гээд завгүй. Тэтгэвэрт гарснаар илүү гэр орны ажилдаа цаг заваа зарцуулах болсон.* *(бүгд санал нэгдэв)*

*Н -Үнэн, гэр орны ажил гээд илүү ачаалалтай болдог.*

*А -Ач зээг нааш цааш нь зөөнө.*

*ФБЯ, Хөвсгөл, амьжиргааны түвшин дундаж бүлэг*

*Б -Ус түлээг нь, хоол ундыг нь бэлдээд тавьчихлаа. Тэнд нэг эмгэн өвгөн хоёр хөлсний ажилчин шиг л байна. "Ашгүй тэтгэвэр бууж байгаа гэнэ. Он гаргаад 6 сараар зээл авч өгөөрэй" гэнэ, яах гэж байгаа юм мэдэхгүй. Өрх толгойлоод байж байгаа юм чинь өөрсдөө үүрэх хэрэгтэй гэдгийг залуучуудад суулгаж өгөх хэрэгтэй байна.*

*ФБЯ, Хөвсгөл, амьжиргааны түвшин доогуур бүлэг*

19

**Нийгэм улс төрийн оролцоо**

- Ахмадуудын 3.6 хувь нь сонгууль, намын үйл ажиллагаа, хурал цуглаанд идэвхтэй оролцох нь өмнөх судалгаануудтай харьцуулахад бага гарч байна. Энд ковидын нөхцөл байдал нөлөөлсөн нэг том хүчин зүйл болжээ
- Статистикийн мэдээгээр 2016 оны сонгуулиар 50-60 насныхны 90.3 хувь, 60-аас дээш насныхны 97 хувь нь сонгуульд санал өгч байсан




20

*Ахмад настны НУТ-ийн оролцоо, нийт, насны бүлгээр*

- Нийгэм улс төрийн оролцооны нэгдсэн үзүүлэлтээр ахмадуудын оролцоо өндөр, оролцоо бага гэсэн 2 бүлэг үндсэндээ хуваагдаж байна. Насны бүх бүлгүүд НУТ-ийн оролцооны хувьд оролцоо бага, оролцоо өндөр гэсэн 2 хэсэгт ялгарч байна. 65-69 насныхны тус бүр 48 хувь нь оролцоо бага, маш бага оролцоотой, 55-59 насныхны 54 хувь, 60-64 насныхны 49 хувь нь 70-аас дээш насныхны 59 хувь нь өндөр, илүү өндөр оролцоотой.




21

**Нийгэм-олон нийтийн үйл ажиллагааны оролцоо**

- Ахмадын холбооны үйл ажиллагаа болон урлаг соёл, боловсролын арга хэмжээнд насны бүлэг ахих тусам оролцоо илүү өндөр болжээ.

| | Нийт | | | Хот /хувь/ | Хөдөө /хувь/ |
|---|---|---|---|---|---|
| | Давтамж | Хувь | Т.хувь | | |
| Оролцоогүй | 83 | 4.8 | 10.1 | 5.7 | 2.9 |
| Олон нийтийн үйл ажиллагааны оролцоо | 1602 | 93.3 | 194.4 | 92.2 | 96.4 |
| • Олон нийтийг хамарсан аян | 323 | 18.8 | 39.2 | 18.8 | 18.9 |
| • Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаа | 238 | 13.9 | 28.9 | 15.6 | 9.8 |
| • Шашин номын акил, буяны үйлсэд | 119 | 6.9 | 14.4 | 4.7 | 12.2 |
| • Гудамж, СӨХ-ийн үйл ажиллагаа | 153 | 8.9 | 18.6 | 10.0 | 6.4 |
| • Урлаг соёл, боловсролын арга хэмжээ | 142 | 8.3 | 17.2 | 7.3 | 10.6 |
| • МАхХ-ны үйл ажиллагаанд оролцдог | 469 | 27.3 | 56.9 | 25.5 | 31.7 |

22

*Ахмад настны НУТ-ийн оролцоо, нийт, насны бүлгээр*

- Ахмад настнуудын олон нийтийн үйл ажиллагааны оролцоо дундаж, дунжаас дээгүүр байна. Ойролцоогоор 1/3 нь дундаж, ¼ нь өндөр, 1/5 нь илүү өндөр түвшинд оролцдог.
- Насны бүлэг бүлэг дээшлэх тусам дундаж, дунджаас дээш оролцоотой ахмадууд ихэсэж байна. Оролцоогүй, маш бага оролцоотой болон өндөр, илүү өндөр оролцоотой ахимаг насныхан хамгийн өндөр хувийг мөн эзлэж буй бол өтөл насны ахмадуудын 57 хувь нь хамгийн өндөр, илүү өндөр оролцоотой байгаа нь бусад насны бүлгээс 8- 25 пунктээр илүү байгаа юм.



| | Оролцоогүй маш бага | Оролцоо бага | Дундаж | Өндөр | Илүү өндөр |
|---|---|---|---|---|---|
| 55-59 нас | 18.5 | 8.7 | 40.3 | 21.5 | 11.1 |
| 60-64 нас | 9.2 | 11.8 | 30.8 | 25.4 | 19.7 |
| 65-69 нас | 8.6 | 10.3 | 31.4 | 25.4 | 24.3 |
| 70-аас дээш | 12 | 7.2 | 23.2 | 29.6 | 28 |
| Бүгд | 12.8 | 9.7 | 34 | 24.6 | 18.9 |

23

**Ахмадуудын оролцдог үйл ажиллагааны тоо, хот хөдөөгөөр**







24


Сэтгэл зүйн оролцоо
Нийгэм, улс төрийн асуудлын талаарх мэдлэг, ойлголтын түвшинг илэрхийлэгч үзүүлэлт
Мэдээллийн эх сурвалж, хот хөдөөгөөр
Сонирхон авч буй мэдээлэл
Хөдөө
Хот
Нийт
0 5 10 15 20 25 30
0 5 10 15 20 25 30 35 40
25


Анхаарал тавьсанд баярлалаа.
Та бүхэн дараах email-ээр холбогдож болно:
jargalbj999@gmail.com
batjargalj@mas.ac.mn
44

***Эрдэм шинжилгээний илтгэл (дотоод)***

Ж.Батжаргал. Ахмад настны нийгмийн харилцаа, нийгмийн капиталын байдал. (25 слайд). //“Монголын нийгмийн харилцаа: төлөв байдал, хандлага” социологийн VI симпозиум. Зохион байгуулагч: МУИС, НШУС, Нийгмийн судалгааны хүрээлэн. УБ., 2022.6.15.




















Нийгмийн харилцаа, нийгмийн капитал
Судалгааны үр дүн
2




Тэтгэвэрт гарснаас хойш гарсан өөрчлөлт
Ахмадуудын 51.7 хувь нь бусадтай харилцах нь багассан (2015, N=400)
Тэтгэвэрт гарснаас хойш танил танил хүрээ буурсан 30.2%
Бусадтай харилцах, олны дунд байх нь багассан 28.6%
Танил талын хүрээ
Бусадтай харилцах, олны дунд байх
Хувийн зохтой байдал
Сэтгэл санаа
Эрүүл мэнд
Санхүүгийн байдал
Орон байр, сууцны нөхцөл
Хувцаслалт
Хооллолт
0 20 40 60 80 100
Сайжирсан Хэвэндээ Дордсон
8




Ахмад настны нийгмийн харилцаа
Ахмад настны нийгмийн харилцаа
Насны бүлэг дээшлэх тусам маш сул, сул харилцаатай бүлэг багасаж, харилцаа өргөжиж, ялангуяа 65-аас дээш насныхны харилцаа илүү өргөн хүрээтэй.
Хотод харилцаа сул, маш сул бүлэг илүү өндөр хувьтай,
Өргөн, илүү өргөн харилцаатай хүмүүс хөдөөд давамгай байна.
Эрэгтэйчүүдийн дунд харилцаа сул, маш сул байгаа нь эмэгтэйчүүдийн бүлэгт харилцаа өргөн, илүү өргөн байгаа нь давамгайлсан.
Ахмадууд гэр бүл, үр хүүхэд (35%); найз нөхөд (25%); хөршүүд (17%), хамт ажилпагсадтай (13%) харилцаатай байхыг чухалчилж байна.
Хөдөө
Хот
Эмэгтэй
Эрэгтэй
70-аас дээш
65-69 нас
60-64 нас
55-59 нас
0.0% 10.0% 20.0% 30.0% 40.0% 50.0%
9




Ахмад настны нийгмийн харилцаа, нийгмийн сүлжээ
Нийгмийн харилцаа маш сул
Харилцаа өргөн бүлэг
I Кластер 17.2%
II Кластер 19.9%
III Кластер 35.1%
IV Кластер 27.9%
Харилцаа сул
Харилцаа хамгийн өргөн бүлэг
10




Нийгмийн сүлжээ
I Кластер = "Гэр бүлийн сүлжээ"
Гэр бүлийн хүмүүстэй нягт,
Бусад хүмүүстэй идэвхгүй харилцаатай
II Кластер = "Танил талын сүлжээ"
Гэр бүлийн хүмүүстэй нягт,
Анхдагч бүлгийнхэнтэй холбоотой,
Албаны хүмүүстэй идэвхгүй
III Кластер = "Ажил хэргийн сүлжээ"
Гэр бүлийн хүмүүстэй нягт,
АхХ, БД, НА, ТБАТ, НН-тэй харилцаатай
Хөрш, танил, хүүчин ажлын ХО-той идэвхгүй
IV Кластер = Төрөл бүрийн сүлжээ =
ГБ, НН, ХС-тай тогтмол нягт,
Бусадтай нь харилцаатай
11




Ахмад настны нийгмийн сүлжээ, нас, байршлаар
Гэр бүлийн
Ахмаг насныхны 18%
Ахмад настны 17%
өндөр настны 16%
өтөл настны 15%
Хотынхны 18%
Хөдөөгийнхний 15%
Танил талын
55-64 насныхны 22%
65-69 насныхны 16%
70-аас дээш -15%
Хотын -21%
Хөдөөгийнхний 16%
Ажил хэргийн
55-69 насныхны 33%
70-аас дээш -45%
Хотын -35%
Хөдөөгийнхний 38%
Төрөл бүрийн
55-64 насныхны 27%
65-69 насныхны 32%
70-аас дээш -26%
Хотын -26%
Хөдөөгийнхний 33%

## Ахмад настны нийгмийн капиталын шалгуур үзүүлэлт




## Олон хүчин зүйлийн регрессийн коэффициентууд

- Олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээгээр нийгмийн капиталын индекс ба 9 шалгуур үзүүлэлтүүд шугаман хамааралтай (F=277.304, p=.000).
- Нийгмийн капиталын индексийн өөрчлөлтийн 93 хувийг тайлбарлаж байна.

| Model | | Unstandardized Coefficients | | Standardized Coefficients | t | Sig. |
|---|---|---|---|---|---|---|
| | | B | Std. Error | Beta | | |
| 1 | (Constant) | -.053 | .033 | | -1.594 | .113 |
| | Гишүүнчлэл | .260 | .043 | .153 | 6.066 | .000 |
| | Харилцааны түвшин | .318 | .021 | .335 | 15.073 | .000 |
| | Итгэл | .294 | .029 | .203 | 10.258 | .000 |
| | ОНҮА-ны оролцоо | .343 | .078 | .218 | 4.404 | .000 |
| | Сэтгэлгийн оролцоо | .382 | .072 | .259 | 5.333 | .000 |
| | Харилцааны өөрчлөлт | .336 | .069 | .143 | 4.890 | .000 |
| | Нийгмийн сүлжээний өөрчлөлт | .261 | .066 | .112 | 3.942 | .000 |
| | Бусдын хүндэтгэл хүлээх | .356 | .061 | .143 | 5.794 | .000 |
| | Хувийн аюулгүй байдал | .296 | .077 | .079 | 3.845 | .000 |

a. Dependent Variable: socialcapital_INDEX_fin9_ch

14

## Ахмад настны нийгмийн капиталын индекс

Нийгмийн капиталын индексийн тархалт *(Mean 0.49; Mode -1; Median 1)*




## Ахмад настны нийгмийн капиталын байдал




## Нийгмийн харилцаа, НК ямар үр нөлөө үзүүлэх вэ

- *Харилцаа ба дасан зохицол*

Маш сул, сул харилцаатай хүмүүс дасан зохицож чадаагүй байгаа нь давамгай байгаа бол, өргөн, илүү өргөн харилцаатай ахмадуудын хувьд тэтгэврийн дараах амьдралдаа сайн зохицож чадсан нь харилцаа муутай ахмадуудаас 11.5-8 пунктээр илүү байна.




## *Харилцаа ба эдийн засгийн боломж*

**Маш сул, сул харилцаатай**

- ТӨО-той хүмүүсийн 18%
- ТӨО-той бүлгийн 9.8%
- Ажил эрхлээгүй ахмадуудын 40.3%
- Ажил эрхлэдэг ахмадуудын 30.2%

**Өргөн, илүү өргөн харилцаатай**

- ТӨО-той бүлгийн 12-19%
- Ажил эрхлээгүй ахмадуудын 60%
- Ажил эрхлэдэг ахмадуудын 69.8%

**Харилцааны түвшин**

- Ажил хийдэг (r=.122),
- Тэтгэвэрт гарснаас хойш санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт(r=.098)
- Хот хөдөө(r=.075),
- Дасан зохицсон байдал(r=.101)

18

## Харилцаа ба ахмад настны сайн сайхан байдал

Ахмад настны сайн сайхан байдлын үзүүлэлт 47.6 хувь нь маш сайн, сайн, 38,2 хувь нь муу, маш муу байна гэж гарчээ.

Боловсрол(r=-.095), Хот, хөдөө (r=-.284),
Нийгмийн капитал (r=.121),
Нийгмийн оролцооны түвшин(r=-.262),
Санхүүгийн нөөц(r=.214),
Амьжиргааны түвшний үнэлгээ(r=.340),
Дасан зохицол (r=.308),
Стресс (r=.289) гэсэн хүчин зүйлс нөлөөлж байна.




19

## Ахмад настны эрүүл мэнд, стресст нөлөөлж буй хүчин зүйлс

### Эрүүл мэнд

- Дасан зохицол (r=.324),
- Нийгмийн оролцоо (r=-.146),
- Ажил хийдэг эсэх(r=.127)
- Тэтгэврээс өөр орлого (r=.097), Тэтгэврийн хэмжээ(r=.166),
- Бусдын тусламж дэмжлэг (r=.160),
- ТХ санхүү(r=.181)
- ТХ нийгмийн статусын өөрчлөлт (r=.108), Хувцаслалт(r=.070)
- Хооллолтонд(r=.080) гарсан өөрчлөлт
- Санхүүгийн нөөц(r=.114)
- Хүйс (r=-.176)

### Стресс

- Боловсрол(r=-.111),
- Ганцаардал(r=.756,
- ТХ нийгмийн статусын өөрчлөлт(r=.108),
- ТД өөрийн үнэлгээ(r=.096),
- Өнгөрүүлсэн амьдралын сэтгэл ханамж(r=.102),
- Дасан зохицол (r=-.142)

20

## Нийгмийн капитал, нийгмийн оролцоо ба эрүүл мэнд

- Нийгмийн капитал, нийгмийн оролцооны түвшин дээшлэх тусам эрүүл мэндийн үнэлгээ нь сайжирч байгаа бол, түвшин доошлох тусам эрүүл мэндийн үнэлгээ буурч байна.
- Нийгмийн капитал, нийгмийн оролцоо өндөр, илүү өндөр бүлгүүдийн эрүүл мэндийн байдлаа сайн гэж үнэлсэн хүмүүс илүү өндөр хувьтай байгаа бол нийгмийн капитал, оролцооны доогуур түвшинд байгаа ахмадуудын хувьд хүнд өвчтэй, байнга өвддөг гэсэн нь хамгийн өндөр давтамжтай байна.
- Нийгмийн капитал ба эрүүл мэнд (r=.146, p=.000) хоорондын хамаарал ач холбогдолгүй,
- Нийгмийн оролцооны түвшин ба эрүүл мэндийн хоорондын хамаарал (r=.146, p=.000) ач холбогдолтой.
- Эрүүл мэндийн асуудалтай ахмадуудын дотор нийгмийн оролцоо бага байна. Нийгмийн оролцоо багатай байх нь эрүүл мэндийн асуудалд оруулж байна.

21

## Дүгнэлт

- Манай ахмадуудын хувьд нийгмийн сүлжээ олон байгаа ихэнх нь сүлжээний гишүүдтэй идэвхгүй харилцаатай, хэрэгцээ гарсан үед л холбогддог. Харилцах давтамж сул байна. Нэг гол онцлог нь гэр бүлийн харилцаа маш нягт, гэр бүл, ах дүүгийн сүлжээнд тогтмол харилцаатай байна. Гэхдээ гэр бүлийн ойр дотны цөөн гишүүдийн хүрээнд тогтвортой нягт гүнзгий харилцаатай байгаа нь нийтлэг ажиглагдав.
- Чанарын судалгааны үр дүнгээс харахад гэр бүлийн тогтвортой нягт сайн харилцаа нь ахмадуудын тэтгэврийн дараах сэтгэлзүйн хямралыг даван туулж, шинэ амьдралын хэв маягт хурдан дасан зохицоход туслах нэг гол хүчин зүйл болж байна.
- Байнгын идэвхтэй нийгмийн оролцоо нь ахмадуудын хувьд эрүүл мэнд харьцангуй сайн, амьдралын идэвхтэй, сэтгэл өөдрөг байх нэг хүчин зүйл болж байна. Эсрэгээрээ оролцоо багатай, харилцаа холбоо сул ахмадуудын хувьд эрүүл мэнд суларч доройтох, стресст өртөх, сэтгэл гутрах, өтлөлт илүү хурдан явагдах, амьдралын сайн сайхан байдал бага байх явдал ажиглагдаж байна.

22

- Тэтгэвэрт гарах, эхнэр нөхөр нь нас барах, хамт амьдарч байсан хүүхэд нь нас барж ганцаараа үлдэх, амьжиргаагаа залгуулах боломжгүй болох, эрүүл мэнд муудах зэргээс шалтгаалан нийгмийн үүрэг хариуцлага алга болж, харилцаа холбоо буурсан, нийгмийн оролцоо багассан тохиолдлууд байна.
- Өтөл настай хүмүүсийн дунд харилцааны давтамж, нийгмийн оролцооны идэвх илүү их ажиглагдаж байгаа нь нийгмийн үүрэг, найз нөхөд, гэр бүлийн гишүүдээ алдсан харилцаагаа нөхөж орлуулах үүднээс шинэ харилцаа холбоо тогтоож, илүү их харилцаанд орж байгаатай холбоотой бөгөөд мөн харилцааны энэ алдагдлаа даван туулж, дасан зохицож байгааг илтгэнэ. Нөгөө талаар олон ахмадууд гэр бүл, үр хүүхдээ авч явах, амьжиргаагаа залгуулахын тулд идэвхтэй оролцоотой байхаар хичээж, эрмэлзэж байгаатай, өөр нэг шалтгаан нь ахмадуудын амьдралын тогтсон хэвшил, дадаж сурсан зан, хүмүүжил, боловсролтой нь холбоотой байна.
- Ахмадуудын хувьд нийгмийн капиталын нөөц баялаг нь "холбогч нийгмийн капитал" байна. Холбогч нийгмийн капитал давамгайлж, "гүүр бологч капитал" буюу босоо хэлхээ холбоо харьцангуй доогуур сул байна. Нийгмийн оролцоог хангадаг, мэдээлэл, үзэл санаа, хэм хэмжээ, үнэт зүйлийн солилцоо болж байдаг гүүр бологч нийгмийн капиталыг бий болгох, бэхжүүлэх шаардлагатай.

23

Чанарын судалгааны дүнгээр ахмад настнуудын нийгмийн харилцаанд 1) эрүүл мэндийн байдал, 2) зан төлөв *(нийтэч, идэвхтэй, хувийн зохион байгуулалттай эсэх)* 3) гэр бүл, хамаатан садны харилцаа *(үр хүүхэд, ач зээ, ах дүү байгаа эсэх, тэдний хүрээлэл, харилцаа ойр нягт эсэх)*, 4) өөрөө болон үр хүүхдүүдийнх нь амьдралын боломж нөхцөл*(тааруу учраас харилцаа тодорхой хэмжээнд хязгаарлагддаг)* 5) өөртөө итгэх итгэл, өөртөө сэтгэл дундуур ханамжгүй байх, өөрийн сул талыг мэдрэх 6) харилцагч хосоо, найзалж нөхөрлөж явсан хэн нэгнийг алдах, харилцааны хүрээ хумигдах, 7) ажил хийх, чийрэгжүүлэлтийн төвд явах, хоббитой байх гэх мэт харилцааны орчин нөхцөл бүрдүүлэх зэрэг хүчин зүйл мөн нөлөөлж байна.

Ер нь ахмад насны нийгмийн оролцоо, харилцаа өргөн ч бай, хязгаарлагдмал ч бай ахмадууд хувийн асуудлаа хүнтэй ярилцдаггүй, хуваалцах хүн байхгүй байгаа нь тэдэнд сэтгэлзүйчийн туслалцаа, үйлчилгээ шаардлагатай байгааг харуулж байна.

24


Анхаарал тавьсанд баярлалаа.
Та бүхэн дараах email хаягаар холбогдож болно.
jargalbj999@gmail.com
batjargalj@mas.ac.mn
25

*Эрдэм шинжилгээний өгүүлэл (дотоод)*

# АХМАД НАСТНЫ АМЬЖИРГААНД НӨЛӨӨЛЖ БУЙ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛ

**_Б.Азбаяр, магистр_**
*ШУА-ийн Философийн хүрээлэнгийн*
*Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбарын*
*Эрдэм шинжилгээний ажилтан*

**Хураангуй:** Өөрчлөгдөн өнөөгийн дэлхий дээр 10 хүн тутмын нэг нь 60-аас дээш насны ахмадууд байгаа бол манай улсын хувьд 20 хүн тутмын нэг нь 60-аас дээш насны өндөр настнууд байна. Гэхдээ хүн амын насны бүтцэд өөрчлөлт орж, улмаар дундаж наслалт уртасч байгаатай холбоотойгоор энэ тоо ойрын жилүүдэд хоёр дахин өсчээ. Тухайлбал, сүүлийн 10 жилд Монгол Улсын нийт хүн амын тоо 16.1 хувиар өссөн байхад өндөр настны тоо 21.9 хувиар буюу үүнээс даруй 6 орчим хувиар хурдацтай өссөн байна. Бидний мэдэж буйгаар, энэхүү үүсч байгаа насжилтын үзэгдэл нь өнөөгийн тулгамдсан асуудлыг бий болгож буй нэг гол үндэс болж байна (ҮСГ, ДБ, НҮБХХ, 2004). Дээрх тоон мэдээллийн шинжилсэн НҮБ-ын Хүн амын сангийн тооцооллоор өнөөгийн бидний оршин амьдран буй нийгмийн анхаарлын төвд буй халамжийн зорилтот бүлэг болох ахмад настны нийт хүн амд эзлэх хувь 2010 онтой харьцуулахад 2020 онд 1.5 пункт, 2030 онд 5.3 пунктээр тус тус өсөх хандлагатайг тодорхойлсон (ҮСГ, ДБ, НҮБХХ, 2004). Үүнээс үзвэл, XXI зууны эхээр хөгшрөлтийн үйл явц зөвхөн хөгжингүй орнуудад илүү өрнөж байсан бол, өнөөдөр дэлхий даяар энэ хандлага түгээмэл ажиглагдах болсон. Тухайлбал, манай улсын хувьд ч хүн амын бүтцэд эзлэх ахмад настны тоо жилээс жилд өссөөр байгаа бөгөөд тус улсын нийт хүн ам 2017 онд 3.2 сая хүн болж, 2000-2017 онд 25.3 хувиар буюу жилд дунджаар 5.6 хувиар нэмэгдсэн байна. Харин ахмад настан 313.3 мянган хүн болж 45.6 хувиар, жилд дунджаар 4.4 хувиар нэмэгдсэн нь хүн амын 10.4 хувийг эзэлж байна.

Бид эл илтгэлдээ ахмад настны амьжиргаанд нөлөөлж буй зарим хүчин зүйлийн өнөөгийн учир шалтгааны мөн чанарыг тодруулан гаргах, ингэхдээ ахмадуудын өмнө тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлсон ба ерөнхий бүлэглэлийг гаргаж, улмаар тэтгэврийн хэмжээ, хүрэлцээний асуудлуудыг тус тус шинжлэх гаргахыг зорьсон болно.

## *(i) Асуудлын үндэслэлийг томъёолох нь*

Хүн амын насжилт нь нэг талаас эдийн засгийн бүтэц, гэр бүлийн үүрэг, ажиллах хүчний нөхөн үржихүйн байдал, эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн системийн зохион байгуулалт, зорилгод шууд нөлөөлдөг. Нөгөө талаас ахмад настнууд өөрсдөө өөрчлөгдөж буй нийгмийн нөхцөл байдалд дасан зохицох шаардлага бий болоод байна. Энэхүү нийгмийн бүлгийн амьдралын үйл ажиллагаа болон нийгмийн зохион байгуулалт нь амьдралын үйл ажиллагааны нөхцөл байдлаас ялгардаг. Өөрөөр хэлбэл, хүмүүс нас ахих тусам эрүүл мэндийн асуудал, өвчлөх эрсдэл нэмэгдснээр амьдралын боломжийг бууруулж байна. Насжилтын дүр төрх нь тухайн үеийн нийгмийн бүтцийг илэрхийлж байгаа бөгөөд түүхэн нөхцөлөөс хамаараад мэргэн, шударга, эрх мэдэлтэй аль эсвэл бие эрүүл мэндийн хувьд эрсдэлтэй тусламж дэмжлэг шаардлагатай, дүр төрх давамгайлж байна.

Монгол Улсын ахмад настнуудын 96 хувь нь орлогын гол эх үүсвэр өндөр насны тэтгэвэр боловч энэ нь тэдний амьжиргаанд төдийлөн хүрэлцдэггүй байна. Манай улсын хувьд ахмад настны амьжиргааны төлөв байдлыг тодорхойлж, түүний онцлогтой уялдуулан төрөөс үйл ажиллагаагаа төлөвлөх, ахмад настны хэрэгцээ сонирхол, үүрэг хариуцлагыг тодорхойлох асуудал тулгарч байна. Монгол Улсад ахмад настнуудын амьжиргаанд тулгамдаж буй асуудлаар хийсэн өргөн хүрээтэй

судалгааны ажил төдийлөн түгээмэл биш байна. Бид энэхүү өгүүлэлдээ түгээмэл хэрэглэгддэг нэр томъёоны тодорхойлолтыг оруулав. Тухайлбал,

*Ахмад настан* - Монгол Улсын “Ахмад настны тухай” хуульд зааснаар 60 түүнээс дээш настай эрэгтэй, 55 түүнээс дээш настай эмэгтэй хүн амыг хэлнэ гэж заасан бол,

*Амьжиргаа* - Үндсэн болон бусад хэрэгцээгээ тогтвортой хангахын тулд дангаараа болон хамтран ажил хөдөлмөр эрхлэх, орлого олох үйл ажиллагааг хамруулсан ойлголтыг хэлнэ.

*Нөөц боломж* - Эл ойлголтыг П.Бурдьегийн “Хүмүүн капитал”-ын онол болон Н.Е.Тихновагийн арга зүйн үүднээс авч үзэн, ахмад настны амьдрал, сэтгэл ханамж, амьжиргаанд нөлөөлж буй голлох гурван нөөц боломж буюу эдийн засаг, нийгэм, мэргэшлийн нөөцийг хамааруулна (Бурдье П, 1993).

*Эрсдэл* - Судалгааны ажлын хүрээнд эрсдэл гэдэг ойлголтод ахмад настны эдийн засаг, нийгэм, мэргэшлийн нөөц боломж бага буюу хомсдолтой байгаа гэсэн утгаар авч үзсэн.

*Гачигдал* (англ.deprivation-хомсдол) – хувь хүн, бүлэг өөрийгөө бусад хүн, бүлэгтэй харьцуулснаар аливаа нэгэн дутагдал, хомсдолтой байгаа гэдгийг мэдрэх, ойлгохыг хэлнэ. Түүний нэг төрөл нь нийгмийн гачигдал юм. Энэ нь тухайн нийгэмд хувь хүн, бүлгийн аливаа нэгэн ур чадвар, чадамжийг ялгаатай үнэлэхтэй холбоотой юм. Тухайлбал, нийгмийн урамшуулал болох нэр хүнд, эрх мэдэл, нийгмийн өндөр байр суурь болон түүний үр дагавар болох нийгмийн амьдралд оролцох боломжуудыг хэлнэ. Ялгаатай үнэлэх, дүгнэлт хийх үндэслэл нь янз бүр байж болно. Жишээлбэл, орчин үеийн нийгэмд залуу хүмүүсийг ахмад настнуудаас, эрэгтэй ажилтныг эмэгтэй ажилтнаас, авьяастай хүмүүсийг энгийн хүмүүсээс илүү үнэлдэг. (Ефлова, 2011).

*Нөлөөлөх хүчин зүйл* - Амьжиргаатай холбоотой, түүнд нөлөөлж болох хүчин зүйлсийг хамруулан ойлгоно. Тухайлбал гэр бүлийн болон гэрлэлтийн байдал, нийгмийн харилцаа, сүлжээний өргөн байдал, орлогын эх үүсвэр, орлого зарлагын харьцаа, зээл ба зээлийн зарцуулалт гэх мэт.

Ахмад настны эрхийг хамгаалах ажилд гол анхаарлаа төвлөрүүлэх, улмаар ахмад настнууд өөрийн хүсэл сонирхлын дагуу бие даан амьдарч чадахгүй, хүнс тэжээл, орон байрны хангамж муу, эрүүл мэндийн үйлчилгээ хангалттай түвшинд авахгүй, мэдлэг чадвартаа тохирсон хөдөлмөр эрхлэхгүй, залуу, ахмад үеийн холбоо тасарч тэдэнд өөрсдийн мэдлэг ур чадвар туршлагаа өвлүүлж үлдээж чадахгүй байгаа зэргээр эрх нь ноцтой зөрчигдөж буйд бид дүгнэлт хийх цаг нэгэнт бий болжээ. Тэдгээрийг цаг алдалгүй арилгах арга хэмжээг шуурхай авахуулах, тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээг боловсронгуй болгохын зэрэгцээ ахмад настны орлогыг хэрхэн нэмэгдүүлэх болон урт хугацааны асаргаа сувилгааны төрөл үйлчилгээ, хүртээмжийг хэрхэн шинэчлэх асуудалд онцлон анхаарч ажиллах шаардлага бидний өмнө тулгараад байна.

2017 оны байдлаар Монгол Улсын нийт хүн ам 3.2 сая хүн болж, 2000-2017 онд 25.3 хувиар, жилд дунджаар 5.6 хувиар нэмэгдсэн байна. Харин ахмад настан 313.3 мянган хүн болж 45.6 хувиар, жилд дунджаар 4.4 хувиар нэмэгдсэн бөгөөд нийт хүн амын 10.4 хувийг эзэлж байна. Түүнчлэн, 2017 онд нийт

ахмад настны 140.6 мянга буюу 42.4 хувь нь эрэгтэйчүүд, 190.7 мянга буюу 57.6 хувь нь эмэгтэйчүүд тус тус эзэлж байна.

Өнөөдөр ахмад настны амьжиргааны индексийг аж байдал, эрүүл мэнд, чадамж, орчин нөхцөл гэсэн 4 бүлэг үзүүлэлтээр тооцож буй бөгөөд 2015 онд уг индексээр дэлхийн 96 орноос Швейцарь улс 90.1 индексийн үзүүлэлтээр хамгийн эхэнд орсон бол, Монгол Улс 37.4 индексийн үзүүлэлтээр 72 дугаар байрт оржээ. Үүнээс улбаатайгаар, индекс тооцсон үзүүлэлт бүр хоорондоо харилцан адилгүй байгаа юм. Тухайлбал, ахмад настны аж байдлын индексийн үзүүлэлт 75.8, пунктээр дэлхийн 96 орноос 31-д орчээ. Энэ нь ахмадууд 100 хувь тэтгэвэр авдаг, ахмад настны ядуурлын түвшин 7.7 хувь, аж байдлын харьцангуй түвшин 96.6 хувь, нэг хүнд ногдох үндэсний орлого 7463 ам долларт хүрсэн байгаагаас үзвэл ахмад настны аж байдлыг өнөөгийн түвшнээс дээшлүүлэх шаардлага буйг харуулж байна.

Ахмадын байгууллагын дотоод мэдээ, судалгааны дүнгээс үзэхэд өнөөдөр манай улсад 277.0 мянган ахмад настан байгаагийн дотор 70 хүртэл настай 183.4 мянга, 71-80 настай 99.4 мянга, 81-90 настай 17.1 мянга, 91 ба түүнээс дээш настан 2.3 мянга, 100 ба түүнээс дээш настай 121 ахмад настан байна. Нийт ахмадуудын 16.7 хувь буюу 28.2 мянган ахмад настан амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхөд амьдарч, 3963 ахмад настан ганц бие, харж хандах ах дүүгүй, 7815 ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй хэвтэрт, 18.4 мянган ахмад настан бусдын байнгын асрамжинд байгаа аж. Түүнчлэн, тэтгэвэрт гарсан ахмад настнуудын 67.5 хувь нь буюу 180 гаруй мянган ахмад настан ямар нэгэн ажил хөдөлмөр хийх хүсэлтэй, өндөр мэргэжлийн дадлага туршлага бүхий зөвлөх мэргэжилтэн 768 ахмад настан байгаа судалгаа байдаг ч өнөөдөр 38.5 мянган ахмад настан хөдөлмөр эрхэлж байгаагийн 9 мянга орчим нь байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа нь дэндүү чамлалттай, тэдний хүч хөдөлмөрийг нийгэмд ашиглаж чадахгүй байгаа дүр зураг харагдаж байна. Харин хөдөлмөр эрхэлж байгаа ахмад настныг салбараар нь авч үзвэл үйлчилгээний салбарт 3.7 мянга, барилга, тээвэр, үйлдвэрлэлд 1.2 мянга, мал аж ахуйд 20.7 мянга, газар тариаланд 4.9 мянган ахмад настан тус тус ажиллаж байна.

Улсын хэмжээнд 2017 оны байдлаар нийт 282.6 мянган хүн сард дунджаар 314.2 мянган төгрөгийн өндөр насны тэтгэвэр авч байна. Нийт тэтгэвэр авагчдын 262.0 (92.7%) мянга нь 551.0 мянган төгрөг хүртэлх тэтгэвэр авч байгаа бөгөөд тэдэнд нийт олгосон тэтгэврийн 943.6 (88.6%) тэрбум төгрөг ногдож байна. Хэдийгээр нийт олгосон өндөр насны тэтгэврийн хэмжээ 2005 оноос хойш 8.2 дахин нэмэгдсэн ч хэрэглээний үнийн өсөлттэй харьцуулахад ихээхэн бага байгаа бөгөөд ахмад настны тэтгэвэр, тэтгэмж нь тэдний амьжиргаанд хүрэлцэхгүй хэвээр байна (ҮСХ, 2018).

Орчин үеийн нийгэмд ахмад настны нийгмийн байдал эртний уламжлалт соёлуудтай харьцуулахад тааруу байдаг. Уламжлалт нийгэмд өндөр нас нь нэр хүнд, эрх мэдэл, эд баялагт тооцогдож, ахмадууд нь нийтээрээ хүндэтгэл хүлээж, гэр бүлийн дотор тэргүүлэх байр суурь эзэлдэг бол орчин үеийн нийгэмд үүнтэй адилтгах зүйл үлдсэнгүй (Гидденс А, 2006). Ахмад настны асуудлуудыг социаль харилцааны талаас нь авч үзвэл ахимаг нас нь голдуу гарз хохирлын хугацаа байдаг. Ахимаг насны эрэгтэйчүүд, тэр дундаа хот суурин газар амьдрагсдын хувьд тэдний үйл ажиллагааг маш их

хязгаарлана гэсэн айдас давамгайлдаг бол эмэгтэйчүүдийнх илүү төвөгтэй байдаг талаар Антони Гидденс онцлон тэмдэглэсэн байна (Гидденс А, 2006).

Философийн хүрээлэнгээс «Тэтгэврийн насныхан», 2015-2016 онд хэрэгжүүлсэн «Орос болон Монголын өөрчлөгдөж буй нийгмийн интеграци, задралын үйл явц» сэдэвт хамтарсан төслийн хүрээнд хийж, ахмадуудын нийгмийн харилцаа, оролцоо, сэтгэл зүйн төлөв байдал, нийгмийн капитал, нийгмийн сүлжээний асуудлыг авч үзсэн. Мөн ахмад настнуудын асуудлаар статистик болон социологийн судалгааны хэд хэдэн ажлууд хийгджээ. Тухайлбал, судлаач Т.Баярцэцэг, Г.Намуунцэцэг нарын *«Ахмад настныг нийгмийн энтерпрайс үйл ажиллагаагаар идэвхжүүлэх боломжууд»* сэдэвт судалгааны ажил нь түүврийн хэмжээ харьцангуй бага буюу Улаанбаатар хотод хийснээрээ хүрээ нь хумигдмал байна. Судалгааны насны ангиллыг авч үзвэл, ахмадууд гэдэгт 55-аас дээш насныхнаар төлөөлүүлсэн нь судалгааны ажлын хүрээнд харьцангуй хязгаарлагдмал байдлыг үүсгээд зогсохгүй Монголчуудын онцлог, олон улсын жишиг хандлагыг нарийвчлан судлаагүй мэт санагдана. Түүнчлэн М.Ундармаа, М.Сугармаа нарын хийсэн *«Ахмад настны асран хамгаалагчийн стресс»* сэдэвт судалгааны ажилд асран хамгаалагчдад тулгамдаж буй асуудал, стресс, түүний хэлбэр, гүнзгийрэлт, шалтгаан, шийдвэрлэх аргыг тодруулсан. Мөн «Ахмад настны нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа» стастистик судалгаа 2018 онд хийгдэж, улмаар эл судалгааны үр дүн нь ахмад настныг судлахад гол суурь судалгаа болж байгаагаараа ач холбогдолтой юм.

Бид энэхүү өгүүлэлдээ «Нийгмийн энтерпрайс гэдэгт нийгмийг хөгжүүлэх хүсэл зориг, ашгийн төлөөх бизнесийн үйл ажиллагаа хоёрыг сайтар уялдуулсан, инновацид тулгуурласан, нийгмийн чиг баримжаа бүхий бизнесийн үйл ажиллагаа юм» хэмээн тодорхойлж нийгэмд тулгараад буй асуудлуудыг шийдвэрлэхэд зөвхөн засгийн газрын гарыг хараад суух бус харин тухайн орон нутгийн нөөц бололцоог олж илрүүлэн ашиглах, орон нутгийн иргэдийг өөрсдийг нь үйл ажиллагаанд өргөнөөр татан оролцуулах чухал гэсэн санааг дэвшүүлж буй. Энэ нь нэг талаараа, судалгааны арга зүйн хувьд ахмадуудыг нийгмийн нөөц гэж үзэж буйгаараа онцлог төдийгүй дэвшүүлсэн буй судалгааны зорилго, дэвшүүлж буй санаа нь шинэлэг бөгөөд судалгааны үр дүнд гарсан зарим үр дүнг харьцуулан судлах боломжийг бүрдүүлж буйгаараа чухал.

### *(ii) Ахмад настны нийгмийн хамгааллын асуудалд хийсэн шинжилгээ, үр дүн*

Ахмад настны нийгмийн хамгааллын асуудлууд, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, хүний эрхийн чиглэлийн тодорхой асуудлаар статистик болон социологийн судалгаануудыг олон улсын байгууллагууд, хүний эрхийн болон төрийн байгууллагууд үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагын улмаас тухайлсан судалгаанууд хийсэн байдаг. Гэхдээ манай орны хувьд амьжиргааг социологийн онол, арга зүйн үүднээс цогцоор нь судалсан судалгаа ховор юм.

Монгол Улс 1990 оны эхээр эдийн засгийн харилцааны системд шилжиж эхэлснээр нийгмийн тэгш бус байдал харьцангуй тэгш байснаас нэлээн өөрчлөгдсөн (ФСЭЗХ, 2001). Өөрөөр хэлбэл сүүлийн 30 жилийн дотор Монгол Улсад баян хоосны ялгаа нь хэт их нэмэгдэж ахмадуудын амьдралын нөхцөл, орлогын байдал нь дортсон гэж хэлж болно. Үүнээс улбаалан нийгмийн тэгш бус байдал үлэмж

нэмэгдэхийн хэрээр амьжиргааны түвшинг авч үздэг нийгмийн тэгш бус байдал манай өнөөгийн нийгэмд бий болох болсноор түүний илэрхийлэл болох давхраажил бидний өмнө тулгарч буй мөнхийн асуудал болж ирснийг бид мартах учиргүй. Угтаа хүмүүс хоорондоо олон шинжээр ялгардаг авч хязгаарлагдмал нөөц боломжийн хүртээмжийн дагуу үүссэн тэгш бус байдлууд л ач холбогдолтой болох явдал байдаг ч гэлээ нөөцийн хүртээмж нь ялгаатай учраас босоо чиглэлийн нийгмийн давхраажилтыг бий болгодог байна.

Мөн нийгмийн давхраажилт, бүтэц, амьдралын хэв маягийг судлахад дараах судлаачдыг дурдах нь зүйтэй гэж үзнэм. Тухайлбал, У.Уорнерийн хувьд, нийгмийн статусыг тодорхойлдог субьектив үнэлгээний шинж тэмдгийн гүйцэтгэж буй үүргийг судалдаг. Тэрбээр нийгэм, соёлын зан үйлийн шинж тэмдгийн судалгаанд маш их ач холбогдол өгч, улмара чөлөөт цагаа өнгөрүүлэх, хэрэглээний загварыг чухалчилсан. Харин Д.Голторп судлаачдын багтай хамт “цагаан” болон “хөх” захтнуудын янз бүрийн амьдралын хэв маяг, үнэт зүйлсийг судалахдаа нийгмийн сүлжээний хязгаарлагдмал байдал, материаллаг сонирхлын тархалт, хөдөлмөр эрхлэлтийн сэдэл, нийгмийн доод түвшний болох “хөх” захтнуудын амьдралын сонирхлын хүрээ нь бага буйг тодорхойлон гаргах оролдлогыг хийсэн байдаг. Тэгвэл, П.Таузенд доод ангийн нийгмийн тэгш бус байдлыг авч үзэхдээ «ядуурлын соёл» хэрхэн бий болдогийг судалсан байх бөгөөд тэрбээр ядуурлын соёлтой нийгмийн доод ангийн бүлэг хүмүүст нийгэм дотроо жирийн харилцаа тогтоох, үйл ажиллагаа эрхлэх боломжууд нь хаалттай байдаг (Townsend P, 1993) талаар дурдсан нь бий. Тэдний дэвшүүлсэн санааг тоймловол: «Нийгмийн статус нь дараах шалгуур үзүүлэлтүүдээр тодорхойлогдох бөгөөд давхарга нь хоорондоо нэг хүнд ногдох сарын орлого, цалин хөлс, иргэн тойронд байгаа хүмүүсийн материаллаг байдал, амьжиргааны түвшний ялгаа, материаллаг байдал, амьдралын хэв маяг болон хэрэглээний бүтэц, нийгмийн адилсал, нийгмийн харилцаа болон улс төрд хандах хандлагын онцлог, санаа зовж буй асуудлууд» гэсэн үзүүлэлтээр ялгардаг байна.

Тэгэхлээр, бидний судалж буй сэдвийн хүрээнд юуны өмнө үндсэн ойлголтуудыг тодорхойлох хэрэгтэй болж буй. Жишээлбэл, *«амьжиргаа»* гэдэг нь өрх, иргэн бүрт хамаатай, тэдний өдөр тутмын амьдралтай холбоотой идэж уух, өмсөх зүүх, амьдрах орон гэрээс эхлэх нь өргөн хүрээний ойлголт юм. Аливаа улсын өрх, иргэдийн амьжиргааны түвшин ямар байх нь тухайн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил ямар байгаагаас хамаардаг. Амьжиргаа хэмээх ойлголтыг энгийнээр авч үзвэл «Тухайн хүний амьдрахад шаардлагатай анхдагч хэрэгцээ болох хоол хүнс, ундны ус, орон гэр, хувцас зэргээр хангагдсан байх явдал» (Жасрай П, 1997) гэж ойлгож болох юм. Өргөн хүрээнд тодорхойлбол, үндсэн болон бусад хэрэгцээгээ тогтвортой хангахын тулд дангаараа болон хамтран ажил хөдөлмөр эрхлэх, орлого олох үйл ажиллагаа, тэдгээрт ашиглагдах нөөц, чадварыг хамруулсан ойлголтыг амьжиргаа хэмээн ойлгож болно. Өөрөөр хэлбэл амьжиргаа нь амьдрах, аж төрөх гэсэн өргөн агуулгатай (Намжил Т, 2004), хэрэгцээгээ хангаж буй арга зам, аж байдлын төлөв байдлыг багтаасан нийгэм, эдийн засгийн нийлмэл ойлголт юм. Нөгөө талаар, *«Монгол Улс дахь ядуурлын дүр төрх: Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2007-2008 оны дүн»* судалгаанд амьжиргааг аж байдлын дүр төрх гэсэн нэр томьёогоор тодорхойлж, хэрэглээний хэв шинж, орлогын ядуурал, орон сууц, мал, газар, санхүүгийн

хөрөнгө, сууц зэрэг гол төлөв эдийн засгийн хэмжүүрээр тодорхойлон авч үзсэн байна. Мөн профессор Х.Гүндсамбуу нар амьжиргааны түвшний талаарх судалгааны онол, суурь үзэл баримтлал, үндсэн ойлголт, үзүүлэлтүүд болон Монгол Улсад амьжиргааны түвшинг тодорхойлж ирсэн аргачлалыг Олон улсын туршлагатай харьцуулан авч үзсэн байдаг.

Тэгвэл, гадны эрдэмтэн судлаачдын хувьд амьжиргааны талаарх шинжлэх ухааны ойлголт, үзэл баримтлал хөгжихөд үнэтэй хувь нэмэр оруулсан Р.Чамберс, Г.Конвэй, Ф.Эллис, Д.Карней, К.Ашли нарын нэрийг дурдаж болно. 1992 онд Робэрт Чамбэрс, Гордон Конвэй нар тогтвортой амьжиргааны талаар XXI зууны орчин үеийн үзэл баримтлалыг гаргасан. Энэ нь өрхийн түвшинд нэлээд түгээмэл тохирсон тодорхойлолт болсон: тэднийхээр «Амьжиргаа гэдэгт боломж чадварууд, эд хөрөнгө (бараа материал, нөөц), хүсэл эрмэлзлэл, түүнд хүрэх боломжууд, амьдрахын төлөө хийж буй бүхий л үйл ажиллагааг хамруулан ойлгоно» гэсэн тодорхойлолт гаргасан байна.

Судлаач Т.Дижифа нь хот суурин газрын хүн амын амьжиргааны хамгийн чухал стратеги бол ажил эрхлэлт гээд амьжиргаа нь ядуурал ба хүнсний аюулгүй байдал гэсэн үндсэн хоёр хэмжүүрээр тодорхойлогдоно гэж үзжээ. Харин ахмад настны нийгмийн асуудлын талаар АНУ-ын судлаач Карол Пардуе-Спеары тус улсын ахмадуудад тулгарч байгаа гол асуудалд 1. Биеийн болон сэтгэл санааны эрүүл мэнд; 2. Эрүүл мэндээ хамгаалах ба асран хамгаалуулах зардал; 3. Санхүүгийн аюулгүй байдал; 4. Үхэл хагацал тохиолдох; 5. Нийгмээс тусгаарлагдах; 6. Ганцаардал; 7. Хүчирхийлэлд өртөх зэрэг асуудлыг хамааруулж үзсэн байна. (Б.Батхишиг, 2019) тодорхойлон өөрийн туурвисан бүтээлүүдэд энэ талаарх санааг онцолсон байна. Түүчнлэн,НУ-д хийсэн өөр нэг судалгаанд ахмад настны социаль асуудлуудад 1. Гэр бүлийн асуудал; 2. Амьдралын нөхцөл /орон сууц/; 3. Мөнгө, санхүү; 4. Асрах, харах хүнтэй эсэх; 5. Өдөр тутмын үйл ажиллагаа; 6. Гэр бүлийн болон бусад хүчирхийлэлд өртдөг эсэх зэргийг оруулсан байна.

ОХУ-ын судлаач О.В.Николаева 1. Эрүүл мэнд; 2. Материаллаг хангамж; 3. Хүмүүстэй харилцах асуудал; 4. Бусдаас хамааралгүй амьдрах; 5. Бусад хүмүүст хэрэгтэй, тустай байх; 6. Бусдын хүндэтгэл хүлээх; 7. Чөлөөт цагаа ашигтай, сонирхолтой өнгөрүүлэх боломж; 8. Тайван, амгалан байх; 9. Нийгэмд хүлээсэн үүргээ биелүүлсэн гэх мэдрэмж, бахархал зэргийг ахмадуудын гол социаль асуудлууд гэж үзжээ. (Б.Батхишиг,2019)

Амьдралын түвшинг шууд тоон хэмжилтэнд өртөх эдийн болон оюуны хэрэгцээг хангах хэр хэмжээг заадаг эдийн засгийн категори гэж үздэг явдал өргөн дэлгэрсэн байв. Барууны орнуудад нэг хүний болон хүн амын орлогоор голдуу хэмждэг амьдралын жишиг /стандарт/ гэдэг ухагдахууныг өргөн хэрэглэдэг байна. Тухайн орны амьдралын жишиг энэ орны иргэд амьдралын ямар хэрэгцээт зүйлс эзэмшиж байна, тэдгээрийг яаж хуваарилж иргэдийн янз бүрийн ай бүлэг ямар аргаар авч байна, энэ бүхэн нь тэдний аж төрөлд хэрхэн нөлөөлж байгааг үзүүлдэг. Энэ утгаараа, амьдралын жишиг дэх бүх юм нийгмийн байгууллын шинж чанараас хамаарахгүй. Байгалийн нөхцөл, түүхэн уламжлал, бусал орны дундах байршил мэт өөр төрлийн нөхцөл байдлаас олон зүйл хамаарч байдаг. Амьдралын жишгийг мөнгөн орлогын хэмжээгээр хэмжиж энэ шалгуураар улс орнуудыг харьцуулах нь тэр болгон объектив үнэн дүгнэлт өгдөггүй.

Манай орон зах зээлийн харилцаанд шилжих явцад социализмын үед хүрсэн нийгмийн харьцангүй тэгш байдал охор хугацаанд алдагдаж өдгөө баян ядуугийн хоёр туйл ирсэн учраас төр засаг ард түмний аж амьдралыг дээшлүүлэх тухай социализмын үеийн суртал, бодлогын оронд ажилгүйдэл, ядуурал гэж юу вэ? Ядуурлын түвшинг (босгыг) яаж тогтоох вэ ядуурлыг яаж бууруулах вэ гэдэг практик зорилтыг шийдвэрлэхэд илүү анхаарахаас өөр аргагүй болсон билээ. Ядуурлын босго буюу амьжиргааны доод түвшинг улс орон болгонд адилгүй тогтоодог боловч түүгнийг тогтоодог нийтлэг аргачлал байдаг (ХЭХТ, 2006). Ядуурлыг босго гэдэг бол хувь этгээд юмуу гэр бүл хүнс, хувцас сууцтай байхад хүрэлцэх доод орлого гэж албан ёсоор тогтоосон мөнгөний хэмжээ юм. Түүнээс доош орлоготой хүмүүсийг ядуус хэмээн үзэж засгийн газраас тусалж дэмждэг дэлхийн нийтийн жишиг бий (СЯ, НҮБХХ, 2005).

Хэрэв, ядуурлыг үнэмлэхүй ба харьцангүй гэж ялгаж үзвэл, үнэмлэхүй ядуурал гэдэг нь амьдралын наад захын шаардлагуудыг хангах чадваргүй байдал юм. Харин харьцангүй ядуурал бол амьдралын боломжийн жишиг гэж тухайн нийгмийн үзэж байгаа зүйлийг хангах чадваргүй байдлыг тус тус хэлнэ. УИХ-ын 1998 оны нэгдүгээр сарын 8-ны өдөр баталсан Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хуульд заасанаар эл түвшинг Үндэсний Статистикийн газар нэгээс доошгүй удаа шинэчлэн тогтоох ёстой гэж заасан бөгөөд тус газраас 1991 оноос хойш өрхийн аж ахуйн судалгааны тоо баримтыг ашиглан туйлын ядуурлын үзүүлэлтийг хүнсний сагсны доод хэмжээгээр тогтоон гаргаж буй билээ. Эл тооцооллоор, нэг хүний нэг өдрийн хоолны хамгийн бага илчлэг болох 2150 калорийг хангахад шаардагдах мөнгийг үнэмлэхүй ядуурал гэж үзнэ хэмээн Дэлхийн банк тодорхойлон үзсэн байдаг. 1990-ээд оны эхнээс манай засгийн газрын амьжиргааны доод түвшинг мөнгөн нэгжээр тооцон илэрхийлэн зарлаж байгаа бөгөөд 1999 онд амьжиргааны доод түвшинг бүс нутгаар хамааруулан тооцоход эл түвшин 14100-17600 төгрөгийн ялгавартайгаар тогтоогдсон байна. Өөрөөр хэлбэл, амьжиргааны доод түвшинг тогтоохдоо хүнд зайлшгүй шаардлагатай хүнсний хэрэгцээт бүтээгдэхүүний сагсан дахь бараа бүтээгдэхүүнийг үндэслэн (хоногт нэг хүний хэрэглэх илчлэг 2100 килокалориос доошгүй) орон байр, цахилгаан, дулаан, хувцас зэрэг наад захын суурь хэрэглээг нэмж тооцдог байна.

Оросын ШУА-ийн Социологийн хүрээлэнгийн тэргүүлэх ажилтан, социологийн шинжлэх ухааны доктор Н.Е.Тихонова Оросын нийгмийн давхраажилтыг шинэ хандлагаар судлахдаа амьдралын нөөц боломж, эрсдэл зэрэг багц үзүүлэлтийг хэрэглэсэн байдаг. Тэгвэл, Философийн хүрээлэнгийн Социологи, нийгмийн сэтгэл зүйн салбарын судлаачид тухайн судалгааны арга зүйг гүнзгийрүүлэн судалж, өөрийн орны нөхцөлд зарим аргачлалыг тохируулан хэрэглэж болох юм гэж үзэж, улмаара энэ арга зүйгээр нийгмээс тусгайлагдсан бүлэгт багтах эрсдэл бүхий хэсэг бүлгийг тодорхойлоход хэрэглэхээр шийдвэрлэсэн. Эл судалгааны ажил нь тус судалгааны арга зүйгээр нийгмээс тусгайлагдах эрсдэл бүхий бүлэгт хамаардаг ахмад настны амьжиргаа, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг шинжилж тэдний нөөц боломж ба эрсдэлийг тодорхойлоход чиглэгдэж байна.

Эрдэмтэн Н.Е.Тихоновагийн амьдралын нөөц боломж, эрсдэлийг тодорхойлох эл арга зүй, аргачлал нь амьдралын түвшнийг гачигдлын талаарх субьектив үнэлгээ, эд хөрөнгийн хангамж, үл хөдлөх хөрөнгө, сууцын чанар, хадгаламжийн хэмжээ, үнэтэй үйлчилгээг хэрэглэж буй байдал, чөлөөт

цагийн боломж зэрэг 8 багц үзүүлэлтээр, нөөц хангамжийн интеграл үзүүлэлтийг эдийн засгийн, мэргэшлийн, нийгмийн, эрх мэдлийн, соёлын бие хүний, нэр хүндийн, биологийн зэрэг 8 багц үзүүлэлтээр тус тус тооцож, улмаар капитал бүхий нөөц боломж эзэмшигчийг тодорхойлсон байдаг (Тихонова Н.Е, 2014). Өөрөөр хэлбэл, амьдралын боломж болон эрсдэлт нөхцөл байдлын дөрвөн багц (Эдийн засгийн нөхцөл, ажил дээрх нөхцөл, хүмүүн капитал, хэрэглээ ба чөлөөт цаг) эерэг сөрөг нийтдээ 24 субьектив үзүүлэлтээр ахмад настнуудын амьжиргааг нийгэм, мэргэшил, эдийн засгийн байдлаар нь онцлон авч үзснээрээ онцлог.

Харин, П.Бурдьегийн боловсруулсан нөөцийн (капиталын) онол эл арга зүйн суурь болж байгаагийн дээр капиталын төрөл нь социаль систем дэх байр суурь болон «габитусын» үүрэг ролийг тодорхойлдог. Тухайлбал, "Габитус" нь Оросын социологийн уламжлалт ойлголтын хүрээн дэх сэтгэлгээ эсвэл сэтгэхүйн утгатай ижил төстэй юм. П.Бурдье «эдийн засгийн капиталын янз бүрийн хэлбэр, соёлын болон бэлэг тэмдгийн капитал» гэж ангилсан (Бурдье П, 1993) байдаг. Түүнийхэрэ бол, нийгмийн орон зайнд субьектын байдлыг авч үзэхэд дээрх гурван капиталын дунд нийгмийн капитал бий болдог аж (Бурдье П, 1993). Түүнчлэн түүний үзсэнчлэн «субьектууд нийгмийн орон зайд нэгдүгээрт капиталын нийт хэмжээ, хоёрдугаарт, хэмжээн дэх капиталын харьцааны дагуу байрладаг» (Бурдье П, 1993) ажээ.

Бид энэхүү судалгааны ажлын хүрээндээ, тус арга зүйг баримтлан ахмад настны амьжиргаа, түүнд нөлөөлөх нөөц боломж ба эрсдэлийн үнэлгээг *эдийн засаг, мэргэшил, нийгмийн* гэсэн гурван нөөцийн хүрээнд үзүүлэлт тус бүрийг гурван *эерэг*, гурван *сөрөг* индикатороор тодорхойлж, нийтдээ эерэг талыг харуулах 9, сөрөг талыг харуулах 9 нийт 18 шкалын тусламжтай ахмад настны амьдралын боломж, эрсдэлийг хэмжиж, тэдний амьжиргаанд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох боломжтой хэмээн үзсэн билээ.

*Хүснэгт 4. Ахмадын амьдралын нөөц боломж ба эрсдэлийг үнэлэх индикатор (эдийн засаг, мэргэшил, нийгмийн нөөц)*

| | | **Эерэг үнэлгээ** | **Сөрөг үнэлгээ** |
|---|---|---|---|
| **Эдийн засгийн нөөц** | Орон сууцны нөхцөл дэх сэтгэл ханамж | *Амьдарч буй орон сууцны нөхцөлдөө сэтгэл хангалуун* | *Амьдарч буй орон сууцны нөхцөлдөө сэтгэл хангалуун биш* |
| | Хөрөнгийн эзэмшил | *Үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөтэй* | *Үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө өмчилдөггүй* |
| | Амьжиргааны түвшний сэтгэл ханамж | *Амьжиргааны түвшингээ дээд гэж үнэлсэн* | *Амьжиргааны түвшингээс доод гэж үнэлсэн* |
| **Мэргэшлийн нөөц** | Боловсролын түвшин | *Дээд боловсролтой* | *Боловсролгүй болон бага боловсролтой* |
| | Боловсролоо дээшлүүлэх төлөвлөгөө | *Боловсрол, мэдлэгээ цаашдаа ч хөгжүүлнэ* | *Боловсрол, мэдлэгтээ анхаардаггүй* |
| | Тэтгэвэрт гарсны дараах ажил эрхлэлт | *Тэтгэвэрт гарснаас хойш ажил эрхэлсэн* | *Тэтгэвэрт гарснаас хойш ажил эрхлээгүй* |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийгмийн нөөц** | Харилцааны өөрчлөлт | *Ахмадуудын бусадтай харилцах харилцаа ихэсдэг* | *Ахмадуудын бусадтай харилцах харилцаа багасдаг* |
| | Чөлөөт цаг дахь сэтгэл ханамж | *Чөлөөт цагаа өнгөрүүлэх хэв маягтаа сэтгэл хангалуун байдаг* | *Чөлөөт цагаа өнгөрүүлэх хэв маягтаа сэтгэл хангалуун бус байдаг* |
| | Нийгмийн харилцааны хүрээ | *Харилцааны хүрээ өргөн буюу 7 хоногт уулздаг хүний тоо олон >30* | *Харилцааны хүрээ бага буюу 7 хоногт уулздаг хүний тоо цөөн <2* |

Эдийн засгийн нөөцөд сууцны нөхцөл дэх сэтгэл ханамж, хөрөнгө эзэмшдэг эсэх, амьжиргааны түвшний үнэлгээ гэсэн гурван хүчин зүйлийг, мэргэшлийн нөөцөд боловсролын түвшин, тэтгэвэрт гарснаас хойш ажил эрхэлсэн, эрхлэх боломжтой эсэх, мэдлэг боловсролоо дээшлүүлэх талаарх бодол гэсэн гурван хүчин зүйлийг, нийгмийн нөөцөд ахмадуудын харилцаанд гардаг өөрчлөлт, чөлөөт цаг дахь сэтгэл ханамж, нийгмийн харилцааны хүрээ гэсэн гурван хүчин зүйлийг тодорхойлох түвшний хүчин зүйлээр сонгосон. Чингэхлээр, эл гэр бүлд хамгийн хүндэтгэлтэйд эхнэр, нөхөр буюу өвөө, эмээ, элэнц хуланц тооцогдох бөгөөд 55-аас дээш насныхан байна. Өндөр настны гэр бүлийн хосууд тэтгэвэрт гарсан байдаг болоод нийгмийн идэвхтэй үйл ажиллагаанаас харьцангуй холддог. Ахмад настнууд хуримтлуулсан баялаг туршлага, арвин мэдлэг ухаанаараа үр хүүхэд, ач зээдээ дамжуулж байдаг. Өндөр настны гэр бүлд, залуу гэр бүлд тохиолддог бэрхшээлүүд тэр бүр байдаггүй боловч бэлэвсрэх магадлал өндөрсдөг байна.

*Зураг 1. Ахмад настны эдийн засаг, нийгэм, мэргэшлийн нөөцийн эерэг, сөрөг индекс, амьжиргааны түвшнээр (хувиар)*




Тухайлбал, амьжиргааны доод түвшинд амьдарч буй ахмадуудын хувьд эдийн засгийн нөөцөө 100 хувь сөргөөр үнэлсэн нь амьжиргааны нөгөө хоёр бүлгээс даруй 10-12 дахин өндөр байна. Мөн мэргэшлийн болон нийгмийн нөөцөө үнэлсэн байдлыг нь харьцуулвал, мэргэшлийн нөөцийн үнэлгээ нь 1.8-4 дахин, нийгмийн нөөцийн үнэлгээ 2.5-4 дахин бага байна. Ахмад настны амьжиргааны түвшин ба амьдралын нөөц, эрсдэлийн үзүүлэлтийн хамаарлыг авч үзэхэд амьжиргаа ба эдийн засгийн нөөц ($r = 0.444$), амьжиргаа ба нийгмийн нөөц ($r = 0.376$) илүү хамааралтай байгаа бол амьжиргаа ба мэргэшлийн нөөцийн ($r = 0.231$) хамаарал харьцангуй сул байна. Түүнчлэн амьжиргааны түвшин багасах

тутам нөөцийн түвшин буурч, амьжиргааны түвшин өндөр байх тутам нөөц нь өссөн харилцан шууд хамааралтай болж байна.

Ахмадуудыг амьжиргааны түвшний үнэлгээг нь үндэслэн гурван бүлэгт ангилан үзвэл, ахмад настнууд өөрсдийн амьжиргааны түвшинг дунд ба түүнээс дээш гэж 48 хувь (0.8 хувь нь дээд, 47.2 хувь нь дундаж) үнэлсэн бол 45 хувь нь дундаас доогуур, 7 хувь нь доод түвшинд амьдарч буйг харуулсан. Үүнийг бид дараах байдлаар ангилан тодорхойлсон. Тухайлбал, (i) *оролцоо ба амьжиргааны түвшин – бид үүнийг* амьжиргааны түвшингээр хамааруулан үзвэл, ахмадуудын улс төрийн оролцоонд төдийлөн ялгаа ажиглагдахгүй байна. Харин сайн дурын үйл ажиллагаан дахь ахмадуудын оролцоонд амьжиргааны түвшин мэдэгдэхүйц нөлөөтэйн дээр амьжиргааны доод түвшинд амьдарч буй ахмадууд, дунд ба түүнээс дээш түвшинд амьдарч буй ахмадуудын сайн дурын үйл ажиллагаан дахь оролцооны ялгаа 5-11.1 засварт багтаан үзсэн. Өөрөөр хэлбэл амьжиргааны түвшин сайжрах тутам сайн дурын үйл ажиллагаан дахь ахмадуудын оролцооны түвшин нэмэгдэж буй нь үүгээр ажиглагдаж байна. (ii) *Шийдвэр гаргах түвшин дэх ахмадуудын оролцоо ба тэдний амьжиргааны түвшин* харьцуулвал, харьяалагддаг бүлэг, хамт олны дунд шийдвэр гаргах түвшин дэх оролцоо төдийлөн ялгаагүй сул (интервал утга нь -19.8 аас -36 завсарт) байгаа нь, гэр бүлийн хүрээнд шийдвэр гаргах түвшин ахмадуудын амьжиргаатай шууд хамааралтайг харуулна. (iii) *Ахмад настны нийгмийн харилцаа ба амьжиргааны түвшний* үзүүлэлтийн хувьд, ахмад настай хүмүүсийн харилцаанд ихэсдэг буюу эерэг өөрчлөлт гардаг гэж хариулагчдын хувь дунд ба түүнээс дээш түвшний амьжиргаатай ахмадуудын дунд эзлэх хувь нь амьжиргааны бусад бүлгээс 3.5-5.6 дахин олон байгаа нь харьцуулалтаар батлагдсан. Үүнээс үзвэл, ахмадуудын өмнө тулгамдаж буй бэрхшээлийг ерөнхийлөн бүлэглэж үзвэл тэтгэврийн хэмжээ, хүрэлцээ бага тул нэмэгдүүлэх шаардлагатай, эрүүл мэнд халамжийн үйлчилгээг сайжруулах, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах зэрэг шалтгаан тэргүүлж байна.

Түүнчлэн, Монгол Улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж, дундаж наслалт нэмэгдсэнээр байгаа нь нийт хүн амд ахмад настны эзлэх хувь хэмжээ тасралтгүй нэмэгдэх хандлагатайг харуулж байна. Үүнтэй улбаатайгаар, ахмад настны эрх, хамгааллын асуудлаар үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байгаа хэдий ч ахмад настны амьжиргаа, аж байдалд анхаарал хандуулах шаардлага тулгарсаар байна. Энэ нь ахмад настнуудын амьжиргааны төлөв, нөлөөлж буй зарим хүчин зүйлийг тодруулж, амьжиргааны нөөц, эрсдэлийг тодорхойлох үүднээс зорилтот бүлэгт чиглэсэн судалгааг гүйцэтгэх нийгмийн болон болон цаг үеийн чухал шаардлага бий болсныг харуулна. Тиймээс бид, эл судалгааг гүйцэтгэхдээ Оросын эрдэмтэн Н.Е.Тихоновагийн боловсруулсан амьжиргааны нөөц, эрсдэл тодорхойлох аргачлалыг судалгааны үзэл баримтлалын тулгуур болгон ашиглаж, үүнтэй уялдуулан амьжиргааны эдийн засаг, нийгэм, мэргэшлийн нөөцийн хүрээнд судалгаагаа чиглүүлэн гүйцэтгэсэн. Түүнчлэн, ШУА-ийн Философийн хүрээлэнгээс 2016 онд хийсэн «Тэтгэврийн насныхан» судалгааны өгөгдлийн баазыг тус байгууллагын албан ёсны зөвшөөрөлтэйгээр суурь өгөгдөл болгон ашиглаж, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан болно.

***Дүгнэлт***

Эцэст нь дүгнэхэд, ахмадуудыг амьжиргааны түвшний үнэлгээгээр нь гурван бүлэгт ангилахад дунд ба түүнээс дээш гэж 48 хувь (0.8 хувь нь дээд, 47.2 хувь нь дундаж) нь, 45 хувь нь дундаас доогуур, 7 хувь нь доод түвшинд амьдарч байна хэмээн үнэлсэн байна. Өөрөөр хэлбэл ахмад настны дийлэнх нь буюу 52 хувь нь өөрсдийн амьжиргааны түвшинг дундаас доогуур байна хэмээн үнэлсэн нь судалгаанд дэвшүүлсэн ахмад настны олонх нь амьжиргааны дундаас доогуур түвшинд амьдарч буйг харуулж байна.

Түүнчлэн ахмад настны амьдралын нөөц боломжийг судлан үзвэл, нийгмийн нөөц харьцангуй өндөр боломжтой байгаа хэдий ч, эдийн засаг мэргэшлийн нөөц хасах утгатай буюу эрсдэлтэй байна. Тухайлбал, эдийн засгийн нөөцийн нэгдсэн индексийн тооцооллоор судалгаанд хамрагдагсдын 27.7 хувь нь сөрөг үнэлгээ өгсөн бол 26.2 хувь нь эерэг үнэлгээ өгч, интервал үнэлгээ нь -1.5 байна. Харин мэргэшлийн нөөцийн нэгдсэн индексээр ахмадуудын 36.9 хувь нь сөрөг, 35.4 хувь нь эерэгээр үнэлж, түүний интервал үнэлгээ нь -1.5 байгаа бол дээрх хоёр багц үзүүлэлттэй харьцуулахад нийгмийн нөөцийн үнэлгээ хоёр дахин өндөр буюу интервал үнэлгээ нь +1.8 гарчээ.

Амьжиргааны дунд ба түүнээс дээш түвшинд амьдарч байгаа ахмадуудын хувьд нийгмийн нөөц өндөр, мэргэшлийн нөөц багатай байна. Дундаас доогуур амьжиргаатай ахмадуудын мэргэшлийн нөөц өндөр нийгмийн нөөц хомс байгаа бол амьжиргааны доод түвшинд байгаа ахмадуудын хувьд мэргэшлийн нөөц харьцангуй сайн, эдийн засгийн нөөцөөр хомсдож байв. Энэ нь орон сууцны нөхцөл, хөрөнгө эзэмшил болон амьжиргааны түвшингийн талаарх сэтгэл ханамж тааруу байгааг илэрхийлнэ.

Орлогын эх үүсвэрийн хувьд амьжиргааны доод түвшинд амьдарч буй ахмадууд тэтгэврээс өөр орлогогүй байгаа бөгөөд тэдний цөөн хувь нь эхнэр/нөхрийн орлого, үр хүүхдийн тусламж дэмжлэгийг авдаг байна. Ахмад настны амьжиргааны түвшинд голлон нөлөөлж буй орлогын нэг эх үүсвэр нь тэтгэврээ авахын хажуугаар давхар ажил эрхлэх боломж мөн. Үүгээр ахмадуудын амьжиргааны түвшин дээшлэх тутам зээл авсан болон авах төлөвлөгөөтэй хүмүүсийн тоо буурч, амьжиргааны түвшин доошлох тутам энэ тоо өсч байгаа урвуу хамаарал ажиглагдаж байна. Ахмадуудын амьжиргааны түвшний үнэлгээ болон санхүүгийн байдлаа тодорхойлсон үзүүлэлт нь корреляци (r =0.524) дундаж түвшний хамааралтай байна. Тухайлбал, амьжиргааны доод түвшинд амьдарч буй ахмадуудын хоёр хүн тутмын нэг нь амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байх агаад зөвхөн 11.5 хувь нь хоол, зарим хэрэгтэй зүйлсээ авах боломжтой гэж хариулжээ. Харин дундаас доогуур болон дунд, дундаас дээш түвшинд амьдарч буй ахмадуудын санхүүгийн чадавх дундаас дээгүүр, харьцангуй өндөр байгаа нь бидний судалгаагаар ажиглагдсан.

Мөн судалгаанд оролцогчдын одоогийн амьдрал дахь сэтгэл ханамж ба тэтгэвэрт гарсны дараах сэтгэл ханамжийн байдлыг интервал утгаар нь авч үзвэл одоогийн амьдрал дахь сэтгэл ханамж нь харьцангуй өндөр байгаа ч тэтгэвэрт гарсны дараах сэтгэл ханамжийн байдал нэлээд доогуур гарснаас үзвэл, ирээдүйгээ өөдрөгөөр ‘харах’ амьдралын сэтгэл ханамж төдийлөн хангалттай бус байгааг давхар харуулсан болно.

Энэ бүхнээс үзэхэд, амьжиргааны доод түвшинд амьдарч буй ахмадууд, дунд ба түүнээс дээш түвшинд амьдарч буй ахмадуудын сайн дурын үйл ажиллагаан дахь оролцооны ялгаа 5-11.1 засварт байгаа нь амьжиргааны түвшин сайжрах тутам сайн дурын үйл ажиллагаан дахь ахмадуудын оролцооны түвшин нэмэгдэх хандлага ажиглагдав. Түүнчлэн ахмадуудын гишүүчлэлийн түвшин харьцангуй сул боловч тэдний амьжиргааны түвшинг харьцуулбал доод болон дунд, дундаас дээш түвшин дэх харьцаа хоёр дахин зөрүүтэй байна. Үүнийг харилцааны хүрээгээр авч үзвэл, ахмад настны амьжиргааны түвшин өндөр байх тутам нийгмийн харилцааны хүрээ өргөн байж, амьжиргааны түвшин буурах тутам нийгмийн харилцааны хүрээ багасдаг ажээ. Үүнээс нийгмийн сүлжээ, хүрээлэл нь ахмадуудын амьжиргаанд дэмжлэг болдог нь харагдлаа. Мөн дунд ба түүнээс дээш түвшинд амьдарч буй хүмүүсийн чөлөөт цагаа өнгөрүүлэх сэтгэл ханамж дундаас доогуур болон доод түвшинд амьдарч буй бүлэгтэй харьцуулахад ойролцоогоор 25-45 пунктаар өндөр байна.

Ахмадуудын боловсролын түвшин болон амьжиргаа нь харилцан шууд хамааралтай буюу боловсролын түвшин ахих тусам амьжиргааны түвшин дээшилж, эсрэг тохиолдолд буурч байгаа нь харагдаж байна. Эдгээрийг нэгтгэн дүгнэвэл ахмад настны амьжиргаанд мэргэшлийн нөөц голлох нөлөөг үзүүлж байна.

Харин ахмадуудын хувьд гэр бүлийн байдал нь тэдний амьжиргааны түвшинд нөлөөлж буй нэг чухал хүчин зүйл бөгөөд амьжиргааны дунд ба түүнээс дээш түвшинд амьдарч буй хүмүүсийн дунд гэрлэсэн хүмүүсийн тоо нөгөө хоёр бүлэгтэй харьцуулахад илүү өндөр байгаа бол амьжиргааны доод түвшинд хамаарч буй хүмүүсийн дунд бэлвэсэн болон салсан хүмүүсийн тоо илүү байна.

Тэтгэврээ тогтоолгосны дараа ч ямар нэгэн байдлаар ажил эрхэлж байгаа ахмадуудын амьжиргааны түвшин дунд ба түүнээс дээш буюу 44.4 хувь байгаа нь бусад нөгөө хоёр бүлгээс ойролцоогоор хоёр дахин өндөр байна. Энэ нь тэтгэвэрт гарснаар огт ажилд орох боломжгүй болсон ахмадууд амьжиргааны доод түвшинд хамаарч буй байдал нь бусад бүлгээс ойролцоогоор 3.5 дахин өндөр байна. Түүнчлэн ахмадуудын амьжиргааны түвшин буурах тутам ирээдүйд итгэх итгэл нь алдарч байгаа нь судалгааны дүнгээс харагдсан. Энэ нь ахмадуудын хөдөлмөр эрхлэх хязгаарлагдмал боломж нь тэдний амьжиргаанд нөлөөлж буй гол эрсдэл болж хэмээн дүгнэж болохоор байна.

Судалгааны хүрээнд ахмадуудын өмнө тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлох оролдлогыг хийсэн бөгөөд ерөнхийлөн бүлэглэвэл, тэтгэврийн хэмжээ, хүрэлцээ бага тул түүнийг нэмэгдүүлэх, эрүүл мэнд халамжийн үйлчилгээг сайжруулах, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах зэрэг шалтгаан тэргүүлж байна. Иймд цаашид амьжиргаанд нөлөөлөх эрсдэлийг бууруулах, бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх замаар орлогын баталгаат байдлыг хангах, улмаар нэн шаардлагатай төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарах шаардлагатай байна.

***Ном зүй***


1. Жасрай П, (1997). Эдийн засгийн мэдээлэл, шинжилгээ. ШУА., Улаанбаатар, Монгол Улс
2. Куприянова Т, (n.d.). Пожилой человек, его проблемы и их решение. Retrieved from fotoriter.ru.
3. Намжил Т, (2004). Монгол гэр бүлийн харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал. «Соёмбо принтинг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс
4. Тихонова Н.Е, (2014). Социальная структура Россий: теорий и реальность. РАН. ИС,: Новый хронограф.
5. ҮСГ, ДБ, НҮБХХ, (2004). Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгааны үндсэн тайлан. Улаанбаатар, Монгол Улс
6. ҮСХ. (2018). Монгол Улсын статистикийн эмхэтгэл. «Мөнхийн үсэг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс
7. ФСЭЗХ. (2001). Нийгмийн шинэчлэл: амьдралын хэв маягийн өөрчлөлт. «Бэмби сан» ХХК. Улаанбаатар, Монгол
8. Чулуунбаатар Г, (2008). XX - XXI зууны зааг үеийн монголын нийгэм, иргэншлийн өөрчлөлт. «Сансудай» ХХК. Улаанбаатар, Монгол Улс
9. Бурдье П, (1993). Улс төрийн социологи.
10. Гидденс А. (2006). Социологи. Ред. Ганхуяг Д. МУИС. «Адмон принтинг» ХХК. Улаанбаатар, Монгол Улс